



МОНГОЛ-ЯПОН УЛСЫН НҮҮРСТӨРӨГЧ  
БАГАТАЙ ХӨГЖЛИЙН ТҮНШЛЭЛ

---

# ХАМТАРСАН КРЕДИТ ОЛГОХ МЕХАНИЗМЫН ГАРЫН АВЛАГА

2021 он





БАЙГАЛЬ ОРЧИН,  
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



Ministry of the Environment

МОНГОЛ-ЯПОН УЛСЫН НҮҮРСТӨРӨГЧ  
БАГАТАЙ ХӨГЖЛИЙН ТҮНШЛЭЛ

# ХАМТАРСАН КРЕДИТ ОЛГОХ МЕХАНИЗМЫН ГАРЫН АВЛАГА



**АНГЛИ ХЭЛ ДЭЭР ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Л.ОТГОНЦЭЦЭГ	Уур Амьсгалын Өөрчлөлтийн Судалгаа, Хамтын Ажиллагааны Төв, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
М.ТЭМҮҮЛЭН	Уур Амьсгал, Эрчим Хүчний Алба, Даян Дэлхийн Байгаль Орчны Стратеги Судлалын Хүрээлэн
КЕНТАРО Такахаши	Уур Амьсгал, Эрчим Хүчний Алба, Даян Дэлхийн Байгаль Орчны Стратеги Судлалын Хүрээлэн
САТОРУ Танго	Даян Дэлхийн Байгаль Орчны Хамтын Ажиллагааны Төв

**МОНГОЛ ХЭЛ ДЭЭР ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:**

Л.ОТГОНЦЭЦЭГ	Уур Амьсгалын Өөрчлөлтийн Судалгаа, Хамтын Ажиллагааны Төв, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
--------------	---

**АНГЛИ ХЭЛНЭЭС МОНГОЛ ХЭЛ РҮҮ ХӨРВҮҮЛСЭН:** Э.САРУУЛ

**МОНГОЛ ХЭЛНЭЭС АНГЛИ ХЭЛ РҮҮ ХӨРВҮҮЛСЭН:** Б.ГАНЧИМЭГ

---

Энэхүү гарын авлага нь Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ын талаар дэлгэрэнгүй, ойлгоход хялбар аргаар тайлбарласан мэдээллийг өгөх зорилготой бөгөөд олон улсын хэлэлцээрт тохиролцсоны дагуу бүх текстийг яг тэр хэлбэрээр нь хуулбарлаагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Түүнчлэн, дэлгэрэнгүй тайлбар болон үйл явцын талаар олон улсын хэлэлцээрт хараахан эцэслэн шийдвэрлэгдээгүй асуудлууд байгаа. Текстүүдийн дэлгэрэнгүй агуулга, тохирсон тодорхойлолтуудыг ХКОМ-ын цахим хуудсанд <https://www.jcm.go.jp>, <http://gec.jp>, <http://www.jcm-mongolia.com/>, байгаа холбогдох бичиг баримтаас үзнэ үү.

Мөн гарын авлагад орж буй агуулга, санхүүгийн мэдээлэл нь Япон улсын санхүүгийн жилтэй уялдуулан жил бүр өөрчлөгдөж болно гэдгийг анхаарна уу.

Энэхүү гарын авлагатай холбоотой тодруулах зүйл байвал [jcmmongolia@gmail.com](mailto:jcmmongolia@gmail.com), [ce-info@iges.or.jp](mailto:ce-info@iges.or.jp). э-шуудангаар холбогдоно уу.

*Нүүр зургийн эх сурвалж: “БӨХӨГ” 15 МВт нарны цахилгаан станц,  
Төв аймгийн Сэргэлэн сум*

# АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ.....	9
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР.....	11
ЗУРАГ, ХҮСНЭГТ, ТАЙЛБАРЫН ЖАГСААЛТ .....	12
БҮЛЭГ 1. ХКОМ-ЫН ТАНИЛЦУУЛГА .....	13
БҮЛЭГ 2. МОНГОЛ-ЯПОН УЛСЫН НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ ХӨГЖЛИЙН ТҮНШЛЭЛ .....	17
2.1. Хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцоолох ойлголт.....	19
2.2. ХКОМ-ын бүртгэлийн систем .....	20
2.3. ХКОМ-ын хамрах хүрээ .....	20
БҮЛЭГ 3. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО .....	23
3.1 Хамтарсан хороо .....	24
3.2 Нарийн бичгийн газар.....	25
3.3 Төсөлд оролцогч талууд .....	25
3.4 Хөндлөнгийн магадлагаа, нотолгоо хийх байгууллага.....	25
БҮЛЭГ 4. САНХҮҮГИЙН СХЕМ.....	27
4.1 Загвар төсөл .....	29
4.2 ХКОМ-ын Эко түрээсийн схемийн төсөл.....	30
4.3 Хамтарсан инновацийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нүүрстөрөгч бага бүхий технологийг үзүүлэх төсөл .....	30
4.4 АХБ-ны ХКОМ-ыг дэмжих Япон сан .....	31
4.5 Үзүүлэх төсөл .....	35
4.6 Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа.....	36

**БҮЛЭГ 5.****ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСӨЛД САНАЛ ИРҮҮЛЭХ****ДЭЛГЭРЭНГҮЙ ЗААВАРЧИЛГАА ..... 37**

5.1	ЗОРИЛГО .....	38
5.2	ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА.....	38
5.2.1	Эрх бүхий төслүүд.....	40
5.2.2	Тэргүүлэх зорилтот орнууд.....	41
5.2.3	Хэн оролцох эрхтэй вэ?.....	41
5.2.4	Олон улсын консорциумын гишүүдэд тавигдах шаардлага .....	42
5.2.5	Санхүүжилтэнд хамрагдах зардал.....	45
5.2.6	Санхүүжилтийн хэмжээ .....	46
5.2.7	Санхүүжилтийн дээд хэмжээ.....	47
5.2.8	Загвар төслийг хэрэгжүүлэх хугацаа .....	47
5.2.9	Төлөвлөгөө/Хуваарь.....	47
5.3	ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭ .....	49
5.3.1	Загвар төслийн сонгон шалгаруулалт.....	49
5.3.2	Төслүүдийг сонгон шалгаруулах журам .....	50
5.3.3	Сонгогдсон загвар төслүүдийг мэдээлэх .....	50
5.4	СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДАРААХ ҮЕ ШАТ.....	50
5.4.1	Санхүүгийн гэрээний өргөдөл/хүсэлт .....	50
5.4.2	Санхүүгийн гэрээ хийх .....	50
5.4.3	Загвар төслийг эхлүүлэхэд анхаарах зүйлс.....	51
5.4.4	Төслийн санхүүжилт болон хэрэгжилтийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах.....	51
5.4.5	Зардал/Өртөг .....	52
5.4.6	Тайлангын бүрдүүлэлт болон холбогдох хянан шалгалт.....	52
5.4.7	Санхүүжилт олгох.....	53
5.4.8	Худалдан авсан хөрөнгийн менежмент .....	53
5.4.9	Олон улсын консорциумын гишүүдэд өөрчлөлт орох.....	54
5.4.10	Санхүүжилтын гэрээг цуцлах.....	54
5.4.11	Шударга бус үйл ажиллагаатай холбоотой торгууль.....	54

5.5 ТӨСЛИЙН САНАЛЫГ ИЛГЭЭХ.....	55
5.5.1 Саналыг хэрхэн илгээх вэ?.....	55
5.5.2 Саналыг илгээх хугацаа.....	55
5.5.3 Бүрдүүлэх материал.....	55
5.5.4 Саналыг хүргүүлэх хаяг.....	57
5.5.5 Асуулт, хариулт.....	57
5.5.6 ХКОМ-ын схемээс хамтарсан инновацийн санхүүжилтийн хөтөлбөрт шилжих.....	57
5.6 МЭДЭЭЛЛИЙН ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ.....	58
5.7 ТЭМДЭГЛЭЛ.....	58
5.7.1 Загвар төслийн танилцуулга.....	58
5.7.2 Бусад.....	58
5.8 ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	58
5.8.1 Танилцуулга.....	58
5.8.2 Загвар төслийн зорилго.....	59
5.8.3 Шалгуурын тойм.....	59
<b>БҮЛЭГ 6.</b>	
<b>ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ .....</b>	<b>67</b>
6.1 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО “АЛСЫН ХАРАА - 2050” .....	66
6.2 МОНГОЛ УЛС ДАХ ХКОМ-ЫН ДҮРЭМ, ЖУРМЫН ДАГУУ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДАМЖ.....	67
6.3 ХКОМ-ЫН ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР .....	79
6.4 ХКОМ-ЫН ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН УДИРДАМЖ .....	83
6.4.1 Зорилго.....	83
6.4.2 Жендерийн эрх тэгш байдлын ерөнхий зарчим .....	83
6.4.3 ХКОМ-ын загвар төслийн үе шат бүрт жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллах зөвлөмж.....	84

ДҮГНЭЛТ .....	86
АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД .....	89
<b>ХАВСРАЛТ I</b>	
<b>ХКОМ-ЫН ӨРГӨДЛИЙН ЗАГВАРУУД .....</b>	<b>93</b>
1. Олон улсын Консорциум байгуулах тухай гэрээ (Жишээ: ХКОМ-ын Загвар төсөл болон Эко түрээсийн схемийн төсөл) .....	94
2. ХКОМ-ын Загвар төслийн саналын тэмдэглэл (Маягт № 36) .....	98
3. ХКОМ-ын Кредитийг хуваах тухай гэрээ (Маягт № 5 ХКОМ-ын Загвар төсөл болон Эко түрээсийн схемийн төсөл) .....	99
<b>ХАВСРАЛТ II</b>	
<b>ХКОМ-ЫН МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСЛҮҮДИЙН МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>101</b>
<b>ХАВСРАЛТ III</b>	
Улс тус бүрийн хэрэгжүүлж буй ХКОМ-ын Загвар төслийн тоо, ашиглаж буй технологийн ангилал .....	107



## ӨМНӨХ ҮГ

Олон улсын аливаа гэрээ, хэлэлцээр тавьсан зорилгоосоо үл хамааран хэрэгжүүлэх хангалттай сайн механизм бүрдээгүй бол амжилттай хэрэгжих боломжгүй бөгөөд зохих механизмыг хөгжүүлэх нь зөвхөн техникийн төдийгүй тодорхой бодлогын шийдвэр, хууль эрх зүйн асуудлыг хамарсан цогц үйл ажиллагаа байдаг. НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБУАӨСК)-ыг 1992 онд Рио-де-Жанейро хотод чуулсан Байгаль орчны хөгжлийн асуудлаарх НҮБ-ын бага хурлын үеэр дэлхийн улс орнуудын төр, засгийн удирдагчид хамтран баталсан. НҮБУАӨСК нь Киотогийн протоколыг 5 жилийн хугацаа зарцуулан 1997 онд батлуулсны дараагаар түүнийг Конвенцын албан ёсны баримт бичиг болгоход дахин 8 жилийн хугацаа зарцуулсан байдаг.

Киотогийн протоколд Цэвэр Хөгжлийн Механизм (ЦХМ), Хамтарсан Хэрэгжилт гэх мэт механизмууд багтсан байдаг хэдий ч Киотогийн протокол нь зөвхөн үйлдвэржсэн, хөгжингүй орнуудад чиглэсэн учраас төсөөлж байсан шиг амжилтанд хүрч чадаагүй. Нөгөө талаас Киотогийн механизмуудад олон төрлийн хамтын ажиллагааг тусгаагүй байсан юм.

Харин Парисын Хэлэлцээр нь богино хугацаанд хүчин төгөлдөр болсон төдийгүй Киотогийн протоколтой харьцуулахад өөр төрлийн буюу нүүрстөрөгчийн зах зээлийн механизмын нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн юм. Бүх улс орнууд, түүний дотор Хөгжиж буй орнууд өөрсдийн Үндэсний Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮТХН) баримт бичгээрээ дамжуулан тодорхой үүрэг хүлээж амлалтыг авцгаасан. Парисын Хэлэлцээрийн шийдвэр нь хэлэлцээрт нэгдсэн улс орнуудаас Цэвэр хөгжлийн механизм, Хамтарсан Хэрэгжилт болон олон улсын хүлэмжийн хийн ялгарлыг худалдаалах туршлагад түшиглэсэн шинэ механизмыг бий болгохыг тусгайлан дэмжихийг зорьсон байна.

Шинэ төрлийн хамтын ажиллагаанд суурилсан механизмыг бий болгохын тулд хэдхэдэн санаачлага гарсны нэг нь Япон улсын Засгийн газрын санаачилсан Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ). ХКОМ нь Киотогийн протоколын механизмуудтай зэрэгцэн хөгжиж байгаа ч олон улсын төвлөрсөн тогтолцоо болох Киотогийн протоколтой харьцуулахад улс орнуудын дотоод, гадаад хоёр талт хамтын ажиллагаанд суурилсан зах зээлийн механизмыг хөгжүүлж, илүү энгийн, практик дээр хэрэгжих бүрэн боломжтой нүүрстөрөгчийн зах зээлийн хөгжлийн нэг хэсэг болж байна.

Нүүрстөрөгчийн зах зээлийн механизмын дийлэнх нь хүлэмжийн хийн ялгарлын бууралтаа арилжаалах төрлийн байсан бол ХКОМ нь суурь ялгаралтай харьцуулсан байдлаар бодитоор кредит тооцох арга барилаараа

ялгардаг. Мөн дараагийн НҮБУАӨСК-ын Талуудын бага хурлаар Парисын Хэлэлцээрийн 6 дугаар зүйлийн дүрмийн номыг эцэслэн баталсны дараа ХКОМ-ын кредитийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээний олон улсын үр дүнд шилжүүлэн ашиглах боломж бүрдэнэ. Үүнтэй холбогдуулан төсөл хэрэгжүүлэгч улс нь өөрийн хэрэгцээ, нөхцөл байдалд тохирсон тодорхой хэмжээний төсвийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагаандаа зарцуулах боломжтой.

ХКОМ нь хоёр орны Хамтарсан Хорооноос албажуулсан дүрэм журам, удирдамжийг мөрдлөг болгон бодит үйл ажиллагаан дээр суурилсан механизм бөгөөд судалгаанд суурилсан аргазүй, байгаль орчны асуудлуудыг цогцоор шийдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор Япон улсын Засгийн газраас Монгол улс болон бусад улс орнуудтай хамтран 2013 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

ХКОМ нь төсөлд суурилсан, хоёр талын хүлэмжийн хийн ялгарлыг дүйцүүлэн бууруулах механизм бөгөөд одоогоор түншлэгч 17 орнуудад 186 төсөл хэрэгжиж байна.

Монгол-Япон улсын Засгийн газар хооронд “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл” байгуулах тухай баримт бичигт 2013 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр гарын үсэг зурснаар Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ыг хэрэгжүүлэхэд хоёр улс хамтран ажиллах боломж нээгдсэн юм.

Энэхүү ХКОМ-ын хамтын ажиллагааны хүрээнд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ, эрчим хүчний хэмнэлт, халаалтын асуудлыг шийдэхтэй холбоотой хэд хэдэн төслийг хэрэгжүүлж байна. Эдгээр төслүүд нь сэргээгдэх эрчим хүчийг ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулалт хийж, технологи дамжуулалт, чадавх бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжсээр ирсэн.

Цаашлаад төслүүд нь хүлэмжийн хийг бууруулах зорилт болон кредит хуваах асуудлууд дээр нэмээд үйл ажиллагааны нийлмэл өгөөж, давхар үр ашгийн үр дүнгээр дамжуулан тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулахад ихээхэн анхаарч ажиллах байна. Монгол улсад төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд ХКОМ-ын хүрээнд үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдэж байгаа учир энэхүү гарын авлага баримт бичгийг дотоод, гадаадын түншүүд, төсөл хэрэгжүүлэгч талуудад зориулан Монгол дах ХКОМ-ын нарийн бичгийн газраас эрхлэн боловсруулж гаргав.



ХКОМ-ын Хамтарсан Хорооны Монгол талын дарга Др. Замбын Батжаргал

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

<b>ХХ</b>	Хамтарсан Хороо
<b>ХКОМ</b>	Хамтарсан Кредит Олгох Механизм
<b>ЦХМ</b>	Цэвэр Хөгжлийн Механизм
<b>БОАЖЯ</b>	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам
<b>ЯБОЯ</b>	Япон Улсын Байгаль Орчны Яам
<b>NEDO</b>	Шинэ Эрчим Хүч, Аж Үйлдвэрийн Технологийн Хөгжлийн Байгууллага
<b>АХБ</b>	Азийн Хөгжлийн Банк
<b>ЖАЙКА</b>	Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага
<b>ДДБОТС</b>	Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Сан
<b>ДДБОССХ</b>	Даян Дэлхийн Байгаль Орчин Стратеги Судлалын Хүрээлэн
<b>АХБЯС</b>	Азийн Хөгжлийн Банкны Япон Сан
<b>НҮБУАӨСК</b>	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Уур Амьсгалын Өөрчлөлтийн Суурь Конвенц
<b>DMC's</b>	АХБ-ны Хөгжиж буй Гишүүн Орнууд
<b>ТХЗ</b>	Тогтвортой Хөгжлийн Зорилт
<b>ХүХ</b>	Хүлэмжийн хий
<b>СО<sub>2</sub></b>	Нүүрстөрөгчийн давхар исэл
<b>ЯББ</b>	Ялгарлын Баталгаажсан Бууралт
<b>ХТН</b>	Хэмжих, тайлагнах, нотлох
<b>ТББ</b>	Төслийн Баримт Бичиг
<b>ТХТ</b>	Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө
<b>ТХТа</b>	Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайлан
<b>ГТЭ</b>	Гуравдагч Талын Этгээд

## ЗУРАГ, ХҮСНЭГТ, ТАЙЛБАРЫН ЖАГСААЛТ

Зураг 1.	ХКОМ-ын түнш орнууд .....	13
Зураг 2.	ХКОМ-ын схем .....	16
Зураг 3.	Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын тооцоолол .....	17
Зураг 4.	Оролцогч талууд .....	22
Хүснэгт 1.	ХКОМ-ын Загвар төслийн санхүүгийн дэмжлэгийн харьцуулсан байдал .....	26
Хүснэгт 2.	Японы Байгаль орчны яам дэмжлэгтэй Загвар төсөл, Эко түрээсийн схем, АХБ-ны дэмжлэгтэй АХБЯС харьцуулалт ...	30
Хүснэгт 3.	Тухайн улсын ижил төстэй төслийн тооноос хамаарах санхүүжилтийн хувь хэмжээ .....	44
Хүснэгт 4.	Санхүүгийн жилийн төлөвлөгөө/хуваарь.....	45
Хүснэгт 5.	Тогтвортой хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний маягт.....	64
Хүснэгт 6.	Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөний Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах боломжит хувь нэмэр .....	67
Хүснэгт 7.	Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайлангийн маягт.....	70
Хүснэгт 8.	Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах хувь нэмрийн тайлангийн Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн маягт.....	72
Хүснэгт 9.	Солар фарм төслийн ТХЗ-д оруулсан хувь нэмэр.....	77
Хүснэгт 10.	Да нанг хотын усны системийг сайжруулах төсөл.....	78
Тайлбар 1.	ХКОМ-ыг хэрэгжүүлэх боломжтой салбарууд .....	19
Тайлбар 2.	Санхүүжилтэнд хамрагдах боломжтой зардлууд.....	43
Тайлбар 3.	Санхүүжилтэнд хамрагдах боломжгүй зардлууд .....	43
Тайлбар 4.	Төсөл хүлээн авах хугацаа .....	51
Тайлбар 5.	Алсын хараа баримт бичгийн 9 зорилго.....	62
Тайлбар 6.	ХКОМ-ын ТХЗ-д оруулж буй 12 хувь нэмэр.....	75

# БҮЛЭГ 1

## ХКОМ-ЫН ТАНИЛЦУУЛГА

Хамтарсан кредит олгох механизм (ХКОМ) нь Япон болон түнш улс, орнуудын хооронд хүлэмжийн хий бага ялгаруулдаг дэвшилтэт техник, технологи, бүтээгдэхүүн, систем, үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх болон хөгжиж буй улс, орнуудын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах хоёр талт хамтын ажиллагааны түншлэл юм. Хүлэмжийн хийн ялгарлын бууралт болон шингээлтийг хэмжих, тайлагнах, нотлох аргыг ашиглан тоон үзүүлэлтээр үнэлэн талууд хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах зорилтдоо ашиглана. Тиймээс ХКОМ-ийг Парисын Хэлэлцээрийн 6.2-р зүйлийг хэрэгжүүлэх хамгийн боломжит, бодит загвар гэдгийг хүлээн зөвшөөрөөд байгаа билээ.

Дэлхийн улс үндэстэн “температурын өсөлтийг аж үйлдвэржилтийн өмнөх түвшнээс Цельсийн 2 хэмээс бага байлгах, температурын өсөлтийг 1.5 хэм хүртэл хязгаарлах хүчин чармайлт гаргах” зорилготой Парисын Хэлэлцээрийг<sup>1</sup> 2015 онд баталсан. Энэхүү урт хугацааны зорилгод хүрэхэд хувь нэмэр оруулах олон улсын зах зээлийн механизмыг Парисын Хэлэлцээрийн 6 дугаар зүйлээр зохицуулна. Тухайлбал, Парисын Хэлэлцээрийн 6.2 дугаар зүйлд улс орон бүрийн Үндэсний Хэмжээнд Тодорхойлсон Хувь Нэмэр (ҮХТХН)-ийн хэрэгжилтийг хангахын тулд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтын үр дүнд түшиглэн хамтарсан арга хэмжээ авах гэж заасан байдаг.

Хамтарсан Кредит Олгох Механизм<sup>2</sup> (ХКОМ) нь Япон болон түнш улс, орнуудын хооронд хүлэмжийн хий бага ялгаруулдаг дэвшилтэт техник, технологи, бүтээгдэхүүн, систем, үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх болон хөгжиж буй улс орнуудын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах хоёр талт хамтын ажиллагааны түншлэл юм. ХКОМ-ын хувьд хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) бууралт болон шингээлтийг хэмжих, тайлагнах, нотлох (ХТН) аргыг ашиглан тоон үзүүлэлтээр үнэлдэг ба Япон улсын болон түнш улсын хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах зорилтдоо ашиглана. Тиймээс ХКОМ-ийг Парисын Хэлэлцээрийн 6.2-р зүйлийг хэрэгжүүлэх хамгийн боломжит, бодит загвар гэдгийг хүлээн зөвшөөрөөд байгаа билээ.

2021 оны байдлаар ХКОМ-ыг хэрэгжүүлэхээр 17 улс Япон улстай хоёр талын түншлэлд гарын үсэг зураад байна (Зураг 1). Монгол улс 2013 оны 1 дүгээр сард Япон улстай ХКОМ-ын хоёр талт хамтын ажиллагааг эхлүүлсэн анхны түнш орон болсон. Одоогийн байдлаар ХКОМ-ын төслөөр дамжуулан нарны цахилгаан үүсгүүр, эрчим хүчний хэмнэлттэй технологи, эко хөтөч технологи, өндөр үр ашигтай хөргүүрийн систем, метан шингээлтийн технологи зэрэг олон төрлийн технологүүдийг түнш орнуудад нэвтрүүлээд байна.

ХКОМ нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБУАӨСК)-ын зорилтод хувь нэмэр оруулаад зогсохгүй Тогтвортой Хөгжлийн Зорилтод<sup>3</sup> (ТХЗ)-д хувь нэмэр оруулна. ХКОМ-ын удирдамжинд улс орнууд болон бүс нутгуудад ТХЗ-ын үйл ажиллагааг нэгэн зэрэг сурталчлах боломжийг олгосноор ХКОМ нь дэлхийн түвшинд түншлэлийг бэхжүүлэн “хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжилд” хувь

1 UN, N. U. (2015). The Paris Agreement. Retrieved Feb 15, 2021, from [www.unfccc.int: https://unfccc.int/process-and-meetings/the-paris-agreement/the-paris-agreement](https://unfccc.int/process-and-meetings/the-paris-agreement/the-paris-agreement)

2 MOEJ. (2021). About the Mechanism: Basic concept of JCM. Retrieved Feb 15, 2021, from [www.jcm.go.jp: https://www.jcm.go.jp/about](http://www.jcm.go.jp/about)

3 UN, U. N. (2015). The Sustainable Development Goals, Retrieved Feb 2021, from [https://sdgs.un.org: https://sdgs.un.org/goals](https://sdgs.un.org/goals)

нэмэр оруулна гэсэн байна. 2015 онд олон улсад ТХЗ-уудыг багтаасан “Тогтвортой хөгжил-2030 хөтөлбөр”<sup>4</sup> (Хөтөлбөр 2030)-ийг баталсан. ТХЗ нь нийгмийн тогтвортой хөгжлийг харуулсан бүх нийтийн төлөвлөгөө бөгөөд 17 зорилго, 169 зорилтоос бүрдэнэ. ХКОМ-аар дамжуулан сэргээгдэх эрчим хүч болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх технологийг нэвтрүүлснээр хүлэмжийн хийн ялгарлыг шууд бууруулах боломжтой ба түнш орнуудтай харилцаа холбоогоо бэхжүүлж, төслийг хэрэгжүүлэх техникийн чадавхийг дээшлүүлж, мөн улс орнуудын тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээг дэмжихэд нэмэр болно.

Монгол улсын Засгийн газраас 2020 оны 12 дугаар сард урт хугацааны бодлого болох “Алсын хараа 2050”<sup>5</sup> баримт бичгийг уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах Парисын Хэлэлцээр болон “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”-тай уялдуулан баталсан бөгөөд тогтвортой хөгжлийг сайжруулах, эрчим хүч, аж үйлдвэрийн бүх салбаруудад нүүрстөрөгч бага бүхий технологийг нэмэгдүүлэхээр тусгасан байна. Иймээс, ХКОМ нь Монгол улсын тогтвортой, ногоон хөгжлийг дэмжих боломжит арга хэрэгсэл бөгөөд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтдоо хүрэхэд хувь нэмэр оруулах юм.



Зураг 1. ХКОМ-ын түнш орнууд (Эх сурвалж: ДДБОТС)

4 UN, U. N. (2015, Sep 25). Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development. Retrieved from [https://sdgs.un.org: https://www.un.org/ga/search/view\\_doc.asp?symbol=A/RES/70/1&Lang=E](https://sdgs.un.org: https://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/70/1&Lang=E)

5 МУЗГ, М. У. (2020). Алсын хараа-2050. Улаанбаатар. Retrieved from <http://nda.gov.mn/1107.html>





# БҮЛЭГ 2

## МОНГОЛ-ЯПОН УЛСЫН НҮҮРСТӨРӨГЧ БАГАТАЙ ХӨГЖЛИЙН ТҮНШЛЭЛ

- 2.1. Хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцоолох  
ойлголт
- 2.2. ХКОМ-ын бүртгэлийн систем
- 2.3. ХКОМ-ын хамрах хүрээ

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр Монгол-Япон улсын Засгийн газар хооронд “Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл”<sup>6</sup> байгуулах тухай баримт бичигт 2013 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр гарын үсэг зурснаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэг, улс орнуудын хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх зорилготой Хамтарсан Кредит Олгох Механизм (ХКОМ)-ыг хэрэгжүүлэхэд хоёр улс хамтран ажиллах боломж нээгдэн энэ чиглэлийн хамтын ажиллагаа амжилттай хэрэгжиж байна (Зураг 2).

Монгол улс одоогоор НҮБУАӨСК-ын хүрээнд 2015 оны Парисын Хэлэлцээрт оруулах Монгол улсын хувь нэмрийн баримт бичигтээ тусгасан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр нийт хүлэмжийн хийн ялгарлаа 2030 он гэхэд эдийн засгийн хөгжил өнөөгийн жишгээр явна гэж тооцсон үзүүлэлттэй харьцуулахад 22.7 хувьд бууруулах зорилтыг Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн бичиг баримт (ҮТХН)-даа тусгасан байна. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт, технологи, чадавх шаардагдах бөгөөд Хамтарсан Кредит Олгох Механизмыг санхүүжилтийн боломжит эх үүсвэр гэж үзсэн байдаг.



Зураг 2. ХКОМ-ын ерөнхий схем


6 Mongolia-Japan, M. M. (2013, Jan 8). Low Carbon Development Partnership between the Japanese side and the Mongolian side. Retrieved from <http://www.jcm-mongolia.com/>: [http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM\\_MN\\_bilateral\\_document.pdf](http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM_MN_bilateral_document.pdf)

Манай улс ХКОМ-ын хүрээнд хэрэгжиж буй төслүүдийн үр дүнд бий болсон хүлэмжийн хийн ялгарлын баталгаажсан бууралт болон шингээлтийг тоон үзүүлэлтээр кредит болгон тооцоолон олон улсын хэмжээнд хүлээсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтдоо тооцуулах боломж бүрдэнэ. Ийм байдлаар Япон улс болон Монгол улс ХКОМ-ын кредитээ хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтдоо ашиглах боломжтой юм.

Монгол, Япон улсын Засгийн газар ХКОМ-ыг амжилттай хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн болон техник технологийн чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллаж байна. Энэхүү түншлэлийн хамтын ажиллагаа одоогийн байдлаар 2030 он хүртэл хугацаанд үргэлжлэх хэдий ч хоёр тал дээр дурдсан хугацаа дуусахаас өмнө сунгах талаар үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

## 2.1 ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫН БУУРАЛТЫГ ТООЦООЛОХ ОЙЛГОЛТ<sup>7</sup>

ХКОМ-ыг практик дээр энгийн байлгахыг зорьж байгаа бөгөөд аргачлал, дүрэм журам, удирдамжаа найдвартай, ил тод, мөн хүрээлэн буй орчны бүрэн бүтэн байдлыг хадгалах зэргийг харгалзан боловсруулсан болно. ХКОМ-ын хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг “жишиг ялгарал” болон “төслийн ялгарал”-ын зөрүүгээр тодорхойлно. Жишиг ялгарлын хэмжээг суурь сценар (BaU) буюу одоогийн байгаа түвшнээс доогуур тооцоолсон ялгарлын хэмжээгээр тогтоодог.



Зураг 3. Хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцоолох (Эх сурвалж: ДДБОТС)

<sup>7</sup> IGES, I. f. (2018, Dec). JCM in Charts for Mongolia 2018. Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar: Environment and Climate Fund. Retrieved Jan 2021, from [www.jcm-mongolia.com](http://www.jcm-mongolia.com): [http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM-in-CHARTS-for-Mongolia\\_ver3\\_EN-3.pdf](http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM-in-CHARTS-for-Mongolia_ver3_EN-3.pdf)

## 2.2 ХКОМ-ЫН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлийн олон талт, хоёр талт хамтын ажиллагааны механизмууд нь ялгарлын бууралтын үр дүнд бий болсон кредитийг давхар тоологдох, давхар санхүүжилт авах зэргээс сэргийлсэн бүртгэлийн системтэй<sup>8</sup> байдаг. Хамтарсан Кредит Олгох Механизм нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, ялгарлын бууралтаа тоон үзүүлэлтэд хөрвүүлэн кредитийг бий болгох хоёр талын буюу хамтарсан механизм бөгөөд олгогдсон кредитийг тал тус бүр өөрийн ялгарлыг бууруулах зорилгоо биелүүлэхдээ ашиглана. Ийм учраас ХКОМ-ыг хэрэгжүүлж буй улсууд төслийн үр дүнд бий болсон кредитээ давхар тоологдохоос сэргийлсэн, дахин давтагдахгүй сериал дугаар бүхий систем үүсгэн бүртгэлжүүлдэг. ХКОМ-ын бүртгэлийн систем нь төслийн үр дүнд бий болсон кредитийг бүртгэж авах, шилжүүлэх, худалдан авах, тооцуулах, цуцлах болон хаагдсан кредитийн бүртгэлийг баталгаажуулах зорилгоор боловсруулсан систем юм.

## 2.3 ХКОМ-ЫН ХАМРАХ ХҮРЭЭ

ХКОМ-ын хэрэгжилтийн хамрах хүрээ<sup>9</sup> нь ХКОМ-ын хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнд бий болсон хүлэмжийн хийн ялгарлын бууралтын кредит олгохтой холбоотой. Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын кредит нь ХКОМ-ын төслийн хүрээнд дэвшилтэт технологийг ашиглан амжилттай бууруулсан нүүрстөрөгчийн хэмжээ юм. ХКОМ-ын гэрээ хэлэлцээрийн хүрээнд боловсруулсан хүлэмжийн хийн ялгарлын бууралтын кредит нь үл худалдаалагдах хэлбэрээр тусгагдсан хэдий ч хоёр улсын Засгийн газар цаашид энэхүү механизмыг олон улсад худалдаалагдах боломжтой хэлбэрт шилжүүлэхэд хэлэлцсээр байх болно.

ХКОМ-ын арга хэмжээний үр дүнд бий болсон кредит нь ХКОМ-ын төслийн хэрэгжилтийн явцад бууруулсан хүлэмжийн хийн ялгарлын бууралт юм.

Нүүрстөрөгчийн давхар исэл (CO<sub>2</sub>), Метан (CH<sub>4</sub>), Азотлог исэл (N<sub>2</sub>O), Фторт нүүрстөрөгч (HFC), перфторт нүүрстөрөгч (PFCs), 6 Фторт хүхэр (SF<sub>6</sub>), 3 фторт азот (NF<sub>3</sub>) төрлийн хүлэмжийн хийн ялгарлууд нь ХКОМ-ын төслийн хүрээнд бууруулж болох ялгарлууд гэж ойлгож болно.

8 MOEJ, M. o. (2016, Jul 30). JCM Rules and Guidelines. [https://www.jcm.go.jp/mn-jp/rules\\_and\\_guidelines](https://www.jcm.go.jp/mn-jp/rules_and_guidelines). Retrieved Jan 2021. from <https://www.jcm.go.jp/>:

[https://www.jcm.go.jp/opt/mn-jp/rules\\_and\\_guidelines/download/JCM\\_MN\\_Spec\\_Registry\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/opt/mn-jp/rules_and_guidelines/download/JCM_MN_Spec_Registry_ver01.0.pdf)

9 MOEJ, M. o. (2018, Nov 06). JCM Rules and Guidelines. Retrieved Jan 2021. <https://www.jcm.go.jp>: Sector Scope:

[https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_05/JCM\\_MN\\_GL\\_PM\\_ver02.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_05/JCM_MN_GL_PM_ver02.0.pdf)

Gas coverage: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_01/JCM\\_MN\\_Rol\\_ver04.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_01/JCM_MN_Rol_ver04.0.pdf)

**Тайлбар 1.****ХКОМ-ыг хэрэгжүүлэх боломжтой салбарууд**

ХКОМ-ын төслүүдийг дараах 15 салбарт хэрэгжүүлэх боломжтой.

1. Эрчим хүчний салбар (сэргээгдэх/үл сэргээгдэх эх үүсвэр);
2. Эрчим хүч түгээлт;
3. Эрчим хүчний эрэлт хэрэгцээ;
4. Аж үйлдвэр;
5. Химийн салбар;
6. Барилга;
7. Тээвэр;
8. Уул уурхай/ашигт малтмалын үйлдвэрлэл;
9. Метал үйлдвэрлэл;
10. Түлш (хатуу, шингэн, хий) олборлох үеийн дэгдэмхий ялгаралт;
11. Галокарбон, гексафторт нүүрстөрөгчийг хэрэглэх, үйлдвэрлэх үеийн дэгдэмхий ялгаралт;
12. Уусгагчийн хэрэглээ;
13. Хог хаягдал боловсруулах, зайлуулах;
14. Ойжуулалт, нөхөн сэргээлт;
15. Хөдөө аж ахуй.



# БҮЛЭГ 3

## ХКОМ-ЫН ОРОЛЦОГЧ ТАЛУУД

- 3.1 Хамтарсан хороо
- 3.2 Нарийн бичгийн газар
- 3.3 Төсөлд оролцогч талууд
- 3.4 Хөндлөнгийн магадлагаа, нотолгоо хийх байгууллага

ХКОМ-ын төслүүд нь Монгол-Японы Засгийн газар, төсөл хэрэгжүүлэгч тал буюу Монгол талын оролцогч байгууллага, төсөл боловсруулагч эсвэл технологи нийлүүлэгч тал буюу Япон талын оролцогч байгууллага, Хамтарсан Хороогоор томилогдсон эрх бүхий Гуравдагч тал буюу хөндлөнгийн магадлагаа, нотолгоо хийх байгууллага гэсэн дөрвөн үндсэн талуудын оролцоотой байдаг.



Зураг 4. Оролцогч талуудын үүрэг

### 3.1 ХАМТАРСАН ХОРОО

ХКОМ-ын Хамтарсан Хороо<sup>10</sup> нь хоёр улсын Засгийн газрын төлөөллүүдээс бүрдсэн дүрэм журам боловсруулах, аргазүйг батлах, санал болгож буй аргазүйг зөвшөөрөх эсвэл татгалзах, ХКОМ-ын төслүүдийг бүртгэх, гуравдагч талын этгээд (ГТЭ)-ийг итгэмжлэх, кредит олгохыг хүссэн хүсэлтийг зөвшөөрөх эсвэл татгалзах, дүрэм журам боловсруулах зэрэг ХКОМ-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л шийдвэрийг гаргах эрх бүхий гишүүдтэй хороо юм.

10 МОЕJ. (2015, Apr 5). JCM Rules of Procedures for the Joint Committee. Retrieved from [https://www.jcm.go.jp/https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_02/JCM\\_MN\\_RoP\\_JC\\_ver02.0.pdf](https://www.jcm.go.jp/https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_02/JCM_MN_RoP_JC_ver02.0.pdf)



### 3.2 НАРИЙН БИЧГИЙН ГАЗАР

ХКОМ-ын өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, хоёр талын Хамтарсан Хороо, бусад ХКОМ-ын хэрэгжилтийг ханган ажилладаг байгууллагууд болон төсөлд оролцогч талуудыг мэдээллээр хангах, чадавх бэхжүүлэх ажлуудыг зохион байгуулах, төслийн баримт бичиг, холбогдох материалуудын бүрэн бүтэн байдлыг шалгах, гарсан шийдвэр, өөрчлөлтийг танилцуулах зэрэг үүрэг, зорилготой ХКОМ-ын нарийн бичгийн газрыг байгуулан ажиллана.

### 3.3 ТӨСӨЛД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Хамтарсан механизм гэдэг утгаараа ХКОМ-ын төслүүд Монгол-Японы тус тусын үүрэг, хариуцлага бүхий аж ахуйн нэгжүүд хамтран төслийг хэрэгжүүлнэ. Өөрөөр хэлбэл, төсөл хэрэгжүүлэгч улсын буюу Монгол тал, төслийг хөгжүүлэгч, технологи нийлүүлэгч буюу Япон тал хамтран олон улсын консорциум байгуулан ажиллана. Төсөлд оролцогч талууд<sup>11</sup> нь төслийн аргазүй (шаардлагатай бол) боловсруулах, төслийн баримт бичиг (ТББ) бэлтгэн ирүүлэх, ХКОМ-ын төслийг хэрэгжүүлэх явцад төслийн хяналт шинжилгээг тогтмол хийх, байгаль орчны үнэлгээ тайлан гаргуулах, мөн магадлан итгэмжлэгдсэн гуравдагч талын этгээд (ГТЭ)-ээр төслийг баталгаажуулах ажлыг хийх үүрэгтэй. Төсөлд оролцогч талууд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын кредитийг тооцуулах эрхтэй.

Түнш улсын төсөл хэрэгжүүлэгч тал нь тухайн улсын хууль, тогтоомжийг даган Засгийн газрын холбогдох байгууллагатай нягт хамтран ажиллана.

### 3.4 ХӨНДЛӨНГИЙН МАГАДЛАГАА, НОТОЛГОО ХИЙХ БАЙГУУЛЛАГА

ХКОМ-ын төслүүдэд хөндлөнгөөс магадлагаа, нотолгоо хийх Гуравдагч талын этгээд байгууллага<sup>12</sup> нь Хамтарсан Хороогоор зөвшөөрөгдөн томилогдсон, Олон Улсын Стандартчлалын Байгууллага (ISO)-ын ISO-14065<sup>13</sup>, Цэвэр Хөгжлийн Механизм (ЦХМ)-ын Гүйцэтгэх зөвлөлөөр магадлан итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллага байна.

11 MOEJ. (2018, Nov 06). Rules of Implementation for the Joint Crediting Mechanism (JCM). Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_01/JCM\\_MN\\_Rol\\_ver04.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_01/JCM_MN_Rol_ver04.0.pdf) Section F, Project Participants

12 MOEJ. (2018, Nov 06). Rules of Implementation for the Joint Crediting Mechanism (JCM). Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_01/JCM\\_MN\\_Rol\\_ver04.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_01/JCM_MN_Rol_ver04.0.pdf) Section E, Third-Party Entities

13 International Organization for Standardization (ISO) 14065. <https://www.iso.org/standard/74257.html>



# БҮЛЭГ 4

## САНХҮҮГИЙН СХЕМ

- 4.1 Загвар төсөл
- 4.2 ХКОМ-ын Эко түрээсийн схемийн төсөл
- 4.3 Хамтарсан инновацийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нүүрстөрөгч бага бүхий технологийг үзүүлэх төсөл
- 4.4 АХБ-ны ХКОМ-ыг дэмжих Япон сан
- 4.5 Үзүүлэх төсөл
- 4.6 Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа

Япон улсын Засгийн газраас ХКОМ-ын төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх Загвар төслийн хөтөлбөр, ХКОМ-ын Эко түрээсийн схемийн хөтөлбөр, Хамтарсан инновацийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нүүрстөрөгч бага бүхий технологийг үзүүлэх төсөл, Үзүүлэх төслийн хөтөлбөр, мөн Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны дэмжлэгтэй Хамтарсан Кредит Олгох Механизмыг дэмжих Япон Сан гэсэн санхүүжилтийн эх үүсвэрүүдээр дамжуулан дэмжлэг үзүүлж байна (Хүснэгт 1).

**Хүснэгт 1.** ХКОМ-ын Загвар төслийн санхүүгийн дэмжлэгийн харьцуулсан байдал<sup>14</sup>

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ		ХАМРАГДАХ БОЛОМЖТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭД	
<b>ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС</b>			
ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСӨЛ	Төслийн анхны хөрөнгө оруулалтын 50 хүртэл хувийг хөнгөлөх бөгөөд хэмжиж, тайлагнах, нотлох хугацааг Япон улсын хуулийн дагуу үйлчилгээний хугацаагаар тодорхойлно.	Япон тал (өргөдөл гаргагч), Монгол талын хамтрагч шаардлагатай	
ХКОМ-ЫН ЭКО ТҮРЭЭСИЙН СХЕМ	Шаардлага хангасан төслийн анхны хөрөнгө оруулалтын зардлын 10%-ийг хөнгөлөх бөгөөд хэмжиж, тайлагнах, нотлох хугацаа нь түрээсийн хугацаатай ижил байна. (5 жил орчим)	Япон тал (өргөдөл гаргагч), Монгол талын хамтрагч шаардлагатай	
Хамтарсан инновацийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нүүрстөрөгч бага бүхий технологийг үзүүлэх төсөл	<ol style="list-style-type: none"> <li>Энэхүү санхүүжилтийн хөтөлбөр нь Япон болон түнш орнууд хамтран үр ашигтай инновацийг дэмжих, өндөр үр ашигтай нүүрстөрөгчгүй технологи, бүтээгдэхүүнийг шинэчлэн, түгээн дэлгэрүүлснээр нүүрстөрөгчгүй нийгмийг цогцлооход оршино.</li> <li>Санхүүгийн дэмжлэгийн хэмжээ               <ol style="list-style-type: none"> <li>Жижиг дунд бизнес эрхлэгчдэд: 2/3</li> <li>А заалтад хамрагдахгүй оролцогчид: өргөдөл гаргах үеийн төслийн өртөг нэг санхүүгийн жилд нэг зуун сая иенээс илүү байвал: 50%</li> <li>А заалтад хамрагдахгүй оролцогчид: өргөдөл гаргах үеийн төслийн өртөг нэг санхүүгийн жилд нэг зуун сая иенээс бага байвал: 1/3</li> </ol> </li> </ol>	Япон тал (өргөдөл гаргагч), Монгол талын хамтрагч шаардлагатай	
ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ	Анхны хөрөнгө оруулалтын зардал (эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр)	Япон тал (өргөдөл гаргагч), Монгол талын хамтрагч шаардлагатай	
<b>АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНААС</b>			
ХКОМ-ЫГ ДЭМЖИХ ЯПОН САН	Хараат бус төслүүд <i>БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ/ЗЭЭЛ</i>	Төслийн нийт зардлын 10% (10 сая доллар хүртэл)	АХБ болон Зээлдэгч тал
	Хараат төслүүд <i>АХБ-ААС АВСАН ЗЭЭЛИЙН ХҮҮГ ТӨЛНӨ</i>	Зээлийн хүүгийн тэтгэмж болгон төслийн нийт зардлын 10% (10 сая доллар хүртэл)	

14 GEC, G. E. (2020). The Global Environment Centre Foundation (GEC) as an implementing organization for the Financing Programme for Joint Crediting Mechanism (JCM). Retrieved from <http://gec.jp/http://gec.jp/jcm/about/>.

## 4.1 ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСЛИЙН ХӨТӨЛБӨР

Японы Байгаль Орчны яам 2013 онд ХКОМ-ын Загвар төслийн хөтөлбөрийг<sup>15</sup> санаачлан төсөлд оролцогч талуудын анхны хөрөнгө оруулалтын 50 хүртэлх хувийг буцалтгүй тусламж хэлбэрээр олгон санхүүжүүлсээр ирсэн. Санхүүжилтэнд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах эсвэл хүлэмжийн хий бага ялгаруулдаг барилга байгууламж, тоног төхөөрөмж, мөн тэдгээр байгууламжийг суурилуулах барилга угсралтын ажлын зардал багтана. ХКОМ-ын Загвар төслийн хөтөлбөрийн нарийн бичгийн газрын үүргийг гүйцэтгэж буй Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Сан (ДДБОТС) нь тухайн жилд хэрэгжих төслүүдийн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулдаг.

ХКОМ-ын загвар төсөлд хамрагдахын тулд хоёр улсын төсөл хэрэгжүүлэгч байгууллагууд олон улсын консорциум байгуулан хамтран ажиллана. Олон улсын консорциумд ХКОМ-ын төслөөр бүртгүүлэх, хяналт шинжилгээг хийх, тайлагнах, баталгаажуулах ажлуудыг хэрэгжүүлэх болон төслийн хэрэгжилтийн хүрээнд тооцуулсан ялгарлын бууралтын кредитийн талаас доошгүй хувийг Япон улсын Засгийн газарт тооцуулах зэрэг шаардлага тавигдана. Олон улсын консорциумын хүрээнд Япон тал нь Японы Байгаль Орчны яам руу төслийн өргөдлөө илгээх бөгөөд санхүүжилтийг мөн хүлээн авах эрхтэй. Тиймээс ХКОМ-ын Загвар төслийн хүрээнд дэмжлэг авахыг хүссэн хэрэгжүүлэгч улс нь төсөл боловсруулагч Япон талын хамтран ажиллах байгууллагаа олсон байх ёстой.

Дараах Японы байгууллагуудыг консорциумын төлөөлөгчөөр хүлээн зөвшөөрнө.

1. Хувийн хэвшлийн компаниуд;
2. Бие даасан захиргааны байгууллагууд;
3. Нэгдсэн Холбоо/Нийгэмлэг;
4. Японы Байгаль Орчны яамны зөвшөөрлийн дагуу Даян Дэлхийн Байгаль Орчны Төв сангаас тохиромжтой гэж үзсэн байгууллага.

Санхүүжилтийн өргөдлийг жилд хэд хэдэн удаа тогтмол бус хугацаанд хүлээн авна. Өргөдлийг үнэлэх шалгуурт: төслийн боломж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах урьдчилсан тооцоолол, эдийн засгийн үр ашиг, технологийг нутагшуулах, ХКОМ-ын төслийн аргачлалыг хөгжүүлэх боломж зэрэг багтана. ДДБОТС нь хүлээн авсан

15 MOEJ. (2013). Guidelines for Submitting Proposals, Tokyo: GEC. Retrieved 2020, from [http://gec.jp/https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/\(tentative\)2021\\_Guidelines\\_for\\_Submitting\\_Proposals.pdf](http://gec.jp/https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/(tentative)2021_Guidelines_for_Submitting_Proposals.pdf) (Линкийг хуулж аван өөрийн интернет хөтөч дээр нээнэ үү)

саналуудыг үнэлэн тэнцсэн өргөдөл гаргагчийн материалыг Японы Байгаль Орчны яамтай зөвшилцөн шийдвэрлэдэг.

Одоогийн байдлаар Монгол улсад Загвар төсөл санхүүжүүлэх схемийн дагуу 6 төслийг хэрэгжүүлж байна.

## 4.2 ХКОМ-ЫН ЭКО ТҮРЭЭСИЙН СХЕМ

2020 оноос эхлэн Япон улсын Засгийн газар загвар төслүүдийг цаашид хөгжүүлэх, өргөжүүлэх зорилгоор “ХКОМ-ын Эко түрээсийн схем”<sup>16</sup>-ийг хэрэгжүүлж эхэлсэн. ХКОМ-ын Эко түрээсийн схемийн хүрээнд барилга байгууламж/тоног төхөөрөмжийн болон холбогдох түрээсийн хүүгийн зардалд Японы Байгаль Орчны яамнаас санхүүгийн дэмжлэг авах боломжтой.

“ХКОМ-ын Эко түрээсийн схем” нь биет байгууламжийг дэмжихийн оронд түрээсийн бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх замаар нүүрстөрөгч бага бүхий техник технологийг илүү үр дүнтэйгээр өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлдэг байна.

Энэхүү шинэ схем нь хяналт шинжилгээний хугацааг богиносгон, төслийн баримт бичгийн саналыг илүү хялбаршуулж төсөл хэрэгжүүлэгч талуудын тайлагнах явцыг хөнгөвчлөх давуу талтай юм.

## 4.3 ХАМТАРСАН ИННОВАЦИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ЧИГЛЭСЭН НҮҮРСТӨРӨГЧГҮЙ ТЕХНОЛОГИЙГ ҮЗҮҮЛЭХ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨР<sup>17</sup>

Энэхүү санхүүжилтийн хөтөлбөр нь Япон болон түнш орнууд хамтран үр ашигтай инновацийг (хамтын инноваци) хөгжүүлэх зорилготой. Түүнчлэн, өндөр чанартай нүүрстөрөгчгүй технологи, бүтээгдэхүүнийг шинэчлэн, түгээн дэлгэрүүлэх үүнд Япон улсын нүүрстөрөгч бага бүхий технологи, бүтээгдэхүүнийг системчлэх, хэд хэдэн технологийг нэгтгэх болон тэдгээр технологийн ашиглалтыг дэмжих замаар Япон улсын технологи хөгжүүлэгчдэд үр өгөөжтэй байлгах, цаашлаад нүүрстөрөгч багатай нийгмийг цогцлооход оршино.

16 MOEJ. (2020). JCM Eco Lease Scheme. Tokyo: GEC. Retrieved from [https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/jcmsbsdR3\\_ecolease\\_overview\\_en.pdf](https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/jcmsbsdR3_ecolease_overview_en.pdf)

17 MOEJ. (2018). Demonstrate Decarbonization Technology for Realizing Co-Innovation. Tokyo: GEC. Retrieved from <https://gec.jp/category/innovation/>

Эдгээр төслүүд нь эрчим хүчний хэрэглээнээс гарах нүүрстөрөгчийн хийн ялгарлыг бууруулахад хувь нэмэр оруулах шаардлагатай. Төсөл хэрэгжиж дууссаны дараа санхүүгийн дэмжлэг хүлээн авагч нь төслийн үр дүнд буурсан хүлэмжийн хийн ялгарлын бууралтын тооцооллыг хийж Японы Байгаль Орчны яаманд тайлагнах үүрэгтэй.

Хамтарсан инновацийн санхүүжилтийн хөтөлбөр нь 2018 оны 6 дугаар сард Японы Засгийн газрын Хэрэг Эрхлэх Газраас эмхтгэн гаргасан Гадаад Хөгжлийн Стратеги (Байгаль орчин)-ийг сурталчлахад хувь нэмэр оруулахыг зорьж байна. Уг хөтөлбөр нь ХКОМ болон Хот хоорондын хамтын ажиллагааны хөтөлбөрүүдээр дамжуулан бусад оронд нүүрстөрөгчгүй технологийг сурталчлах стратеги бодлогын нэг хэсэг юм.

Хөтөлбөрийн хүрээнд санхүүжилт авахаар сонгогдсон төслийн оролцогчид Байгаль Орчны Тавдугаар суурь төлөвлөгөөний дагуу “Бүс нутгийн эргэлт ба Экологийн хүрээ” болон Тогтвортой Хөгжлийн Зорилтууд ‘ТХЗ’-ыг сурталчлахад хувь нэмэр оруулах хэрэгтэй.

#### 4.4 АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХКОМ-ЫГ ДЭМЖИХ ЯПОН САН

Хамтарсан Кредит Олгох Механизмыг дэмжих Япон сан<sup>18</sup> (цаашид АХБЯС) нь 2014 оны 6 сард байгуулагдсан Азийн Хөгжлийн Банкны итгэмжлэгдсэн сан юм. Сан нь АХБ-аас санхүүжүүлсэн ХКОМ-ын шаардлага хангасан төслүүдэд бага нүүрстөрөгч бүхий дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэхэд буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа үзүүлэх хэлбэрээр олгодог санхүүгийн урамшуулал юм. Хараат бус буюу бие даасан (төрийн өмчийн хөрөнгө оруулалттай) болон хараат (хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай) төслүүд дэмжлэг авах боломжтой.

Япон улсын Засгийн газар АХБЯС-д жил бүр дэмжлэг үзүүлсээр ирсэн бөгөөд одоогийн байдлаар өссөн дүнгээрээ 8.2 тэрбум ¥ (79.29 сая доллартай тэнцэх) болоод байна. Энэхүү дэмжлэгийг ирэх жилүүдэд үргэлжлүүлэхээр төлөвлөж байгаа. Япон улсын Засгийн газартай ХКОМ-ын тухай хоёр талт гэрээ байгуулсан АХБ-ны гишүүн хөгжиж буй орнууд (DMC's) энэхүү дэмжлэгийг авах эрхтэй.

АХБЯС-аас дэмжлэг авахын тулд тухайн төслүүд нь АХБ эсвэл түүний харьяа сангуудаар санхүүжигдсэн байх ёстой. Бусад банк эсвэл хандивлагчдын АХБ-тай хамтран санхүүжүүлдэг төслүүд нь мөн хамрагдах

18 Asian Development Bank ADB. (2016). Handbook for Developing Joint Crediting Mechanism Projects. ADB. Retrieved Jan 2021, from <https://www.adb.org/documents/handbook-developing-joint-crediting-mechanism-projects>

боломжтой боловч зөвхөн АХБ-ны санхүүжилттэй хэсэг нь АХБЯС-аас санхүүгийн дэмжлэг авах эрхтэй.

**Хараат бус төслүүд.** Хараат бус төслүүдийн хувьд, АХБЯС-аас нүүрстөрөгч бага бүхий дэвшилтэт техник технологитой холбоотой нэмэлт зардалд санхүүжилт олгоно. Санхүүжилт нь төслийн нийт өртгийн 10% эсвэл 10 сая доллар хүртэл байх боломжтой ба аль бага хэмжээгээр тооцно. 50 сая доллараас бага өртөгтэй төслүүдийн хувьд тэтгэмжийн дээд хэмжээ 5 сая доллар байна.

**Хараат төслүүд.** Хувийн хэвшлийн зээлдэгчид эсвэл АХБ-ны гишүүн хөгжиж буй орны засгийн газрын бус төсөл хөтөлбөрүүдийн хувьд АХБЯС нь ХКОМ-ын хүрээнд хэрэгжүүлж буй эрчим хүчний үр ашигтай/сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд АХБ-ны зээлийн хүүгийн санхүүжилтийг олгоно. Зээлдэгч нь буцалтгүй тусламж авалгүйгээр зээлээ хүүгүйгээр эргэн төлж болно. Санхүүжилт нь төслийн нийт өртгийн 10% эсвэл 10 сая доллар хүртэл байх боломжтой ба аль бага хэмжээгээр тооцно.

Одоогийн байдлаар Монгол улсад АХБ-ны дэмжлэгтэй АХБЯС-ийн хөтөлбөрийн хүрээнд 2 төсөл хэрэгжиж байна.

**Хүснэгт 2.** Японы Байгаль орчны яам дэмжлэгтэй Загвар төсөл, Эко түрээсийн схем, АХБ-ны дэмжлэгтэй АХБЯС харьцуулалт<sup>19</sup>

ГАРЧИГ	ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСӨЛ	ХКОМ-ЫН ЭКО ТҮРЭЭС	АХБ-НЫ ДЭМЖЛЭГТЭЙ ХКОМ-ЫН ТӨСЛҮҮД
<b>Төслийн шаардлага хангасан улс</b>	ХКОМ-ын түнш 17 улс	ХКОМ-ын түнш 17 улс	Ази, Номхон далайн бүсийн ХКОМ-ын түнш 11 орон
<b>Бизнесийн төрөл</b>	Техник технологи/ байгууламжид зориулсан буцалтгүй тусламж (түрээслэх боломжтой)	Түрээсийн төлбөрийн буцалтгүй тусламж	Буцалтгүй тусламж/ Зээл
<b>Санхүүжилтийн дээд хэмжээ</b>	Тухайн улсад дэмжигдсэн техник технологийн тооноос хамаарч шаардлага хангасан төслийн зардлын 50% хүртэл, 2 тэрбум иен хүртэл (19 сая доллар орчим)	3 жилийн хугацаанд түрээсийн зээлийн хүүг багтаасан түрээсийн төлбөрийн 10% (Хамгийн дээд ногдуулах төсөв 500 сая иен орчим (5 сая доллар))	АХБ-ны зээлийн хүүгийн тэтгэмж болгон төслийн нийт зардлын 10% (10 сая доллар хүртэл)

<sup>19</sup> GEC, G. E. (2021). The Global Environment Centre Foundation (GEC) as an implementing organization for the Financing Programme for Joint Crediting Mechanism (JCM). Retrieved from <http://gec.jp>:



<b>Эрх бүхий өргөдөл гаргагч</b>	Санхүүгийн дэмжлэгийн хүсэлт гаргах төлөөлөл нь Японы байгууллага байна	Санхүүгийн дэмжлэгийн хүсэлт гаргах төлөөлөл нь Японы түрээсийн компани байна	АХБ-аас зээл авах байгууллага нь АХБ-ны хөгжиж буй гишүүн орнуудын байгууллага байна (АХБ нь ХКОМ-ын өргөдлийн баримт бичгийг боловсруулна)
<b>Санхүүжилтэд хамрагдах зардлууд</b>	Машин механизм болон хэрэглээний зардал, барилга угсралтын ажлын зардал, захиргааны ажлын зардал гэх мэт.	Шаардлага хангасан техник технологүүд/байгууламжийн түрээсийн төлбөр	Төслийг АХБ-тай хамтран санхүүжүүлэх эсвэл АХБ-ны удирддаг сангаас санхүүжүүлнэ (ХКОМ-д өргөдөл гаргаж буй Эрчим хүчний үр ашигтай/сэргээгдэх эрчим хүчний төслүүд)
<b>Шаардлага хангасан техник технологи/байгууламж</b>	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад шууд хувь нэмэр оруулах	Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад шууд хувь нэмэр оруулах	Хүлэмжийн хийн ялгарлыг болон эрчим хүчний эх үүсвэрээс ялгардаг CO <sub>2</sub> -г бууруулах дэвшилтэт нүүрстөрөгч бага бүхий тоног төхөөрөмж
<b>Худалдан авах ажиллагаа</b>	Төслөөс хамаарна	Төслөөс хамаарна	АХБ-д хүлээн зөвшөөрөгдсөн хувийн хэвшлийн эсвэл арилжааны үйл ажиллагаа явуулдаг байгууллага гүйцэтгэнэ
<b>Санхүүжилтийн үнэлгээ</b>	Хэрэгжүүлэгч байгууллага (Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Сангийн 2014-2021 он санхүүгийн жил) болон Японы Байгаль Орчны яам	Хэрэгжүүлэгч байгууллага (Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Сангийн 2020-2021 он санхүүгийн жил) болон Японы Байгаль Орчны яам	Зээл: АХБ ХКОМ: АХБ болон Японы Байгаль Орчны Яам
<b>Зардлын үр ашиг</b>	≤ 4,000JPY/tCO <sub>2</sub>	≤ 4,000JPY/tCO <sub>2</sub>	≤ \$40/tCO <sub>2</sub>
<b>Өргөдөл хүлээн авах хугацаа</b>	Төсөв нь Японы санхүүгийн жилтэй холбоотой. 2021 санхүүгийн жилийн хувьд 4-р сараас 10-р сарын хооронд өргөдөл авах нээлттэй	Төсөв нь Японы санхүүгийн жилтэй холбоотой. 2021 санхүүгийн жилийн хувьд 4-р сараас 10-р сарын хооронд өргөдөл авах нээлттэй	Хэдийд ч хамаагүй
<b>Барилга угсралтын ажлын хугацаа</b>	Саналыг хүлээн авсан оныг оруулан Японы 3 санхүүгийн жилийн хугацаанд	Саналыг хүлээн авсан оныг оруулан Японы 3 санхүүгийн жилийн хугацаанд	ХКОМ-д шаардлагагүй

<b>ХКОМ-ын аргазүй болон Төслийн баримт бичиг боловсруулах</b>	Японы Байгаль Орчны Яам нь зөвлөх ажиллуулах төсөвтэй байдаг	Зарчмын хувьд, санал болгож буй техник технологи нь ХКОМ-ын аргазүйгээр батлагдсан эсвэл санал болгосон байна.	Санхүүжилт хүлээн авагч нь ХКОМ-ын санхүүжилтээс зөвлөх ажиллуулах боломжтой
<b>Хяналт шинжилгээний хугацаа</b>	Япон улсын хуулиар тогтоосон тоног төхөөрөмж/байгууламжийн эдэлгээний хугацаа дуустал	Түрээсийн хугацаагаар	Төслийн ажиллагаа дуусах хүртэл эсвэл Япон болон хэрэгжүүлэгч улсын хоорондын ХКОМ-ын баримт бичигт заасан хугацаа дуусах хүртэл, аль нь түрүүлж дуусах хугацаагаар
<b>Нотолгоо</b>	Нотолгоог дор хаяж хоёр удаа явуулна: (i) нэг жил ажилласны дараа, (ii) 2030 оны 12-р сар эсвэл төслийн үйл ажиллагаа дууссаны дараа, түрүүлж дуусах хугацаагаар	Нотолгоог дор хаяж хоёр удаа явуулна: (i) нэг жил ажилласны дараа, (ii) 2030 оны 12-р сар эсвэл төслийн үйл ажиллагаа дууссаны дараа, түрүүлж дуусах хугацаагаар	Нотолгоог дор хаяж хоёр удаа явуулна: (i) нэг жил ажилласны дараа, (ii) 2030 оны 12-р сар эсвэл төслийн үйл ажиллагаа дууссаны дараа, түрүүлж дуусах хугацаагаар
<b>Гуравдагч талын этгээд (ГТЭ)-ийн зардал (магадлагаа, нотолгоо)</b>	Японы Байгаль Орчны Яамнаас магадлагаа болон эхний нотолгооны зардалд дэмжлэг үзүүлэх боломжтой	Японы Байгаль Орчны Яамнаас магадлагаа болон эхний нотолгооны зардалд дэмжлэг үзүүлэх боломжтой	Магадлагаа болон эхний нотолгооны зардлыг ХКОМ-ын Японы Сангаас гаргах боломжтой
<b>Санхүүгийн дэмжлэгийг олгох</b>	Ихэвчлэн төлбөрийг төсөл дуусан туршилт хийгдсэний дараа болон Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Сангаас эцсийн шалгалт хийсний дараа олгодог. Шаардлагатай бол загвар төслийн гүйцэтгэсэн хэсгийг үндэслэн явцын төлбөрийг хийж болно.	Ихэвчлэн төлбөрийг төсөл дуусан туршилт хийгдсэний дараа болон Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Сангаас эцсийн шалгалт хийсний дараа олгодог. Явцын төлбөр олгохгүй.	Төлбөрийг төсөл дууссаны дараа Японы Байгаль Орчны яамнаас байгууллагуудад олгоно.
<b>Кредит хуваах</b>	50-аас доошгүй хувийг Японы Засгийн газарт тооцуулна	50-аас доошгүй хувийг Японы Засгийн газарт тооцуулна	Төсөлд оролцогчид болон Япон, түнш орны Засгийн газрууд хоорондоо хэлэлцэнэ.

## 4.5 ХКОМ-ЫН ҮЗҮҮЛЭХ ТӨСӨЛ

Японы Эдийн Засаг, Худалдаа, Аж Үйлдвэрийн яамны дэргэдэх Шинэ Эрчим Хүч, Аж Үйлдвэрийн Технологийн Хөгжлийн байгууллага (NEDO) нь ХКОМ-ын үзүүлэх төслийн хөтөлбөрийг<sup>20</sup> удирддаг. Энэхүү хөтөлбөр нь нүүрстөрөгч бага бүхий дэвшилтэт технологийг хэрэгжүүлэхтэй холбоотой анхны хөрөнгө оруулалтын зардлын зарим хэсэг болох зураг төсвийн үндсэн зардал, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн зардал, олон улсын тээврийн зардал зэргийн санхүүжилтийг олгодог. Мөн ХКОМ-ын Хэмжиж, тайлагнах нотлох (MRV) болон хөндлөнгийн магадлагаа, нотолгоохийх байгууллагын холбоотой зардлыг санхүүжүүлэх боломжтой. Загвар төслийн схемийн адил NEDO нь төслүүдэд санхүүжилтийн дэмжлэг үзүүлэхийг тодорхойлох сонгон шалгаруулалтыг явуулдаг байна.

Хөтөлбөрийн дагуу 'үзүүлэх хугацаа' хамгийн ихдээ 2 жил байх бөгөөд энэ хугацаанд тоног төхөөрөмжийн суурилуулалт, 1 жилийн ашиглалт, хяналт шинжилгээг хийх ёстой. Загвар төслөөс ялгаатай нь Хэмжиж, тайлагнах нотлох аргаар хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцоолох ёстой ч ХКОМ-ын кредитийг олгох, хүргүүлэхийг шаарддаггүй.

Үзүүлэх төслийн хөтөлбөрт төсөлд оролцогч талуудад тоног төхөөрөмжийн зардлын тодорхой хэсгийг тодорхой хугацааны дараа NEDO-д буцааж төлөх өвөрмөц шаардлага тавьдаг. 'Үзүүлэх хугацаанд' NEDO нь уг хөтөлбөрийн хүрээнд суурилуулсан тоног төхөөрөмжийн хууль ёсны өмчлөгч байдаг бөгөөд хэрэгжүүлэгч улсын төсөлд оролцогч талуудад төхөөрөмжийг ашиглахыг зөвшөөрдөг байна. 'Үзүүлэх хугацаа' дуусахад Япон талын төслийн оролцогч нь NEDO-оос суурилуулсан тоног төхөөрөмжөө буцааж худалдаж авах ёстой бөгөөд уг тоног төхөөрөмжид элэгдэл хорогдол багатайгаар нөхөн олговор тооцно. Бодит байдал дээр Япон талын аж ахуйн нэгж тоног төхөөрөмжийг хэрэгжүүлэгч улсын түншдээ зардаг байна. Тиймээс уг схем нь тоног төхөөрөмжийг дор хаяж 1 жил ажиллуулсны дараа хэрэгжүүлэгч улсын аж ахуйн нэгжид хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжийг олгодог.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Япон талаас Хитачи ХХК, Монгол талаас Цахилгаан Дамжуулах Үндэсний Сүлжээ ТӨХК байгууллагууд хамтран 2013 онд "Өндөр үр ашигтай, алдагдал багатай цахилгаан дамжуулах, түгээх систем"-ийн төслийг ХКОМ-ын үзүүлэх төслөөр хэрэгжүүлж дууссан.

20 Asian Development Bank ADB. (2016). Handbook for Developing Joint Crediting Mechanism Projects. ADB. Retrieved Jan 2021, from <https://www.adb.org/documents/handbook-developing-joint-crediting-mechanism-projects>

#### 4.6 ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГАА ХИЙХ

Япон улсын Засгийн газар нүүрстөрөгч бага бүхий дэвшилтэт технологийг эх үүсвэр болгох, боломжит төслүүдийн эх үүсвэр, мөн ХКОМ-ын аргачлалыг боловсруулахад зориулж 2010 оноос хойш ХКОМ-ын Техник Эдийн Засгийн Үндэслэлийн Судалгаа<sup>21</sup> (ТЭЗҮ)-ны хэд хэдэн ажлыг санхүүжүүлсэн. Загвар болон үзүүлэх төслийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж буй ихэнхи төслүүдийн сонгон шалгаруулалтыг эхлэхээс өмнө ХКОМ-ын техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг Японы Засгийн газрын санхүүжилтээр амжилттай боловсруулж дууссан байдаг. ХКОМ-ын төслүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх дээрх эх үүсвэрүүд нь төсөл боловсруулах болон хэрэгжүүлэх эхний үе шатанд хийгдэх бөгөөд анхны хөрөнгө оруулалтын өртгийг нөхөх эсвэл ХКОМ-ын төслийн санхүүжилтийн зардлыг бууруулах боломжтой юм. Урьдчилгаа санхүүжилт авах боломжтой байх нь бага нүүрстөрөгч бүхий төслүүдэд тулгарч буй саад бэрхшээлүүд болох анхны хөрөнгө оруулалтын өртөгийг багасгах, гэрээний хугацаанд төслийн хэвийн ажиллахтай холбоотой эрсдлийг арилгахад туслах болно.

ТЭЗҮ-ийн хөтөлбөрийн хүрээнд 2013-2015 оны хооронд Монгол Улсад 9 судалгааны төслийг хэрэгжүүлж дууссан.

21 MOEJ. (2010). The Feasibility Study Program. Tokyo, Japan. Retrieved from [https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm\\_pamphlet\\_02.pdf](https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm_pamphlet_02.pdf)

# БҮЛЭГ 5

## ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСӨЛД САНАЛ ИРҮҮЛЭХ ДЭЛГЭРЭНГҮЙ ЗААВАРЧИЛГАА<sup>22</sup>

- 5.1 Зорилго
- 5.2 Ерөнхий танилцуулга
- 5.3 Төслийн сонгон шалгаруулалт болон үнэлгээ
- 5.4 Сонгон шалгаруулалтын дараах үе шат
- 5.5 Мэдээллийн хариуцлагатай байдал
- 5.6 Тэмдэглэл
- 5.7 ХКОМ-ын загвар төслийг сонгон шалгаруулах үнэлгээний шалгуур үзүүлэлт

<sup>22</sup> GEC, G. E. (2020). Guidelines for Submitting Proposals. Tokyo: GEC. Retrieved from [https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/\(tentative\)2021\\_Guidelines\\_for\\_Submitting\\_Proposals.pdf](https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/(tentative)2021_Guidelines_for_Submitting_Proposals.pdf) (Линкийг хуулж аван өөрийн интернет хөтөч дээр нээнэ үү) (CHAPTER 5) is adopted entirely based on the "Guidelines for Submitting Proposals", an official document developed by GEC for the JCM.

## 5.1 ЗОРИЛГО

ХКОМ-ын Загвар төсөлд санал ирүүлэх дэлгэрэнгүй зааварчилгаанд санхүүжилтийн схемийн хүрээнд өргөдөл гаргахаас эхлэн төсөл дуусах хүртэл баримт бичгийн бүрдүүлэлт, хэрхэн оролцох, үүрэг хариуцлага, төслийн үе шат, санхүүжилтийн процедур гэх мэт тайлбарыг өгөхөөр зорилоо.

## 5.2 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Төсөлд оролцогч талууд нүүрстөрөгчгүй дэвшилтэт технологийг ашигласан загвар төслийг хэрэгжүүлэх бөгөөд үүнтэй холбоотой хүлэмжийн хийн ялгарлын бууралтаа хэмжих, тайлагнах, нотлох (MRV) зарчмаар явуулна.

ХКОМ-ын түншулсад, оролцогч талууд ХКОМ-ын түнш орнуудын төсөл хэрэгжүүлэгч талууд нь Олон Улсын Консорциумын гишүүдэд тавигдах 2. (5) шаардлагын дагуу холбогдох төслийн дараах үйл ажиллагааг хариуцна.

### **Төсөлд оролцогч талууд холбогдох төслийн дараах үйл ажиллагааг хариуцна:**

а) ХКОМ-ын төслөөр бүртгүүлэх:

Төсөлд оролцогч талууд ХКОМ-ын төслөөр бүртгүүлэхдээ Төслийн Баримт Бичиг (ТББ) боловсруулах, үүнд орон нутгийн оролцогч талуудын уулзалтыг зохион байгуулах, төсөлд магадлагаа, нотолгоо хийх хөндлөнгийн Гуравдагч талын этгээдтэй хамтран ажиллах зэргийг оруулах шаардлагатай. Төслийн барилга, тоног төхөөрөмжийн угсралтын ажил дуусан үйл ажиллагаа эхэлснээс хойш 1 жилийн дотор төслийн бүртгэлийг хийсэн байна. ХКОМ-ын төслөөр бүртгүүлэхийн тулд төслийн аргачлалыг боловсруулан Хамтарсан Хороогоор батлуулсан байх шаардлагатай. Төсөлд оролцогч талууд өөрсдөө энэхүү аргачлалыг боловсруулах боломжтойгоос гадна ХКОМ-ын аргачлал боловсруулдаг мэргэжлийн байгууллагад шаардлагатай мэдээллийг өгч хамтран ажиллаж болно. Харин ХКОМ-ын Эко Түрээсийн схемийн төслийн хүрээнд шинээр аргачлал боловсруулахгүй. Өөрөөр хэлбэл өмнө батлагдсан ХКОМ-ын Загвар төслийн аргачлалыг ашиглан төслөө боловсруулж болно.

b) Хяналт шинжилгээ:

Төсөлд оролцогч талууд Хамтарсан Хороогоор батлагдсан эсвэл батлахаар хүлээгдэж буй хэмжиж, тайлагнаж, нотлох арга дээр суурилсан аргачлал дээр үндэслэн хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тоон үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийх бөгөөд Япон улсын хуульд заасны дагуу ХКОМ-ын хамтын ажиллагааны баримт бичиг хүчинтэй хугацаанд жил бүр тухайн төхөөрөмжийн үйл ажиллагааны тайланг Япон улсын Байгаль Орчны яаманд төхөөрөмжийн ажиллах бүрэн хугацааны туршид гаргаж өгнө. Нэмж дурдахад, талуудын хариуцлагатай холбоотойгоор хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг хэмжих боломжгүй хугацаа гарсан тохиолдолд уг хугацааг төслийн нийт үргэлжлэх хугацаан дээр нэмж тооцох болно. Япон Улсын Байгаль Орчны яам төслүүдийн ирүүлсэн тайланг хэрэгжүүлэгч улсын Засгийн газарт мэдээлэх эрхтэй.

c) ХКОМ-ын кредит тооцуулах хүсэлтийг гаргах:

ХКОМ аргачлалд заасны дагуу оролцогч талууд хяналт шинжилгээний тайланд үндэслэн ХКОМ-ын ялгарлын бууралтын кредитийг тооцуулах хүсэлтийг гаргана. Үүнд, хяналт шинжилгээний дэлгэрэнгүй тайлан, хөндлөнгийн байгууллагын баталгаажуулалт, ХКОМ-ын Хамтарсан Хороонд гаргасан “ХКОМ-ын кредит тооцуулах хүсэлт” өргөдлийг бүрдүүлэх шаардлагатай. Гэхдээ энэ нөхцөл нь улс хоорондын асуудлаас үүдэлтэйгээр хүсэлт гаргах боломжгүй байгаа оролцогч талуудад хамаарахгүй болно. Түүнчлэн, оролцогч талууд Япон Улсын Байгаль Орчны яамнаас шийдвэрлэсэн хувь хэмжээ бүхий тооцуулсан ХКОМ-ын кредитийг Япон улсын Засгийн газарт тооцуулна.

Төсөлд оролцогч талууд ХКОМ-ын хамтын ажиллагааны баримт бичиг хүчинтэй хугацаанд төслийн үйл ажиллагаа эхэлхээс дуусах хүртэлх хугацааны туршид бууруулсан хүлэмжийн хийн ялгаралд үндэслэн ХКОМ-ын кредитийг тооцуулах хүсэлтийг гаргана. Өөрөөр хэлбэл, ХКОМ-ын хоёр талт хамтын ажиллагааны баримт бичгийн хүчинтэй хугацаа 2020 оноос 2030 он хүртэл сунгагдсан тохиолдолд 2030 он хүртэлх бууруулсан хүлэмжийн хийн ялгарлын тооцоолол дээр үндэслэн ХКОМ-ын кредитийг тооцуулах хүсэлтийг илгээнэ.

Эхний кредит олгох хүсэлтийг ХКОМ-ын төслөөр бүртгүүлснээс хойш нэг жилийн дотор гаргана (хоёр талын хэлэлцээрийн нөхцөл байдлаас шалтгаалан гаргах боломжгүй байгаа нөхцөл байдлаас бусад тохиолдолд). Дараагийн хүсэлтийг холбогдох жилүүдэд

бууруулсан хүлэмжийн хийн ялгаралд үндэслэн гаргах боломжтой. Гэхдээ барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хуульд заасан эдэлгээний хугацаа дууссан тохиолдолд хүсэлтийг 1 жилийн дотор хийх, хэрэв барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хуульд заасан хугацаа 2031 оноос хойш дуусах тохиолдолд 2021 оноос 2030 он хүртэл бууруулсан ялгарлын бууралтыг 2031 он юмуу оройтлоо гэхэд 2032 оны эхэнд хүсэлтийг гаргаж болно. Хэрвээ шаардлагатай гэж үзвэл кредит тооцуулах хүсэлтээ 2030 оноос өмнө гаргаж болно.

\* Японы хуульд заасан хугацааг дараах вэбсайтнаас харах боломжтой. (Япон хэл дээр):



[https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=340M50000040015](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=340M50000040015)

ХКОМ-ын Эко Түрээсийн схемийн хувьд, хяналт, шинжилгээний хугацаа нь төслийн түрээсийн хугацаатай ижил байдаг буюу өөрөөр хэлбэл хамгийн багадаа таван жилийн хугацаатай байдаг.

\*Дээр дурдсан а) бүлгээс с) бүлэгт холбогдох зардлыг уг загвар төсөл хариуцахгүй болно. Гэхдээ, Японы Байгаль Орчны яам шаардлагатай гэж үзвэл аргачлал боловсруулах, төслийн баримт бичиг болон хяналт шинжилгээний тайлан бүрдүүлэлтийг дэмжих гэх мэт зардлыг гаргах боломжтой.

### 5.2.1 ЭРХ БҮХИЙ ТӨСЛҮҮД

Загвар төсөлд орох төслүүд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- a) Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл буюу ХКОМ-д нэгдсэн эсвэл нэгдэхээр төлөвлөж буй хөгжиж буй орнуудад нүүрстөрөгчгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар эрчим хүчний салбараас ялгарч байгаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төслүүдийг хэрэгжүүлэх, мөн Япон улсын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилгод тодорхой хэмжээний хувь нэмэр оруулах;
- b) Тухайн төсөл нь хэрэгжүүлэгч улсын тогтвортой хөгжлийн бодлогод хувь нэмэр оруулах. Төслийн суурилуулсан тоног төхөөрөмж, ашиглалтын үйл ажиллагаа нь тухайн орны холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн байхаас гадна байгаль орчныг хамгаалах олон улсын туршлагад нийцсэн байх шаардлагатай;
- c) Төслийн хүрээнд бууруулсан хүлэмжийн хийн ялгарлын үр дүнг тоон үзүүлэлтээр тооцоолж шалгаж болохоор байх;



- d) Тухайн төслийн хүрээнд суурилуулсан барилга байгуулж, тоног төхөөрөмж нь Япон улсын Засгийн газраас ямар нэг санхүүгийн дэмжлэг аваагүй байх;
- e) Хэрэв нэвтрүүлэх гэж буй технологи нь энэхүү гарын авлагын Хавсралт 3-т “Ашиглаж буй технологийн ангилал” -д багтсан бол технологи нь түүний нөхцлийг хангасан байна гэж үзнэ.

### 5.2.2 ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТОТ ОРНУУД

Загвар төслийг ХКОМ-ын хамтын ажиллагааг хэрэгжүүлэгч дараах улс орнуудад нэн тэргүүнд хэрэгжүүлнэ (2021 оны 4 сарын 7-ны байдлаар):

Монгол, Бангладеш, Этиоп, Кени, Малдив, Вьетнам, Лаос, Индонези, Коста Рика, Палау, Канбож, Мексик, Саудын Араб, Чили, Мьянмар, Тайланд болон Филиппин. (\*хоёр талт хамтын ажиллагаанд нэгдсэн бусад улс хамрагдах боломжтой)

### 5.2.3 ХЭН ОРОЛЦОХ ЭРХТЭЙ ВЭ?

Загвар төслийн хүрээнд дараах шаардлагуудыг хангасан оролцогч санхүүгийн дэмжлэг хүсэх эрхтэй:

- (a) Загвар төслийг төлөөлж буй оролцогч Япон компани нь:
  - I. Хувийн компани,
  - II. Бие даасан захиргааны байгууллага,
  - III. Нэгдсэн холбоо/сан, эсвэл
  - IV. Японы Байгаль Орчны яамнаас баталгаажсан ДДБОТС-аар хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага байх.
- (b) Дээрхи заасан оролцогч нь олон улсын консорциумын төлөөлөгч байгууллага байх.
  - 1. Олон улсын консорциум нь (хувь хүн байж болохгүй) төслийг амжилттай хэрэгжүүлэх зорилготой дээр дурдсан Япон талын хуулийн этгээд болон хэрэгжүүлэгч улсын хуулийн этгээдээс бүрдэнэ.
  - 2. Төлөөлж буй тал нь загвар төслийн хүсэлт гаргана. Олон улсын консорциумын төлөөлөх бүрэлдэхүүнээс (Монгол-Япон хуулийн этгээд) бусад гишүүдийг түнш оролцогч гэнэ.

3. Төслийн сонгон шалгаруулалтын дараа ДДБОТС-ийн зөвшөөрөлгүйгээр тухайн төслийн оролцогч талуудыг өөрчлөх боломжгүй.
  4. ХКОМ-ын Эко түрээсийн схемийн төлөөлөн оролцогч тал нь тоног төхөөрөмжийн түрээслүүлэгч нь байна
- (c) Төсөлд оролцогч талууд төслийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулсан байх шаардлагатай бөгөөд төслийг хэрэгжүүлэх техникийн чадамжтай байх шаардлагатай;
- (d) Төсөлд оролцогч талууд төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хариуцах санхүүгийн чадамжтай байх;
- (e) Төсөлд оролцогч талууд зохих менежментийн бүтэц болон нягтлан бодох бүртгэл, бусад захиргааны ажлыг хариуцах чадамжтай байх;
- (f) Төсөлд оролцогч талууд төсөлтэй холбоотой хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, зардлын задаргаа, хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүн болон бусад мэдээллийг бүрэн тайлагнана;
- (g) Төсөлд оролцогч талууд нь ямар нэгэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй (борёкудан) хамааралтай биш гэсэн амлалтыг өгнө.

#### 5.2.4 ОЛОН УЛСЫН КОНСОРЦИУМЫН ГИШҮҮДЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- a) Олон улсын консорциумын төлөөлж буй тал болох Япон талын хуулийн этгээд нь дараах хариуцлагуудыг хүлээнэ:
- I. Загвар төслийн хүсэлт гаргах,
  - II. Төслийн явцыг удирдах, төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах, нягтлан бодох бүртгэлийн гол холбоо барих байгууллагын үүргийг гүйцэтгэх болон төсөлтэй холбоотой бусад захиргааны ажлыг хариуцах,
  - III. Нүүрстөрөгчгүй шинэ дэвшилтэт технологийг танилцуулах,
  - IV. Төхөөрөмжийг худалдан авах, суурилуулалт хийх, барилга, тоног, төхөөрөмжийн угсралтын ажлыг дуусган ашиглалтанд оруулах мөн түүнчлэн Япон улсын хуульд зааснаар төслийн хэрэгжилтийн хугацаанд төхөөрөмж нь төслийн зорилгын дагуу ажиллаж буйг удирдан хянах,
  - V. Төсөлд оролцогч талуудын зүгээс Санхүүгийн Журмыг зөрчсөн тохиолдолд санхүүжилтыг буцаан олгох.

- b) Олон улсын консорциумын бүх гишүүдэд тавигдах шаардлага:
- I. ХКОМ-ын аргачлалыг хөгжүүлэгч байгууллагад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төслийн аргачлалыг хөгжүүлэхэд шаардагдах мэдээллийг өгөх, тэдэнтэй хамтран ажиллах;
  - II. Хөндлөнгийн магадлагаа, нотолгоо хийх байгууллагад төслийг баталгаажуулахад шаардагдах мэдээллээр хангах болон төслийн газар дээр хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хяналт шинжилгээ хийх үйл ажиллагаанд хамтран ажиллах;
  - III. Нүүрстөрөгчгүй дэвшилтэт технологийг нэвтрүүлэн ашиглаж хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хяналт шинжилгээ хийх;
  - IV. Төслийн үр дүнд буурсан хүлэмжийн хийн ялгарлыг тооцоолох, төсөл тус бүрийн онцлогоос шалтгаалан Япон улсын хуульд заасны дагуу барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа дуусах хүртэл ЯБОЯ-д тайлагнах;
  - V. Хамтарсан Хороонд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын кредит тооцуулах хүсэлт гаргах болон Хамтарсан Хороо эсвэл Японы Засгийн газар болон ХКОМ-ын түнш улсуудтай төслийг бүртгүүлэхтэй холбоотой шаардлагатай арга хэмжээг авч ажиллах; Хууль ёсны хугацаанд заасны дагуу төсөл үргэлжлэх хугацаанд буурсан хүлэмжийн хийн ялгарлын үр дүнд үндэслэн Япон Улсын Байгаль Орчны яамнаас шийдвэрлэсэн хувь хэмжээгээр тооцсон ХКОМ-ын кредитийг Японы Засгийн газарт тооцуулах;
  - VI. Загвар төслийн хугацаа дууссаны дараа Япон улсын хуульд зааснаар тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг санхүүгийн дэмжлэгийн зорилгод нийцүүлэн үр ашигтай үргэлжлүүлэн хэвийн явуулахад анхаарах.
  - VII. Олон улсын консорциумын хүрээнд төсөлд оролцогч талуудын бүрэлдэхүүн солигдож дээрх I. – VII.-д заасан нөхцлүүдийг биелүүлэх боломжгүй тохиолдолд ДДБОТС-д мэдэгдэх.
- c) Консорциумын гишүүн тоног төхөөрөмж түрээсээр авч буй тохиолдолд дараах хариуцлагыг хүлээнэ:

Хэрэв консорциумын гишүүн (түрээслүүлэгч) өөр нэг консорциумын гишүүнд (түрээслэгч) тоног төхөөрөмжөө түрээслүүлж буй тохиолдолд түрээсийн гэрээ болон холбогдох түрээсийн тооцооны мэдээллийг, хөтөлбөрийн хүрээнд үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн хэмжээг, тоног төхөөрөмжийн түрээсийн дүнгээс хассан эсэхийг баталгаажуулах үүднээс ДДБОТС-д санхүүжилт хүссэн өргөдлийн

материалуудад хавсарган өгнө. Төслийн хэрэгжилтийн хугацаа дуусахаас өмнө түрээсийн хугацаа дуусахаар байвал түрээслүүлэгч нь түрээсийн гэрээг сунгах эсвэл төхөөрөмжийг түрээслэгчид шилжүүлж өгөх хүртэл төслийн хэрэгжилтийн хугацааны туршид төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хариуцна.

d) Хил дамнасан хэсэгчилсэн төлбөрийн нөхцөлтэй худалдаа

Хэрэв консорциумын гишүүн өөр нэг консорциумын гишүүнд тоног төхөөрөмжөө хил дамнасан хэсэгчилсэн төлбөрийн нөхцөлтэйгээр худалдаалж буй тохиолдолд. ('хил дамнасан хэсэгчилсэн төлбөрийн нөхцөлтэй худалдаа' гэдэг нь төлбөрийн нөхцөл нь хойшлуулсан борлуулалтыг эсвэл хил дамнуулан явуулдаг төлбөрийн нөхцөл нь хэсэгчилсэн хэлбэрээр явагдах худалдааг хэлнэ.) Хэрэв төлбөрийн гүйлгээний эхэн үеэс өмчлөл шилжсэн бол үлдэгдэл төлбөрийн нөхцлийн дэлгэрэнгүй мэдээллийг, төслийг хэрэгжүүлж буй тоног төхөөрөмжийн эзэмшигч ХКОМ-ын загвар төслөөс үзүүлж буй санхүүгийн дэмжлэгийн үр шимийг хүртэж буйг баталгаажуулах үүднээс, ДДБОТС-д санхүүжилт хүссэн өргөдлийн материалуудад хавсарган өгнө. Энэ тохиолдолд борлуулагч тал байршуулсан төлбөрийг хүүгийн төлбөртөө тооцуулан авах боломжтой. Мөн дараах зүйлийг анхаарна:

- I. Хэрэв тухайн төслийг төлөөлж буй тал хэсэгчилсэн төлбөрийн нөхцөлтэй борлуулалтыг хийсэн бол дээрх (a) хэсэгт дурдсан шаардлагыг мөн биелүүлнэ.
- II. Хэрэв тухайн төслийг төлөөлж буй талаас өөр, Япон улсын эсвэл гуравдагч улсын байгууллага хэсэгчилсэн төлбөрийн нөхцөлтэй борлуулалтыг хийсэн бол худалдан авагч төлбөрөө төлж дуустал тухайн борлуулагч компани нь олон улсын консорциумын гишүүнээр байх шаардлагатай.
- III. Дээрх аль аль тохиолдолд (I болон II) буюу олон улсын консорциумын гишүүн бус талаас төхөөрөмжийг худалдан авахад санхүүжилтэд хамрагдсан зардлыг тооцоолох үндэс нь өөрчлөгдөхгүй болно.

e) ХКОМ-ын Эко Түрээсийн Схем

Төсөлд оролцогч талууд санхүүгийн дэмжлэгтэй дүйцэх хэмжээний дүн нь анх санал оруулахад өгсөн түрээсийн гэрээнээс (гэрээний төсөл) хассаныг нотлох баримт бичгийг (түрээсийн төлбөрийн задаргаа) ирүүлнэ.

### 5.2.5 САНХҮҮЖИЛТЭНД ХАМРАГДАХ ЗАРДАЛ

Загвар төсөл нь дараах зардлын санхүүжилтыг олгоно. Зөвхөн тухайн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан зардлуудыг хянаж шалгасны дүнд санхүүжилт олгоно. ХКОМ-ын Эко Түрээсийн схемийн тухайд тоног төхөөрөмжийн түрээсийн төлбөр болон түрээсийн хүүнд санхүүжилт олгоно.

#### Тайлбар 2.

Санхүүжилтэнд хамрагдах боломжтой зардлууд

- a) Барилга угсралтын ажлын зардал
- b) Туслах ажлын зардал
- c) Машин, хэрэгслийн зардал
- d) Судалгаа, шинжилгээний зардал
- e) Тоног төхөөрөмжийн зардал (төхөөрөмжийг хянахтай холбоотой зардал орно)
- f) Холбогдох захиргааны ажлын зардал
- g) Даян дэлхийн байгаль орчны төв сангаас баталгаажсан бусад зардлууд

#### Тайлбар 3.

Санхүүжилтэнд хамрагдах боломжгүй зардлууд

- a) Хуучин тоног төхөөрөмжийг солихтой холбоотой зардлууд
- b) Загвар төслийн төхөөрөмжинд засвар үйлчилгээ хийхтэй холбоотой материал, хэрэгслийн зардлууд; түргэн тусламжийн хэрэгслүүд, аюулгүйн ажиллагааны хэрэгслүүд (гал унтраагч, аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэл гэх мэт) болон аюулгүй байдлын тоног төхөөрөмж
- c) Барилга угсралт, барилгын инженерийн ажил (үүнд эрчим хүчтэй холбоотой нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулахтай шууд холбогдох бүтцийн ажил хамаарахгүй)
- d) Үйл ажиллагааг сэргээх үйлдэлтэй холбоотой зардал, хуучин төхөөрөмжийг шинэчлэн суурилуулалт хийх үед үйл ажиллагааг сэргээх зэрэг
- e) Сэлбэг хэрэгслүүдийн зардал (туршилт, ашиглалтын сэлбэг хэрэгслүүд үүнд хамаарахгүй)
- f) Загвар төслийн хүрээнд ДДБОТС-д хүлээлгэн өгөх тайлан гаргах болон төслийн талбайд үзлэг хийхтэй холбоотой зардлууд
- g) Гэрээг солилцох болон шилжүүлэг хийхтэй холбоотой зардал
- h) Газар худалдан авах, эзэмшихтэй холбоотой зардал

## Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн худалдан авахдаа ашиг хасах

Загвар төслүүдэд үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэг нь төсөлд оролцогч талын өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалттай холбоотой төлбөрийг багтаасан зардлыг төлөвлөсөн байвал зах зээлийн үнээр худалдаа хийж болно. Гэхдээ, санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцогчдын ашиг тусыг оруулах зардалд хамруулах нь зохисгүй гэж үздэг. Тиймээс оролцогч компаний компанийн өөрийн бүтээгдэхүүн гэх мэтийг худалдан авахдаа дүнг “өртгөөр” (худалдан авсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өртөг г.м) бүртгэнэ.

\* Оролцогчдын компанийн бизнесийн төрлөөс шалтгаалан үйлдвэрлэлийн өртгийг тооцоолоход хэцүү бол бусад үндэслэлтэй тайлбар бүхий өртөгийг хүлээн зөвшөөрч болно.

### 5.2.6 САНХҮҮЖИЛТИЙН ХЭМЖЭЭ

Загвар төсөл болон хамтарсан инновацийг дэмжих хөтөлбөрийг санхүүжүүлэх төсвийн нийт хэмжээ 3 жилийн хугацаатай 8.3 тэрбум Япон иен. Загвар төсөлд санал болгож буй санхүүжилтийн хэмжээ нь зарчмын хувьд 2 тэрбум иен дотор байх ёстой. ХКОМ-ын Эко Түрээсийн схемийн хүрээнд нэг загвар төслийн санал болгож буй санхүүжилтийн нийт хэмжээ 3 жилийн хугацаатай 500 сая иен байна.

Загвар төслийн санхүүжилтийн хэмжээг тооцохдоо хамрагдах боломжтой зардлын нийт дүнг Хүснэгт 3-т заасан хувиар үржүүлнэ.

ХКОМ-ын Эко Түрээсийн схемийн санхүүжилтийн хэмжээг тооцохдоо түрээсийн зардлыг (тоног төхөөрөмжийн зардал болон холбогдох түрээсийн хүүгийн төлбөр ороод) санхүүжилтийн хувь хэмжээ буюу 10%-иар үржүүлж тооцоолно.

Түүнээс гадна санхүүгийн дэмжлэгийн бодит хэмжээг тооцохдоо төслийг хэрэгжүүлэхэд бодитоор зарцуулж баталгаажсан нийт зардлын хэмжээн дээр үндэслэн тодорхойлно. Зардлын хэмжээний тухай төслийн төлөөлөн оролцогчид бичгээр мэдэгдсэн байх хэрэгтэй. Зардлыг зарцуулахаас өмнө өөр зарцуулалт байх ёсгүй.

## 5.2.7 САНХҮҮЖИЛТИЙН ДЭЭД ХЭМЖЭЭ

Санхүүжилтийн дээд хэмжээг тооцоходоо тухайн улсад ижил төстэй технологи ашиглан хэрэгжүүлж буй нийт сонгогдсон төслүүдийн тоон дээр үндэслэн тодорхойлно. Сонгогдсон төслүүдийн тухай дэлгэрэнгүйг Хавсралт 3-аас (технологийн төрөл зүйлийн ангилал, тухайн улсад хэрэгжүүлж буй ХКОМ-ын загвар төслийн тоо баримт) харна уу.

**Хүснэгт 3:** Тухайн улсын ижил төстэй төслийн тооноос хамаарах санхүүжилтийн хувь хэмжээ

Улс тус бүрийн ижил төстэй технологи ашиглан хэрэгжүүлж буй нийт сонгогдсон төслүүдийн тоо	Санхүүжилтийн хувь хэмжээ
Байхгүй (0)	50% хүртэл (ДДБОТС тодорхойлсноор)
3 хүртэлх (1 -3)	40% хүртэл (ДДБОТС тодорхойлсноор)
4-өөс дээш (>4)	30% хүртэл (ДДБОТС тодорхойлсноор)

Нэг доролон төрлийн технологийг нэвтрүүлэх гэж байгаа тохиолдолд, санхүүгийн дэмжлэгийн дээд хувь хэмжээг технологи тус бүрээр тооцно.

ХКОМ-ын Эко Түрээсийн схемийн санхүүжилтийн тогтмол хувь хэмжээ нь 10%. Санхүүжилтийн дээд хэмжээ болон хувь хэмжээг санхүүгийн гэрээн дээр зааж оруулна.

## 5.2.8 ЗАГВАР ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Загвар төслийн хэрэгжилтийн хугацаа, барилга байгууламж, тоног, төхөөрөмжийн суурилуулалт болон холбогдох бүх төлбөрийн төлөлт хийгдэх хугацаа нь Санхүүгийн Гэрээний Мэдэгдэл дээр заасан өдрөөс эхлэн хамгийн уртдаа 2024 оны 1 дүгээр сарын 31-ыг (2021 онд тухайн төсөл хэрэгжихээр сонгогдсон тохиолдлоор жишээ авахад) дуустал байна. Заагдсан хугацаанаас өмнө эсвэл хойно хийгдсэн гэрээ болон худалдан авалт нь загвар төслийн санхүүжилтэд хамрагдахгүй.

## 5.2.9 ТӨЛӨВЛӨГӨӨ/ХУВААРЬ

ХКОМ-ын төслийн өргөдлийг тухайн санхүүгийн жилийн 4 дүгээр сарын 6-ний өдрөөс 10 дугаар сарын 30-ны хооронд ирүүлнэ. (Төсвийн үлдэгдлээс хамааран өргөдөл хүлээн авах хугацаа эрт дуусч болно.)

**Хүснэгт 4:** Санхүүгийн жилийн төлөвлөгөө/хуваарь (2021 оноор жишээ авав)

<b>Хугацаа</b>	
<b>Япон улсын санхүүгийн жил 2020</b>	
2021 оны 4 сарын 7, Лхагва	Төслийн сонгон шалгаруулалтыг зарлах (жилийн турш явагдана)
2021 оны 5 сарын 10, Даваа	Загвар төслийн эхний сонгон шалгаруулалт дуусах хугацаа
Эхний сонгон шалгаруулалтын хугацаа дууссанаас 4 долоо хоногийн дотор	Төслүүдийг хянах Ярилцлага хийх (Токио хотод, Япон талын хуулийн этгээдтэй)
6 сарын сүүлчээр	Загвар төслүүдийг урьдчилсан байдлаар сонгох (ДДБОТС-ийн үнэлгээнд үндэслэн) Сонгогдсон төслүүдийн оролцогч танилцуулга мэдээлэл хийх
Урьдчилсан шалгаруулалтын дараагаас 30 хоногийн дотор	Санхүүгийн дэмжлэгийн гэрээ байгуулахад шаардлагатай төслийн баримт бичгийг ирүүлнэ
Урьдчилсан шалгаруулалтын дараа 60 хоногийн дотор	Японы талын төсөлд оролцогч талтай санхүүжилтийн гэрээ хийх мэдэгдэл ирнэ. (ДДБОТС-ийн үнэлгээнд үндэслэн) Загвар төсөл хэрэгжиж эхлэнэ.
	Хоёр дах шатны буюу 5 сарын 10-аас хойш ирүүлсэн төслийн саналыг эхний шатны сонгон шалгаруулалт дууссаны дараа хянаж эхэлнэ. Хянаж эхэлснээс хойш 2 сарын дотор ДДБОТС-аас үр дүнг танилцуулна.
2021 оны 10 сарын 29, Баасан	Төслүүдийн саналыг хүлээн авч дуусна. (Тухайн жилд төсөвлөсөн санхүүжилтийн үлдэгдлээс хамааран өргөдөл хүлээн авах хугацаа эрт дуусч болно)
2022 оны 2 сарын эцэс гэхэд	(1 жилийн хугацаатай төсөл) Загвар төслүүд хэрэгжиж дуусна. (Тоног төхөөрөмжийн суурилуулалт, төлбөр тооцоо хийгдсэн байна)
2022 оны 2 сараас 3 сар хүртэл	(1 жилийн хугацаатай төсөл) - Төслийн эцсийн тайланг илгээнэ (2022 оны 3 сарын 10-ны гэхэд ирүүлсэн байна) - ДДБОТС-аас хяналт шинжилгээний ажил хийгдэнэ. (баримт бичгийн болон шаардлагатай гэж үзвэл төслийн талбайд биеэр очих, цахимаар)
	(2 эсвэл 3 жилийн хугацаатай төслүүд) - Төслийн дунд үед ДДБОТС-аас хяналт шинжилгээний ажил хийгдэнэ. (баримт бичгийн болон төслийн талбайд биеэр очих) - Төслийн дунд үеийн тайлан (2022 оны 4 сарын 10-ны дотор) (Шалгалтын явцад олон улсын консорциумын гишүүдээс, тухайлбал төслийн төлөөлөх талаас (Япон тал) оролцох ёстой)



<b>Япон улсын санхүүгийн жил 2022</b>	
2022 оны 4 сар	2021 оны санхүүгийн жилд зарцуулсан санхүүгийн дэмжлэгийг олгоно. (ДДБОТС-ийн шалгалтад үндэслэн)
2023 оны 2 сарын эцэс	(2 жилийн хугацаатай төсөл) Загвар төсөл хэрэгжиж дуусна. (Тоног төхөөрөмжийн суурилуулалт, төлбөр тооцоо хийгдсэн байна)
2022 оны 2 сараас 3 сар	(2 жилийн хугацаатай төсөл) <ul style="list-style-type: none"> <li>- Эцсийн шатны тайлангуудыг оруулна (2023 оны 3 сарын 10-ны дотор)</li> <li>- ДДБОТС хянан шалгана. (баримт бичгийн болон шаардлагатай гэж үзвэл төслийн талбайд биеэр очих, цахимаар)</li> <li>- (3 жилийн хугацаатай төслүүд)</li> <li>- Төслийн дунд үед ДДБОТС-аас хяналт шинжилгээний ажил явагдана. (баримт бичгүүдийг болон шаардлагатай тохиолдолд тухайн газар дээрхи үзлэг шинжилгээ гэх мэт)</li> <li>- Төслийн дунд үеийн тайлан (2023 оны 4 сарын 10-ны дотор)</li> </ul>
<b>Япон улсын санхүүгийн жил 2023</b>	
2023 оны 4 сар	2022 оны санхүүгийн жилд зарцуулсан санхүүгийн дэмжлэгийг олгоно. (ДДБОТС-ийн шалгалтад үндэслэн)
2024 оны 1 сарын эцэс	(3 жилийн хугацаатай төсөл) <ul style="list-style-type: none"> <li>- Төслийн эцсийн тайланг илгээнэ. (2024 оны 3 сарын 10 гэхэд ирүүлсэн байна)</li> <li>- ДДБОТС хянан шалгана. (баримт бичгийн болон шаардлагатай гэж үзвэл төслийн талбайд биеэр очих, цахимаар)</li> </ul> (Шалгалтын явцад олон улсын консорциумын гишүүдээс, тухайлбал төслийн төлөөлөх талаас (Япон тал) оролцох ёстой)
2024 оны 3 сар	Санхүүгийн дэмжлэгийг олгоно (ДДБОТС-ийн шалгалтад үндэслэн)

## 5.3 ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ БОЛОН ҮНЭЛГЭЭ

### 5.3.1 ЗАГВАР ТӨСЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

ДДБОТС нь санал оруулсан төслүүдийн хяналт шинжилгээг 5.8-д заасан 'ХКОМ-ын загвар төслүүдийг сонгох үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд'-ийн дагуу хариуцан ажиллана. (цаашид "үнэлгээний шалгуур үзүүлэлт" гэх).

### 5.3.2 ТӨСЛҮҮДИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Эхлээд үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 1-д заасан Шаардлагыг хангаж буй эсэхийг шалгана. Үүний дараа ДДБОТС-аас үнэлгээний шалгуур үзүүлэлтийн 2-д заасан Үнэлгээний журмын дагуу шалгана. Сонгон шалгаруулалтын явцад ДДБОТС-аас нэмэлт материал шаардаж болно. Материал хүлээн авснаас хойш шаардлагатай үед ярилцлага хийнэ.

### 5.3.3 СОНГОГДСОН ЗАГВАР ТӨСЛҮҮДИЙГ МЭДЭЭЛЭХ

ДДБОТС-аас сонгогдсон загвар төслүүдийг төсөлд оролцогч талуудад мэдэгдэх бөгөөд сонгогдсон төслүүдийн талаарх мэдээлэл Японы Байгаль Орчны яам болон ДДБОТС-ын цахим хуудсуудад тавигдан олон нийтэд нээлттэй болно (Төсөлд оролцогч талуудын нэр, улс, төслийн нэр мөн төлөвлөж буй хүлэмжийн хийн ялгарлын бууралтын мэдээлэл гэх мэт).

ДДБОТС-аас сонгогдоогүй төслүүдийн талаар төсөлд оролцогч талуудад мэдэгдэнэ. Төслийг татгалзах болсон шалтгааны талаар дэлгэрэнгүй мэдээлэх боломжгүй.

## 5.4 СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДАРААХ ҮЕ ШАТ

### 5.4.1 САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ АВАХ ГЭРЭЭНИЙ ӨРГӨДӨЛ/ХҮСЭЛТ

Сонгогдсон загвар төсөлд оролцогч талууд ДДБОТС-тай байгуулах Санхүүгийн дэмжлэгийн гэрээний материалыг бүрдүүлж өгнө. Хэрвээ баримт бичгийн боловсруулалт бүрэн гүйцэд биш тохиолдолд өргөдлийг дахин хянах, эсвэл дахин илгээх шаардлагатай.

### 5.4.2 САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ГЭРЭЭНИЙ ДҮГНЭЛТ

ДДБОТС хүлээн авсан баримт бичгийг хянан шалгаж баримт бичгийн бүрдүүлэлт дууссаны дараа төсөлд оролцогч талуудтай Санхүүгийн дэмжлэгийн гэрээг байгуулна. Сонгогдсон загвар төслийг зарласан өдрөөс хойш 60 хоногийн дотор буюу Японы санхүүгийн жилд багтаан ДДБОТС-аас хамааралгүй шалтгаанаар Санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээг байгуулах боломжгүй тохиолдолд ДДБОТС сонгогдсон загвар төслийг цуцлах магадлалтай. ДДБОТС-аас санхүүжилтийн гэрээг хянах хугацаа 30 хоног байдгийг анхаарна уу. Тиймээс, төсөлд оролцогч талууд загвар төслөөр сонгогдсоноос хойш 30 хоногийн дотор бичиг баримтаа бүрдүүлж өгсөн байх шаардлагатай.

### 5.4.3 ЗАГВАР ТӨСЛИЙГ ЭХЛҮҮЛЭХЭД АНХААРАХ ЗҮЙЛС

Загвар төслийг зөвхөн Санхүүгийн дэмжлэгийн гэрээг хийснээс хойш эхлэх боломжтой. Төсөлд оролцогч талууд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай:

- a) Төсөлд оролцогч талууд болон бусад аж, ахуйн нэгжүүд хоорондын загвар төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэрээнүүдийн он, сар, өдөр нь Санхүүгийн дэмжлэгийн гэрээг хийсэн өдрөөс хойш хийгдсэн байх шаардлагатай.
- b) Төсөлд оролцогч талууд дээр дурдсан гэрээг хийхдээ бусад аж ахуйн нэгжийг өрсөлдөөнт зарчмаар сонгон шалгаруулахыг анхаарна.
- c) Мөн дээрх гэрээнүүдийн хүрээнд бусад аж, ахуйн нэгжүүдэд төлөгдөх төлбөрийг санхүүгийн жилийн төгсгөлд хийнэ.

### 5.4.4 ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ БОЛОН ХЭРЭГЖИЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

1. Хэрэв төсөлд оролцогч талууд ямар нэгэн шалтгаанаар төслийн хэрэгжилтийн төлөвлөгөө болон санхүүжилтийн дэмжлэгт өөрчлөлт оруулахаар бол энэ тухай албан ёсоор бичгээр ДДБОТС-д урьдчилан хүсэлт гаргаж зөвшөөрөл авах шаардлагатай.
2. Санхүүжилтийн дэмжлэгт өөрчлөлт ороогүй тохиолдолд ч төсөлд оролцогч талууд доор дурдсан өөрчлөлтүүдэд ДДБОТС-ээс зөвшөөрөл авна.
  1. Хамгийн бага зардлын 15%-д өөрчлөлт орохоос бусад өөрчлөлтүүд (үүнд ангилал тус бүрт хуваарилсан зардлын хувь хэмжээг өөрчлөх орно).
  2. Дараах жижиг өөрчлөлтүүдээс бусад тохиолдолд хэрэгжүүлэх төлөвлөгөөг өөрчлөх.
    - a) Төслийн зорилгод болон оролцогчдын бүтээлч байдал дээр суурилсан үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр өөрчлөлт оруулахгүй.
    - b) Төслийн зорилго болон төслийн үр ашигтай байдалтай холбоотой бус байдлаар хэрэгжилтийн төлөвлөгөөнд бага хэмжээний өөрчлөлт оруулах.

- с) Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хэмжээ болон ХКОМ-ын кредит тооцох тооцоололд өөрчлөлт оруулах

#### 5.4.5 ЗАРДАЛ/ӨРТӨГ

Загвар төслөөс санхүүжүүлж буй зардлын хувьд, төсөлд оролцогч талууд санхүүгийн дэвтрийг хөтлөнө. Уг дэвтэрт санхүүжилтэнд ороогүй бусад зардал/өртгийг мөн тусад нь салган оруулж өгөхөөс гадна орлого зарлагын мэдээллийг холбогдох баримтуудын хамт хавсарган оруулна.

Загвар төсөл дууссанаас хойш эдгээр санхүүгийн баримт бичгүүдийг 5 жилийн турш хадгална.

#### 5.4.6 ТАЙЛАНГЫН БҮРДҮҮЛЭЛТ БОЛОН ХОЛБОГДОХ ХЯНАН ШАЛГАЛТ

- а) ЖИЛ БҮРИЙН ЭЦЭСТ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ГАРГАХ

Төсөлд оролцогч талууд санхүүгийн жил бүрийн төгсгөлд буюу 4 сарын 10-ны дотор ДДБОТС-д тайлан хүргүүлнэ.

- б) ЗАГВАР ТӨСЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

Төсөлд оролцогч талууд загвар төсөл дууссаны дараа 30 хоногийн дотор эсвэл жил бүрийн 3 сарын 10-ны дотор (жишээ: 2021 оны Японы санхүүгийн жил нь 2 сарын 28-ны дотор, 3 жилийн хугацаатай төслийн сүүлийн жилд) төслийн эцсийн тайланг хүргүүлнэ. Загвар төслийн эцсийн тайланг тавих үед төслийн холбогдох гэрээнүүдтэй хамааралтай бусад байгууллагад төлөх төлбөрүүдийг төлсөн байх шаардлагатай.

Төсөлд оролцогч талууд төслийн гүйцэтгэлийг тайлагнахдаа барилгын ажил, түүний үр дүнгийн дагуу төлбөрийг хийж, нэхэмжлэх, баримтыг хавсаргах шаардлагатай. Төсөлд оролцогч талаас гүйцэтгэлийн тайлан ирүүлэх үед ДДБОТС нь төслийн үр дүн санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний агуулгатай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах зорилгоор баримт бичгийг хянах, шаардлагатай бол хяналт шалгалтыг хийнэ. ДДБОТС гэрээний нөхцөлтэй нийцэж байна гэж үзвэл ДДБОТС-аас тухайн төсөлд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тодорхойлж, төсөлд оролцогч талуудад мэдэгдэнэ.

### 5.4.7 САНХҮҮЖИЛТ ОЛГОХ

ДДБОТС хүсэлтийг хүлээн авсны дараа тухайн газар дээр шалгалт хийснээс хойш дараагийн Японы санхүүгийн жилийн 4 сарын 30-ны дотор төсөлд оролцогч талуудад санхүүжилтийг олгоно. Мөн түүнчлэн төсөлд оролцогч талууд төслийн хэрэгжилтийн дунд үед санхүүжилт хүсэхдээ тухайн төслийн дууссан хэсэгт үндэслэн олгох санхүүжилт хүсэх процесс ижил байна.

Санхүүжилтийн эцсийн төлбөрийг олгохдоо төслийн хэрэгжилтийн дунд үед олгогдсон санхүүжилтийг эцсийн төлбөрөөс хасан оролцогч талуудад олгоно. Гэхдээ төслийн хэрэгжилтийн дунд үед олгогдсон санхүүжилтийн хэмжээ нийт санхүүгийн дэмжлэгийн үнийн дүнгээс давсан тохиолдолд зөрүүг оролцогч талууд буцаан төлнө.

### 5.4.8 ХУДАЛДАН АВСАН ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТ

Төсөлд оролцогч талууд загвар төслийн хүрээнд худалдан авсан эд хөрөнгийн менежментийн (цаашид 'хөрөнгө' гэх) тал дээр бүртгэл тооцооны дэвтрийг хөтлөн жил бүр ЯБОЯ-нд тухайн хөрөнгөтэй холбогдох тайланг явуулна.

Төсөлд оролцогч талууд загвар төсөл хэрэгжиж дуусахад ашигласан барилга байгууламж, тоног төхөөрөмжийн хүрээнд хүлэмжийн хийн ялгарлаа бууруулсан байна. Хэрвээ үр дүнд хүрээгүй тохиолдолд шалтгааныг нь тайландаа тайлбарлан тусгана. Хэрэв төсөлд оролцогч талууд загвар төслөөс өөр зорилгоор хөрөнгийг ашиглах, борлуулах, солих, түрээслэх, барьцаалах, задаргаа хийх, хаях, үрэгдүүлэх (зөвхөн 500,000 иен ба түүнээс дээш нэгжийн үнэтэй тоног төхөөрөмж, байгууламж) тохиолдолд ДДБОТС-аас зөвшөөрөл авна.

Төсөлд оролцогч талууд тухайн үл хөдлөх хөрөнгийг барьцаалахаар бол ДДБОТС-аас холбогдох зөвшөөрөл авна. Энэ тохиолдолд, санхүүжилт буцаагдах эрсдэлтэйг анхаарна уу. Түүнчлэн, ДДБОТС-аас тоног төхөөрөмжийг задлах, хаях зөвшөөрөл өгсөн ч дээр 2(1)(с) бүлэгт заасны дагуу тухайн тоног төхөөрөмжийг унтраахаас өмнөх үр дүн буюу хийн ялгарлын бууралтанд үндэслэн кредит тооцох хүсэлтийг гаргана.

Хэрэв загвар төслийн зорилтын хүрээнд төсөлд оролцогч талууд тоног төхөөрөмжийг олон улсын консорциумын бусад гишүүдэд хэрэглүүлэх, зарах, солих эсвэл түрээслүүлэх тохиолдолд ДДБОТС-д

өмнө нь мэдэгдэнэ. Төслийн бүх тоног төхөөрөмж дээр Монгол-Японы ХКОМ-ын Загвар төслийн эд хөрөнгө гэсэн хаяг наалттай байна.

#### 5.4.9 ОЛОН УЛСЫН КОНСОРЦИУМЫН ГИШҮҮДЭД ӨӨРЧЛӨЛТ ОРОХ

Загвар төсөл дууссанаас хойш хуулийн хугацаанд төсөлд оролцогч талуудын хаяг, нэр солигдох болон бусад байгууллагатай нэгдсэн тохиолдолд төсөлд оролцогч талууд энэ тухайгаа ДДБОТС-д цаг алдалгүй мэдэгдэнэ.

#### 5.4.10 САНХҮҮЖИЛТИЙН ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

Хэрэв төсөлд оролцогч талууд дараах зөрчлийг гаргасан тохиолдолд санхүүжилтийн гэрээг хэсэгчлэн эсвэл бүтэн цуцлана. Энэ тохиолдолд төсөлд оролцогч талууд олгогдсон санхүүжилтыг хэсэгчлэн эсвэл бүтнээр буцааж төлнө. Гэхдээ (d) тохиолдолд энэ нөхцөл нь төслийн аль хэдийн батлагдсан хэсэгт хамаарахгүй

- a) Холбогдох хууль, санхүүгийн дүрэм журам эсвэл ДДБОТС-ын зааврыг зөрчих
- b) Загвар төсөлд хамааралгүй зүйлд санхүүжилтийг зарцуулах
- c) Зохисгүй үйлдэл гаргах
- d) Санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ байгуулагдсаны дараа үүссэн байгалийн гамшиг, бусад хүчин зүйлийн улмаас загвар төслийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн үргэлжлүүлэх боломжгүй болсон, эсвэл төсөлд оролцогч талуудаас шалтгаалахгүйгээр загвар төслийг хэрэгжүүлэх боломжгүй болох

#### 5.4.11 ШУДАРГА БУС ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ ТОРГУУЛЬ

Хуурамч материал бүрдүүлэх, Японы Засгийн газраас өөр тусламж дэмжлэг авах болон хууль зөрчсөн тохиолдолд Санхүүжилтийн гэрээг цуцлах буюу санхүүжилтыг буцаана.

## 5.5 ТӨСЛИЙН САНАЛЫГ ОРУУЛАХ

### 5.5.1 САНАЛЫГ ХЭРХЭН ОРУУЛАХ ВЭ?

Төслийн саналыг бүрэн гүйцэд баримт бичгийн хамт ДДБОТС-ын Токио хот дах төв оффист битүүмжилсэн дугтуйнд хийн шуудангаар илгээх буюу электрон хэлбэрээр (CD-R or DVD-R) хүргүүлнэ. Факс, и-мэйл болон интернэтээр материалыг хүлээн авахгүй. Төслийн саналыг Япон хэл дээр бичнэ.

### 5.5.2 САНАЛЫГ ОРУУЛАХ ХУГАЦАА

#### Тайлбар 4.

#### Хугацаа

(жил бүрийн 10 дугаар сарын сүүлийн өдөр)

Жишээ нь: 2021 оны 10 дугаар сарын 29 (12:00 Японы цагаар)

- Төсвийн үлдэгдлээс хамааран санал хүлээн авах хугацаа эрт хаагдах боломжтой.
- ДДБОТС нь 10:00–12:00 болон 13:00–17:00 цагуудад материал хүлээн авна. (Бямба, Ням болон баярын амралтын өдрүүдээс бусад)

### 5.5.3 БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

Төслийн саналаа дараах материалуудын хамт бүрдүүлэх шаардлагатай. Төслийн санал бичих загварыг дараах цахим хуудаснаас татаж авах боломжтой. <http://gec.jp/jcm/jp/kobo/mp210407> (зөвхөн Япон хэл дээр) Бүрэн гүйцэд бүрдүүлсэн төслийн саналыг 2% CD-R, DVD-R-нд хуулан электрон хэлбэрээр бүх баримт бичгийн хамт хавсарган хүргүүлнэ.

- Маягт №1 Өргөдлийн маягт
- Маягт №2 Төлөөлж буй талын мэдүүлэг
- Маягт №3а Төслийн хэрэгжилтийн төлөвлөгөө
  - (10) хуудсанд багтаан бичнэ. Жагсаалтын (Маягт №6) дагуу туслах материалуудыг хавсаргана.
- Маягт №3б ХКОМ-ын Загвар төслийн саналын хуудас
  - Энэхүү баримт бичгийг, төслийг хэрэгжүүлэх улсын Засгийн газар болон ХКОМ-ыг хариуцан ажиллаж байгаа талуудад

хүргүүлж болно. Төсөл хэрэгжүүлэгч улсын Засгийн газар төсөлтэй холбоотой тодруулгыг хүсэх эрхтэй.

- e) Маягт №4 Төсөв (төсвийн үнийн санал болон дагалдах баримт бичгүүдийн хамт)
- f) Байгууллагын мэдээлэл (компанийн танилцуулга) мөн төлөөлж буй тал болон оролцогч талуудын хоорондын хамтын ажиллагааны баримт бичиг
  - Хэрэв төслийн саналаа ирүүлэх үед хамтарсан компани хараахан байгуулагдаж амжаагүй тохиолдолд төсөлд оролцогч талууд батлагдсан эсвэл батлагдах гэж байгаа хамтын ажиллагааны төслийг өгч болно. Компани байгуулах төсөл мөн хийгдэж амжаагүй байгаа тохиолдолд төсөлд оролцогч талууд бизнесийн тодорхойлолт буюу хуулийн дагуу хамтран ажиллах баримт бичгийг үзүүлэх шаардлагатай.
- g) Төлөөлж буй тал болон хамтрагч байгууллагуудын санхүүгийн тайлан (аудитаар баталгаажуулсан, сүүлийн 3 жилийн).
- h) Олон улсын консорциумын гэрээ

Олон улсын консорциумын гэрээний төсөл болон гарын үсэг зурах хүртэлх статус. Гарын үсэг зурсан гэрээг Санхүүжилтийн гэрээний өргөдлийг өгөхдөө хавсарган оруулна.
- i) Маягт №5 ХКОМ-ын кредит хуваах гэрээ
  - Гарын үсэг зурж баталгаажсан гэрээ байх.
- j) Маягт №6 Төслийн санал оруулах материалуудын жагсаалт
- k) Бусад холбогдох баримт бичиг

---

\* Баримтын өгөгдлийг тоон дарааллаар файлын нэртэй, шалгах хуудасны тоогоор хадгална [Маягт 6].

\* Электрон хэлбэрээр ирүүлж байгаа CD-R, DVD-R дээр шошгон дээр өргөдөл гаргагчийн нэр, улсын нэр, төслийн нэрийг бичнэ.

Нэмж дурдахад, үнэлгээний явцад өргөдөл гаргагч тал шаардлагатай бол утас эсвэл имэйлээр холбоо барьж болно. Энэ тохиолдолд нэмэлт бичиг баримт бүрдүүлэх шаардлагатайг анхаарна уу.

---



#### 5.5.4 САНАЛЫГ ХҮРГҮҮЛЭХ ХАЯГ

Төслийн материалыг доорх хаягаар илгээнэ:



Шуудангийн хаяг: Даян Дэлхийн Байгаль Орчны Төв сан, Токио хот дах оффис (ДДБОТС)

4th floor, Hongo Ozeki Bldg., 3-19-4 Hongo Bunkyo-ku, Tokyo 113-0033, Japan

#### 5.5.5 АСУУЛТ, ХАРИУЛТ

Тодруулах асуулт байвал дараах хаягаар явуулна: [jcm-info@gec.jp](mailto:jcm-info@gec.jp)

#### 5.5.6 ХКОМ-ЫН СХЕМЭЭС ХАМТАРСАН ИННОВАЦИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХӨТӨЛБӨРТ ШИЛЖИХ

ХКОМ-ын Загвар төсөлд хамрагдахаар өргөдөл өгсний дараа, сонгон шалгаруулалтын явцад тухайн төсөл нь Хамтарсан Инновацийг Хэрэгжүүлэхэд Чиглэсэн Нүүрстөрөгчгүй Технологийг Үзүүлэх Төслийн Санхүүжилтийн Хөтөлбөр хамрагдах боломжтой гэж үзвэл өргөдлөө тухайн хөтөлбөрийн хүрээнд өөрчлөх боломжтой. Энэ тохиолдолд загвар төслийн хүрээнд ирүүлсэн өргөдлийг түдгэлзүүлнэ.

Загвар төсөл болон Хамтарсан Инновацийг Хэрэгжүүлэхэд Чиглэсэн Нүүрстөрөгчгүй Технологийг Үзүүлэх Төслийн Санхүүжилтийн Хөтөлбөрт нийтлэг зүйлүүд олон байдаг тул Хамтарсан инновацийн санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдах өргөдлийг бэлдэхэд хялбар байх болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг Хамтарсан инновацийн санхүүжилтийн хөтөлбөрийн удирдамжаас харна уу.

Хамтарсан инновацийн санхүүжилтийн хөтөлбөрийн талаар холбоо барих:



Даян Дэлхийн Байгаль Орчны Төв сан, Токио хот дах оффис (ДДБОТС)

3rd floor, Hongo Ozeki Bldg., 3-19-4 Hongo Bunkyo-ku, Tokyo 113-0033, Japan

Имэйл: [inov@gec.jp](mailto:inov@gec.jp)

## 5.6 МЭДЭЭЛЛИЙН ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

ДДБОТС-д хүлээлгэн өгсөн санхүүгийн баримт бичиг болон дагалдах баримт бичгүүд (нэхэмжлэх, гэрээ, төлбөрийн баталгаа гэх мэт) эдгээрийн электрон хувилбаруудыг Санхүүгийн дүрэм журамд заасны дагуу хянамгай хадгалж зөвхөн төслийн саналыг үнэлж дүгнэх, Санхүүгийн гэрээг эцэслэх мөн санхүүжилтийн хэмжээг тодорхойлоход хэрэглэнэ.

## 5.7 ТЭМДЭГЛЭЛ

### 5.7.1 ЗАГВАР ТӨСЛИЙГ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

ЯБОЯ загвар төслүүдийн ерөнхий болон үр дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй түгээнэ. Тийм учраас, ДДБОТС төсөлд оролцогч талуудаас төсөлд ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжийн зураг болон бусад мэдээллийг хүсэх эрхтэй.

“ Төсөлд оролцогч талууд нь төслийн үр дүнгээ олон нийтэд мэдээлэх эрхтэй бөгөөд тэр тохиолдолд тухайн төсөл нь Монгол-Японы Засгийн газар хоорондын хамтын ажиллагаа, ХКОМ-ын Загвар төслийн хүрээнд, ЯБОЯ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй тухайг заавал дурдаж явна. ”

### 5.7.2 БУСАД

Оролцогчид энд заасан дүрэм журмаас гадна Япон улсын Санхүүжилтийн төсвийг хэрэгжүүлэх дүрэм (1955 оны гэрээ №179), дээрхи хуулийг хэрэгжүүлэх тухай тушаал (1955 оны тушаал №255), болон Санхүүгийн Дүрэм/Журмыг даган мөрдөнө.

ХКОМ-ын Загвар төслийн жендерийн тэгш байдлын удирдамжыг мөн харна уу.

## 5.8 ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ (2021 оны байдлаар)

### 5.8.1 ТАНИЛЦУУЛГА

ХКОМ-ын Загвар төслийг сонгон шалгаруулахдаа шударга, ил тод байдлын зарчмыг эрхэмлэх бөгөөд Даян Дэлхийн Байгаль Орчны Төв сан (ДДБОТС)-аас хөндлөнгийн хороо байгуулан энэхүү шалгуур үнэлгээний журмыг батлав.

Уг үнэлгээний журамд үндэслэн, ДДБОТС нь Японы Байгаль Орчны яамтай зөвлөлдөн ашиглаж буй технологийг харгалзан загвар төслүүдийг сонгох болно.

### 5.8.2 ЗАГВАР ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Загвар төслийн зорилго нь хөгжиж буй орнуудад нүүрстөрөгчгүй технологи, тоног төхөөрөмжийг ашиглан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилготой төслийг хэрэгжүүлэх зардлын тодорхой хэмжээг санхүүжүүлэн дэмжих эсвэл засгийн газрын харьяа бусад санхүүгийн байгууллагуудтай хамтран (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэгийн (JICA) арга хэмжээний үр дүнд бууруулсан хүлэмжийн хийн ялгарлын кредитээ Япон улс нь хүлэмжийн хийн ялгарлаа бууруулах зорилтдоо ашиглах юм. 2018 оны 6 сард Япон улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газраас (Cabinet Office) баталсан Байгаль орчны Гадаад Бодлогын Стратегийн хүрээнд ХКОМ-ын Загвар Төсөл нь нүүрстөрөгчгүй технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх замаар дэлхийн хэмжээнд хүлэмжийн хийг бууруулах үйл ажиллагаанд хувь нэмэр оруулах зорилготой юм.

Нэмж дурдахад, Хамтарсан Инновацийг Хэрэгжүүлэхэд Чиглэсэн Нүүрстөрөгчгүй Технологийг Үзүүлэх Төслийн Санхүүжилтийн Хөтөлбөрийг сурталчлах үүднээс хөтөлбөрийн хүрээнд үзүүлж буй төслүүд дууссаны дараа бизнесийн хөгжлийн тодорхой байдлыг харуулсан төслүүдэд өмнөх хөтөлбөрийн хүрээнд давуу эрх эдлэх боломжийг олгоно.

### 5.8.3 ШАЛГУУРЫН ТОЙМ

Дараах шалгуур үзүүлэлтэд үндэслэн загвар төслийг шалгаруулна.  
(1) Эхний шатны шалгуурыг хангасан төсөлд оролцогч талууд дараагийн шатны (2) үнэлгээг хийлгэх эрхтэй.

#### **(1) ЭХНИЙ ШАТНЫ ШАЛГУУРУУД**

Төслийн санал нь дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг шалгах. Эдгээр шалгууруудыг хангасны дараа дараагийн шатны үнэлгээг хийлгэнэ.

Эхний шатны шалгууруудыг хангаагүй төслийн санал буцаагдах болно.

1. Өргөдөл гаргагч нь эрх бүхий оролцогчийн шаардлагыг хангаж буй эсэх;  
Өргөдөл гаргагч нь 2.(4)-д заасан 'Төслийн санал ирүүлэх зааварчилгаа'-д заасан шаардлагыг хангана.  
Тухайн загвар төсөл нь ХКОМ-ын төсөл болон хэрэгжсэнээр эрчим хүчний салбараас ялгарч байгаа нүүрстөрөгчийн давхар исэл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахаар төлөвлөж байгаа эсэх
2. Загвар төсөл нь төсөл хэрэгжүүлж буй улсын (цаашид "түнш улс" гэх) холбогдох бодлоготой (үүнд Үндэсний тодорхойлсон хувь нэмэр орно - ҮТХН) нийцэж байх ёстой.  
Төслийн хүрээнд ашиглах технологи нь эрчим хүчний салбараас ялгарч байгаа нүүрстөрөгчийн давхар исэл, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах шаардлагатай. (Ялгарлын бууралтыг тоон үзүүлэлтээр тооцоолж болохоор байх, Эрчим хүчний үйлдвэрлэлийн үр ашиг буурсан зэрэг үйл ажиллагаа багассаны улмаас үүсэх ялгарлын бууралт нь үүнд тооцогдохгүй, Төслийн үр дүнд буурсан ялгарлын бууралт нь хүлэмжийн хийн ялгарлын бууралтад нөлөөлж буй бусад хүчин зүйлүүдээс тусдаа ялгагдахаар байна)
3. Санхүүжилтийн дэмжлэг нь нүүрстөрөгчгүй технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж буй төслийн хөрөнгө оруулалтад бодитоор дэмжлэг болж буй эсэх;

---

\* Зарчмын хувьд, эрчим хүч үйлдвэрлэх явцад үүссэн дулааныг үр дүнтэй ашигладаг тоног төхөөрөмж, нүүрстөрөгчийг хуримтлуулах, хадгалах (CCS) зэрэг нүүрсхүчлээс ангид байлгах технологид хувь нэмэр оруулдаг тоног төхөөрөмжөөс бусад тохиолдолд малтмал түлш ашиглан дулааны эрчим хүч үйлдвэрлэхтэй холбоотой бизнес байх ёсгүй.

---

4. Өргөдөл гаргагч нь загвар төсөлд нэвтрүүлж буй технологийн давуу талыг бодитоор харуулж чадах эсэх? Өөрөөр хэлбэл:
  - Бусад компанийн технологийг оролцуулсан давуу талын нотолгоо, өгөгдөл болон харьцуулсан үзүүлэлтүүд гэх мэт;
  - Хэрэв нэвтрүүлэх технологи нь энэхүү гарын авлагад Хавсралт 3 "Улс тус бүрийн хэрэгжүүлж буй ХКОМ-ын Загвар төслийн тоо, ашиглаж буй технологийн ангилал"-д дурдсан технологи бол технологи нь нөхцлийг хангасан байна гэж үзнэ.
5. Өргөдөл гаргагчийн төсөлд ашиглах гэж байгаа технологи нь, төслийг хэрэгжүүлэх улсад шинэ, дэвшилтэт технологи мөн гэдгийг

нотолж чадах эсэх;

6. Тухайн технологи нь олон улсад, практик дээр ашиглагдаж байгаа, төслийг хэрэгжүүлэх улсад нэвтрүүлж болох эсэх; Өөрөөр хэлбэл:

- Технологийг бусад төсөлд ашиглаж байсан эсэхийг харгалзан үзэх (үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг харна); Технологийг худалдааны зориулалтаар үйлдвэрлэсэн байх шаардлагатай. (каталог, үзүүлэлтүүдийг харна)
- Танилцуулах технологи нь түнш орны зах зээлд нутагшуулах, түгээх өндөр боломжтой байх бөгөөд түгээн дэлгэрүүлэх стратеги нь ирээдүйд хувийн хэвшлээр дамжуулан бие даан түгээх боломжийг бүрдүүлнэ.

Тухайн улсад барилга байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай дэмжлэгийн систем, технологийн дэмжлэг үзүүлэх боломж байгаа юу?

7. Загвар төслийг хэрэгжүүлсний дараа төсөл хэрэгжүүлсэн улсад тухайн технологи нь өргөн хүрээнд тархан ашиглагдах боломжтой эсэх; Мөн, өргөдөл гаргагч нь технологийн тархалтыг арилжааны зарчмаар дэмжих тодорхой стратегитай юу?

8. Загвар төсөл нь хэрэгжүүлж буй улсынхаа тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж буй эсэх;

- Тоног төхөөрөмжийн суурилуулалт болон үйл ажиллагаа нь төсөл хэрэгжиж буй улсын байгаль орчны хууль, журам, мөн байгаль орчныг хамгаалах олон улсын дүрэмд нийцсэн байх. (агаар/орчны бохирдол, усны бохирдол, хог хаягдлын боловсруулалт, дуу/чимээ, экосистем гэх мэт).

9. Хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцоолох аргачлал болон хяналт шинжилгээний арга зүй байгаа эсэх;

- Загвар төсөл нь бусад улсад болон тухайн улсад ашиглагдсан ижил төстэй технологийг нэвтрүүлэх тохиолдолд тухайн улсад батлагдсан ХКОМ-ын аргачлалыг хэрэглэх шалгуурыг хангаж буй эсэх; Шалгуур үзүүлэлтүүдийн тухай дэлгэрэнгүйг ДДБОТС-аас гаргасан материалаас харна уу.
- Хэрэв ХКОМ-аар батлагдсан аргачлал байхгүй бол суурь ялгарал болон төслийн ялгаралд үндэслэн консерватив аргаар тооцоолох боломжтой эсэх;
- Хүлэмжийн хийн ялгарлын бууралтыг тооцоолоход шаардлагатай

хяналт, шинжилгээг хийх арга, түүний хэрэгжилтийг зүй зохистойгоор ханган ажиллана.

10. Загвар төслийн зардлыг зөв тооцоолсон эсэх;
  - Зардлыг өмнө нь хэрэгжиж байсан ижил төстэй төслийн зардал дээр үндэслэн тооцоолно; эсвэл зардлыг бодит загвар, техникийн нөхцөл дээр суурилан гаргана.
  - Хувийн болон томилолттой холбоотой зардлуудын тооцоолол тодорхой байх
11. Загвар төсөл нь Японы Байгаль орчны яамнаас 2018 оны 6-р сард боловсруулсан Япон улсын Байгаль орчны салбарын Гадаадын Хөгжлийн стратеги, 2020 оны 12-р сард Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Дэд Бүтцийн Стратегийн Зөвлөлөөс боловсруулсан 2025 оны дэд бүтцийн тогтолцоог гадаадад хөгжүүлэх стратегитай нийцэж байна уу?
12. Загвар төсөл нь Тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулж байна уу?
  - Загвар төсөл нь Япон улсын болон Монгол улсын бодлогод нийцсэн, тухайн улсын тогтвортой хөгжил болон Тогтвортой хөгжлийн зорилтод (SDG)-д хувь нэмэр оруулж байх. Мөн түүнчлэн, “ХКОМ-ын жендерийн удирдамж”-ийг дагаж мөрдөх шаардлагатай.

---

\* Тогтвортой хөгжлийн зорилт нь 2016-2030 он хүртэлх олон улсын хөгжлийн зорилтуудын бүрдэл бөгөөд энэ тухай 2015 оны 9 сард болсон НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн дээд хэмжээний уулзалтаар батлагдсан Тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрт тусгасан байдаг.

---

13. Хэрэв загвар төсөл нь ЖАЙКА болон бусад засгийн газрын харьяа санхүүгийн байгууллагууд, (ЖАЙКА-ын санхүүжилтийн ODA төсөл эсвэл засгийн газрын харьяа санхүүгийн байгууллага) хувьцаа эсвэл зээл аван хамтарч буй тохиолдолд оролцогч нь дээрх санхүүжилтүүдийн эх үүсвэрүүдийг тодорхой ангилан зааж өгсөн байх.
14. Тухайн загвар төсөлд нэвтрүүлэх гэж буй тоног төхөөрөмж нь Японы Засгийн газраас санхүүжилтийн дэмжлэг аваагүй байх.

## (2) ҮНЭЛГЭЭНИЙ ТОЙМ

Эхний шатны шалгууруудыг хангасны дараа төслийн материалыг доорх үнэлгээний дагуу оноо өгч дүгнэх болно.

ХКОМ-ыг өмнө хэрэгжүүлж байсан дараах улс орнуудыг нэн тэргүүнд авч үзнэ (2021 оны байдлаар): Монгол, Бангладеш, Этиоп, Кени, Малдив, Вьетнам, Лаос, Индонези, Коста Рика, Палау, Канбож, Мексик, Саудын Араб, Чили, Мьянмар, Тайланд болон Филиппин.

### А) Төслийн хэрэгжилтийн тогтвортой байдал (20 оноо)

- 1) Төслийг хэрэгжүүлэх талуудын менежмент болон үйл ажиллагааны чадамж (10 оноо)
- 2) Төсөл хэрэгжүүлэгч талуудын бүтцийн байдал (олон улсын консорциум дах аж ахуйн нэгжүүдийн гүйцэтгэх үүргийн тухай шийдвэрийг оруулаад) (10 оноо)

### В) Бизнесийн тодорхой байдал (30 оноо)

- 1) Төслийн төлөвлөгөө (хуваарь, төсөл хэрэгжүүлэх байршил, төслийг хэрэгжүүлэх лиценз болон зөвшөөрөл, эрчим хүч үйлдвэрлэх тохиолдолд Худалдан Авах Гэрээ хийгдсэн эсэх) болон санхүүгийн төлөвлөгөө (төсөлд оролцогч талуудын оруулсан хөрөнгө оруулалтын бодит хувь хэмжээ, санхүүгийн зохицуулалтын тодорхой мэдээлэл). Төслийг хэрэгжүүлэх эрх авахад төсөлд оролцогч талууд тендерт оролцох шаардлагатай тохиолдолд загвар төслийн санхүүгийн дэмжлэгийн үр дүн болон тендерийн хуваарийг мэдэгдэнэ. (10 оноо)
- 2) Төслийн үр ашигтай байдал, эдийн засгийн үзүүлэлт, бэлэн мөнгөний урсгалын урьдчилсан тооцоолол болон зардлаа нөхөх хугацаа (урьдчилсан тооцооллоор зардлаа нөхөх хугацаа нь 3 жил эсвэл санхүүгийн дэмжлэгтэйгээр түүнээс илүү байх) (10 оноо)
- 3) Санхүүгийн төлөвлөгөөний зохистой байдал (талуудын оруулсан хөрөнгө оруулалтын нарийвчилсан мэдээлэл мөн санхүүгийн зохицуулалтын дэлгэрэнгүй) (10 оноо)

### С) Нийт хүлэмжийн хийн ялгарлын бууралт (эрчим хүчний салбарын нүүрсхүчлийн хийн ялгарал ороод) (25 оноо)

Нийт буурсан үзүүлэлт  $[tCO_2eq]$  = нэг жилд буурах хүлэмжийн хийн ялгарлын үзүүлэлт  $[tCO_2eq/y]$  х Япон улсын хуульд зааснаар тоног төхөөрөмжийн ашиглалтын нийт хугацаа  $[y]$

D) Санхүүжилтийн дэмжлэгийн хувьд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр ашигтай байдал, зардал хэмнэсэн байдал (25 оноо)

Хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр ашигтай байдал, зардал хэмнэсэн байдал  $[JPY/tCO_2eq]$  = санхүүгийн дэмжлэгийн хэмжээ  $[JPY]$  / хүлэмжийн хийн ялгарлын нийт бууралт  $[tCO_2eq]$

- Хүлэмжийн хийг 1 тонноор бууруулахад шаардагдах санхүүгийн дэмжлэгийн зардлын үр ашигтай байдал чухал. Өөрөөр хэлбэл, хүлэмжийн хийн ялгарлын бууралтын зардлын үр ашигтай байдал, 1 тонн хүлэмжийн хийн ялгарлын бууралт нь 4000 Япон иентэй дүйцэх эсвэл бага байх.
- Гэхдээ тухайн улсад ижил төстэй технологи нэвтрүүлж буй төслүүдийн тоо 5 байвал хүлэмжийн хийн ялгарлын бууралтын зардлын үр ашигтай байдал 1 тонн хүлэмжийн хийн ялгарлын бууралт нь 3000 Япон иентэй дүйцэх эсвэл бага байж болно. (жишээ: Палау, Филиппин зэрэг улсад өнөөдрийн байдлаар 5-аас дээш нарны эрчим хүчний төсөл хэрэгжиж байна)
- Түүнчлэн, ижил төстэй технологийн төсөл тухайн улсад дор хаяж 10 байвал, зардлын үр ашигтай байдал нь 1 тонн хүлэмжийн хийн ялгарлын бууралт нь 2500 Япон иентэй дүйцэх эсвэл бага байж болно. (жишээ: 10 гаруй нарны цахилгаан станцын төсөл Тайланд улсад хэрэгжиж байна)

Япон улсын хуулийн дагуу технологийн насжилтын хугацааг заасан байдаг хэдий ч ХКОМ-ын Эко Түрээсийн схемийн хувьд хяналт шинжилгээний хугацаа нь төслийн түрээсийн хугацаатай ижил байна.

E) Нэмэлт оноо (10 оноо)

Хамтарсан Инновацийг Хэрэгжүүлэхэд Чиглэсэн Нүүрстөрөгчгүй Технологийг Үзүүлэх Төслийн Санхүүжилтийн Хөтөлбөр болон өмнөх хөтөлбөр хамрагдсаны дараа тухайн бизнесдээ ахиц дэвшил үзүүлэх нь тодорхой харагдаж байгаа төслүүдэд нэмэлт оноо өгнө.



# БҮЛЭГ 6

## ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТ

- 6.1 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого  
“Алсын хараа - 2050”
- 6.2 Монгол Улс дах ХКОМ-ын дүрэм, журмын дагуу  
тогтвортой хөгжлийн удирдамж
- 6.3 ХКОМ-ын төслийн Тогтвортой Хөгжлийн Зорилтод  
оруулах хувь нэмэр
- 6.4 ХКОМ-ын Жендерийн Тэгш Байдлын Удирдамж

## 6.1 МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГО “АЛСЫН ХАРАА - 2050”

Монгол Улсын Их Хурал 2020 онд “Алсын хараа - 2050”<sup>23</sup> урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг баталсан. Урт хугацааны хөгжлийн бодлого нь суурь 9 зорилт, 50 хөгжлийн зорилгыг агуулж байгаа бөгөөд 10 жилээр буюу 2020-2030, 2031-2040, болон 2041-2050 он гэсэн гурван үе шаттайгаар хэрэгжүүлэхээр нарийвчлан хуваажээ. “Монгол Улс эдийн засгийн өсөлттэй, нийгмийн хөгжлөөрөө тэргүүлэгч болж, байгаль, хэл, газар нутгийн бүрэн бүтэн байдал, соёлоо тогтвортой хадгалан хамгаалж чадсан улс болно” гэсэн алсын хараанд анхаарлаа төвлөрүүлж дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр тодорхойлов.

### Тайлбар 5.

#### Алсын хараа баримт бичгийн 9 зорилт

1. Үндэсний нэгдмэл үнэт зүйлс - “Үндэсний нэгдмэл үнэт зүйлийн онцлог шинж чанарыг гүн гүнзгий ухааран үндэстнээрээ өсч хөгжих”.
2. Хүний хөгжил - “Монгол улсын хүний хөгжлийн индексийг 0.9 болгох, дэлхийн аз жаргалын индексээрээ эхний 10 орны тоонд багтах”.
3. Амьдралын чанар ба дундаж давхарга - “2050 он гэхэд таатай амьдрах нөхцлөөр хангагдсан дундаж давхаргыг нийт хүн амын 80 хувь хүртэл нэмэгдүүлэх”.
4. Эдийн засаг - “ДНБ-ийг 6.1 дахин, нэг хүнд ноогдох ДНБ-ийг 3.6 дахин болгон өсгөж 15000 ам.долларт хүргэн хөгжингүй орнуудын босгыг давах”.
5. Сайн засаглал - “Хүний эрх болон шударга ёсыг бүрэн дээдэлсэн, авлигыг үл тэвчсэн сайн засаглалыг бий болгох”.
6. Ногоон хөгжил - “Ногоон хөгжлийн хамт байгаль орчны тогтвортой байдлыг хангах”.
7. Амар тайван, аюулгүй нийгэм - “Үндэсний амин чухал ашиг сонирхлыг хамгаалах гадаад болон дотоод орчныг бүрдүүлэх”.
8. Бүсчилсэн хөгжил - “Бүс нутгийг эдийн засгийн интеграцид нэгдүүлж, хүн амын суурьшлын тогтвортой бүтэцтэй, өрсөлдөх чадвартай болгон хөгжүүлэх”.
9. Улаанбаатар ба дагуул хотууд - “Тохилог, байгаль орчинд ээлтэй амьдрах нөхцлийг бүрдүүлсэн хүн төвтэй хотыг байгуулах”.

Эдгээрийг дүгнэн үзэхэд урт хугацааны хөгжлийн бодлогын ач холбогдол нь нэгдмэл зарчим, ухамсартай үндэстнийг бий болгох, хүний хөгжил, эрүүл мэнд, боловсрол, гэр бүл, шинжлэх ухаан,

23 МУЗГ, М. У. (2020). Алсын хараа-2050. Улаанбаатар. Retrieved from <http://nda.gov.mn/1107.html>

инноваци болон хөдөлмөртэй холбоотой тогтолцоог боловсронгуй болгож, дундаж давхаргыг хөгжүүлэх, нийгмийн хамгаалал болон даатгалын системийн шинэчлэлийг хийж, боломжийн үнэтэй орон сууцаар хангах үр дүнтэй системийг бий болгох, гарааны бизнес болон эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг сурталчлахыг дэмжих зэрэг болно.

Эдийн засгийн гол салбаруудаа зөв тодорхойлсноор цаашдын өсөлтийг бий болгоход дэмжлэг болох, эдийн засгийн эрүүл орчныг бүрдүүлэх, олборлох болон боловсруулах үйлдвэрүүдийн тэнцвэрт байдалд тулгуурласан уул уурхай болон хөдөө аж ахуй, мөн түүнчлэн аж үйлдвэрийн салбар, эрчим хүч, тээвэр, ложистик, аялал жуулчлалын салбар болон мэдлэгт суурилсан бүтээлч аж үйлдвэрүүд дээгүүр байр суурьтай байна.

Түүнчлэн зорилгод засаглалын тогтвортой байдлыг хангах, эрх мэдлийн хуваарилалт, хяналт, төрийн байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох, цахим засаглалыг хөгжүүлэх, мөн төрийн албан хаагчдын мэргэжлийн чадавх, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх, иргэний нийгэм-хувийн хэвшил-олон нийтийн түншлэлийг бэхжүүлэх, хууль дүрмийг чангатгах, авлигалгүй засаглалыг бий болгохыг бас тусгасан болно.

Урт хугацааны бодлогод цаашид хот, суурин газар руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн болон хүн амын нягтралыг бууруулах, улсын нутаг дэвсгэрийг эдийн засгийн зургаан бүсэд хуваан улс даяараа эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх, үндэсний соёлыг хадгалж хамгаалахад хөрөнгө оруулалт хийх, хүн амын суурьшлын тогтвортой тогтолцоо, ирээдүйн хойч үедээ тэнцвэртэй эко системтэй уламжлалт болон байгалийн тогтоцыг өвлүүлэх, эдийн засгийн төрөлжилт, ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх мөн нийслэл Улаанбаатар хот болон дагуул хотуудыг хөгжүүлэхийг тусгана.

## 6.2 МОНГОЛ УЛС ДАХ ХКОМ-ЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДАМЖ

Монгол, Япон улсын Хамтарсан Хороо Монгол улсад ХКОМ-ын хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг үнэлэх, дүгнэх зорилгоор “ХКОМ-ын Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө/тайлан”(ТХТ/ТХТа)<sup>24</sup> баримт

24 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp/>  
[https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01.0.pdf)

бичгийг баталсан. Энэхүү баримт бичгийн хүрээнд тухайн төсөл нь хэрэгжих явцдаа хүрээлэн буй орчинд ээлтэй, хүний эрүүл мэнд, ажиллах орчин, бүс нутгийн нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах шаардлага, стандартыг тодорхойлж өгөх бөгөөд эдгээрийг Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөнд төслийн бүртгэлийн явцад тодорхойлно. Төсөлд оролцогч талууд Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөний маягыг ашиглан тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрээ урьдчилсан байдлаар тодорхойлсон байна.

## Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөө маягт нь 2 хэсгээс бүрдэнэ:

### 1) Гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тогтвортой хөгжилд оруулах боломжит хувь нэмэр (Хүснэгт 5)

ТХТ нь болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох 8 зүйл, 22 асуулт бүхий маягтаас бүрдэх бөгөөд үүнд: Бодлогын уялдаа холбоо, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Бохирдлын хяналт, Аюулгүй байдал болон эрүүл мэнд, Хүрээлэн буй орчин болон биологийн олон янз байдал, Эдийн засаг, Нийгмийн орчин ба олон нийтийн оролцоо, Технологи зэрэг багтана. Төсөлд оролцогч талууд Тийм, Үгүй гэсэн хариултын хүрээнд байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөө бий эсэхийг тодорхойлно.

**Хүснэгт 5.** Тогтвортой хөгжилд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний маягт (жишээ)<sup>25</sup>

В. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тогтвортой хөгжилд оруулах боломжит хувь нэмэр				
В.1 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх болон Тогтвортой хөгжилд оруулах боломжит хувь нэмрийн төлөвлөгөө				
№	Зүйл	Асуултууд	Тийм/ Үгүй	Хэрэв Тийм бол авах арга хэмжээг тодорхойлох
1	Бодлогын зохицуулалт	Санал болгож буй төсөл нь тухайн салбар, технологи, эсвэл газарзүйн бүсэд хамааралтай орон нутгийн өнөөгийн бодлого, хөтөлбөртэй нийцэхгүй байна уу?	Үгүй	
2	Байгаль орчны үнэлгээ (EIA)	Санал болгож буй төсөл нь албан ёсны/хуулийн дагуу Байгаль орчны үнэлгээ хийлгэх шаардлагатай юу?	Тийм	Төсөл нь 2015 онд Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хүрээнд Байгаль орчны үнэлгээний шаардлагыг хангасан.
3		Санал болгож буй төсөл нь агаар бохирдуулах бодис ялгаруулдаг уу?	Үгүй	

25 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01.0.pdf)

4	Бохирдолын үнэлгээ (Хэрэв БОУ шаардагдах бол хариулах шаардлагагүй)	Санал болгож буй төсөл нь ус бохирдуулах бодис эсвэл биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч (БХХ), химийн хэрэгцээт хүчилтөрөгч (ХХХ), эсвэл рН зэрэгт нөлөөлдөг бодис ялгаруулдаг уу?	Үгүй	
5		Санал болгож буй төсөл нь цахилгаан хэрэгслийн хог, хөргөх хог зэрэг хаягдал үүсгэдэг үү? (Хэрэв тийм бол хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болгон оруулна уу)	Тийм	Бага хэмжээний энгийн хог хаягдал гарахад зохих ёсоор нь устгана. Тоног төхөөрөмжийг байрлуулах явцад урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлаас болж цахилгаан хэрэгслийн хог хаягдал үүсэх боломжтой бөгөөд зохих ёсоор арга хэмжээ авах хүртлээ зөв зүйтэй хадгална.
6		Санал болгож буй төсөл нь өндөр дуу чимээтэй ба/эсвэл чичиргээтэй байх уу?	Тийм	Ашиглалтын явцад цахилгаан агааржуулагчийн дуу чимээ тодорхой хэмжээгээр нэмэгдэх төлөвтэй байгаа боловч хамгийн ойрын суурьшлын бүсээс 10 км зайд байрладаг тул ямар нэгэн төвөгтэй байдал үүсгэхгүй гэж төлөвлөж байгаа.
7		Санал болгож буй төсөл нь хөрсний суулт үүсгэдэг үү?	Үгүй	
8		Санал болгож буй төсөл нь ямар нэгэн үнэр үүсгэдэг үү?	Үгүй	
9	Аюулгүй байдал ба эрүүл ахуй	Санал болгож буй төсөл нь барилга угсралт, ашиглалтын явцад орон нутгийн иргэдэд мөн түүнчлэн төсөлд оролцож буй хүмүүст ямар нэгэн аюултай нөхцөл байдлыг бий болгох уу?	Тийм	Төслийн барилга угсралтын ажлын явцад ажилчдын аюулгүй байдалд зарим аюултай нөхцлийг бүрдүүлж болзошгүй тул барилгын ажилчдын аюулгүй байдлыг хангах үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажиллана.
10	Хүрээлэн буй орчин ба биологийн олон төрөл зүйл	Санал болгож буй төслийн талбай нь үндэсний хууль тогтоомж эсвэл олон улсын гэрээ, конвенцоор тогтоогдсон тусгай хамгаалалттай газар нутагт байрладаг уу?	Үгүй	
11		Санал болгож буй төслийн газар нь үндэсний хууль тогтоомж эсвэл олон улсын гэрээ, конвенцоор тогтоогдсон ховордсон ан амьтадыг хамгаалах бүс газар эсвэл олон нийтийн зориулалттай газар уу?	Үгүй	
12		Санал болгож буй төсөл нь гадны амьтдын төрөл зүйлийг авчрах уу?	Үгүй	
13		Санал болгож буй төслийн хүрээнд байгаль орчин, биологийн төрөл зүйлд (үүнд дуу чимээ, чичиргээ, булингартай ус, тоос шороо, ялгаруулсан хий, хаягдал зэрэг) нөлөөлөхүйц барилга угсралтын ажил хийгдэх үү?	Үгүй	

14		Санал болгож буй төсөлд гадаргын ус, газрын доорх/ эсвэл гүний усыг ашиглах уу?	Үгүй	
15	Эдийн засаг	Санал болгож буй төсөл нь орон нутгийн ажиллах хүчний чадавхид сөргөөр нөлөөлөх үү?	Үгүй	
16		Санал болгож буй төсөл нь орон нутгийн иргэдийн амар амгалан байдалд сөргөөр нөлөөлөх үү?	Үгүй	
17	Нийгмийн орчин ба олон нийтийн оролцоо	Санал болгож буй төсөл нь нүүлгэн шилжүүлэлт эсвэл бусад төрлийн зөрчилдөөн үүсгэх үү?	Үгүй	
18		Санал болгож буй төсөл нь орон нутгийн иргэд, ялангуяа олон нийтийн зөвлөлөөс ирж буй санал, гомдлыг хүлээн авах, хариу өгөх, дагаж мөрдөх зэрэг үйл ажиллагаанд оролцохгүй байх байдал үүсгэх үү?	Үгүй	
19		Төсөлд оролцогч талууд орон нутгийн иргэдийн хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой аливаа хууль тогтоомж, тогтоолыг зөрчиж байна уу?	Үгүй	
20	Технологи	Санал болгож буй төсөл нь төслийн ашиглалт, засвар үйлчилгээнд шууд хамаарах технологи шилжүүлэх, сургалт хийх, техникийн тусламж үзүүлэх зэрэг ажилд хүний нөөцийг бүрдүүлж чадахгүй байна уу?	Үгүй	
21		Санал болгож буй төсөл нь төслийн талбай дээр ашиглалтын үед үүсч болох асуудлыг шийдэх төсөлд ашиглагдаж буй техник технологийн үзүүлэлт, гарын авлага зэрэг мэдээллийг англи, монгол хэлээр материалыг хангаж чадахгүй байна уу?	Үгүй	
22		Санал болгож буй төсөл нь төслийн бэлтгэл ажил, түүний дотор барилга угсралт, технологи суурилуулах зэрэг үйл ажиллагаанд оролцож буй орон нутгийн иргэдийн хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх ажиллагааг төлөвлөөгүй байна уу?	Үгүй	

Тодорхойлсон зүйл тус бүрийн дагуу төслийн хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл, тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг үнэлэн, үндэсний болон орон нутгийн дүрэм журамд нийцэж буй эсэхийг тодорхойлно уу. Бүх асуултанд Тийм (Үүнд "Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөг хүргүүлэх үед тодорхой бус байх") эсвэл Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөг хүргүүлэх үеэс хамааран Үгүй гэж хариулна.

## 2) Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах боломжит хувь нэмэр (Хүснэгт 6)

Төсөлд оролцогч талууд ТХЗ-д оруулах боломжит хувь нэмрийг тодорхойлно. Төсөлд оролцогч талууд Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөг ирүүлсний дараа тодорхой хугацаанд хяналт шинжилгээ хийсний үр дүнд Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайлан (ТХТа)-г ирүүлэх ёстой. Хэрэв ХКОМ-ын төсөл нь дээр дурдсан 8 зүйлд сөрөг нөлөөлөл үзүүлэхээр дүгнэгдвэл төсөлд оролцогч талууд засах арга хэмжээг тодорхойлох ёстой (Хүснэгт 7, 8).

**Хүснэгт 6.** Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн төлөвлөгөөний Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах боломжит хувь нэмэр<sup>26</sup>

С. Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах боломжит хувь нэмэр			
С.1 ТХЗ-д оруулах хувь нэмрийг тогтоох			
ТХЗ No.	Доорхи ТХЗ(ууд)-ын алинд нь хувь нэмэр оруулах боломжтой гэж тодорхойлогдох вэ?	Боломжит хувь нэмрийг тодорхойлох	Хэрвээ “боломжит хувь нэмрийг тодорхойлох” дээр тэмдэглэгээ хийсэн бол тайлбарыг бичнэ үү.
1	Ядуурлын бүх хэлбэрийг устгах	<input type="checkbox"/>	
2	Өлсгөлөнг зогсоох, хүнсний аюулгүй байдлыг ханган тэжээллэг байдлыг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих	<input type="checkbox"/>	
3	Хүн бүр эрүүл энх, сайн сайхан амьдрах нөхцөлөөр хангах	<input checked="" type="checkbox"/>	Эрчим хүч үйлдвэрлэхэд нүүрсний оронд нарны эрчим хүчийг ашиглахыг дэмжсэнээр агаарын чанарыг сайжруулах ба 3.9-д заасан хүн амын эрүүл мэндэд сайнаар нөлөөлж агаарын бохирдлоос үүдэх өвчнөөс сэргийлэхэд хувь нэмэр оруулах боломжтой юм.
4	Хүн бүхэнд чанартай боловсролыг ижил тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, насан турш сурч боловсрох боломжийг дэмжих	<input type="checkbox"/>	
5	Хүйсийн эрх тэгш байдлыг хангах, бүх охид, эмэгтэйчүүдэд эрх мэдэлттэй байх боломжийг олгох	<input type="checkbox"/>	

26 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01.0.pdf)

6	Нийт хүн амд ундны ус болон ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй болгох тогтвортой менежмент хэрэгжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	Нарны цахилгаан станц нь дулааны цахилгаан станцаас ялгаатай нь үйл ажиллагаандаа усыг ашигладаггүй. Иймд ТХЗ-ын 6 зүйлийн 6.4-т зааснаар тус төсөл нь эрчим хүчний салбар дахь ус ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, усны тогтвортой хэрэглээг дэмжих замаар усны нөөцийг хамгаалахад нэмэр болно.
7	Нийт хүн амыг төлбөрийн чадварт нь нийцсэн, найдвартай, тогтвортой, орчин үеийн сэргээгдэх эрчим хүчээр хангах	<input checked="" type="checkbox"/>	ХХ МВт-ын нарны станцыг суурилуулснаар төвийн эрчим хүчний системд эрчим хүч нийлүүлэх ба тус төсөл нь орчин үеийн, тогтвортой эрчим хүчээр ханган дэд бүтэц, технологийг өргөжүүлэх хувь нэмэр оруулах ба далайд гарцгүй хөгжиж буй Монгол улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэн ТХЗ-ын 7 зүйлийн 7.1, 7.2, 7.а, 7.б зэрэг үндэсний зорилтуудад хувь нэмэр оруулах боломжтой.
8	Тууштай, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангах, бүх нийтээрээ бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэхийг дэмжих	<input type="checkbox"/>	
9	Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой үйлдвэржилт инновацыг дэмжих	<input checked="" type="checkbox"/>	Төсөл нь санхүүгийн, техник, технологийн дэмжлэгээр хангах замаар тогтвортой, уян хатан дэд бүтцийн хөгжлийг дэмжихэд хувь нэмэр оруулах боломжтой ба Монголд тогтвортой эрчим хүчний хэрэглээгээр нөөцийг ашиглах үр ашгийг нэмэгдүүлэн ТХЗ-ын 9 зүйлийн 9.4, 9.а зорилтуудад хувь нэмэр оруулах боломжтой.
10	Дотоодын болон улс хоорондын тэгш бус байдлыг багасгах	<input type="checkbox"/>	
11	Хот, суурин газруудын суурьшлыг аюулгүй, хүртээмжтэй, найдвартай, тогтвортой болгох	<input checked="" type="checkbox"/>	Тус төслөөр нүүрсний хэрэглээг бууруулснаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг багасган, нарийн ширхэгт тоосонцрын хэмжээг бууруулан улмаар Монгол Улсын томоохон асуудал болоод буй агаарын чанарыг сайжруулахад хувь нэмэр оруулах боломжтой юм. Төсөл нь ТХЗ-ын 11 зүйлийн 11.6-д хувь нэмэр оруулах боломжтой.
12	Тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийн загвараар хангах	<input checked="" type="checkbox"/>	Эрчим хүчний эх үүсвэр болох нүүрсний хэрэглээг багасгаснаар олборлолтыг бууруулж, тогтвортой менежмент дэмжин, байгалийн баялгийг үр ашигтай ашиглахад хувь нэмэр оруулах боломжтой. Төсөл нь ТХЗ 12 зүйлийн 12.2-т хувь нэмэр оруулах боломжтой.



13	Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийн эсрэг арга хэмжээг яаралтай авах	<input checked="" type="checkbox"/>	Төсөл нь нүүрс түлсэнээс гарах суурь ялгаралтай харьцуулахад хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах боломжтой ба утааг бодитоор бууруулахад хувь нэмэр оруулах болно. Төсөл нь Монгол улсад уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааны талаарх мэдлэгийг дээшлүүлэх, иргэн болон байгууллагын чадавхийг сайжруулахад хувь нэмэр оруулна. Төсөл нь ТХЗ-ын 13 зүйлийн 13.3-т хувь нэмэр оруулах боломжтой.
14	Далай тэнгисийн нөөцийг хамгаалах, тогтвортой хөгжилд зүй зохистой ашиглах	<input type="checkbox"/>	
15	Хуурай газрын экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих, цөлжилттэй тэмжэх, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг мөхөж устахаас сэргийлэх	<input type="checkbox"/>	
16	Амар тайван, бүх нийтийн оролцоог хангасан тогтвортой хөгжлийг дэмжих, бүх нийтэд шударга ёсыг хүртээх, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцыг бүх шатанд бий болгох	<input type="checkbox"/>	
17	Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг эрчимжүүлж, хэрэгжүүлэх арга механизмыг бэхжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	Хувийн хэвшлийн оролцогч нь төслөөс дэмжиж буй байгаль орчинд ээлтэй технологийг суурилуулах, түгээх, ажиллуулах зорилгоор санхүүгийн шууд хөрөнгө оруулалтыг Монгол улсад эргэлтэд оруулна. Хувийн хөрөнгө оруулалт нь ХКОМ-ын төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төсвийн санхүүжилтийн дэмжлэгийг авах бөгөөд ингэснээр ТХЗ-ын 17 зүйлийн 17.3, 17.7, 17.17-д хувь нэмэр оруулах боломжтой болно.

“Тодорхойлсон” гэсэн эгнээний дор Зорилго тус бүрт оруулсан хувь нэмэрээс хамааран нүд бүрийг “Тодорхойлсон” гэж тэмдэглэнэ үү. “Тодорхойлсон” гэж тэмдэглэсэн тохиолдолд төслийн оролцогчид нь Зорилтод оруулах хувь нэмэр(үүд)-ээ тайлбарлана уу.

Боломжит хувь нэмэр(үүд)-ийг тодорхойлохдоо “Тогтвортой хөгжлийн 2030 Хөтөлбөрийн тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудын дэлхийн шалгуур үзүүлэлт” болох ТХЗ шалгуур үзүүлэлтийн бүрэн жагсаалтыг үзнэ үү. НҮБ-ын Статистикийн хэлтсийн вэб сайтаас харах боломжтой <https://unstats.un.org/sdgs/indicators/indicators-list/>.

Хүснэгт 7. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн тайлангийн маягт<sup>27</sup>

В. Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмэр					
В.1 Урьдчилан сэргийлсэн сөрөг нөлөөлөл болон Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийг шалгах жагсаалт					
No	Бүлэг		Тодорхойлоогүй	Тодорхойлсон	Хэрэв “тодорхойлсон” гэсэн нүдийг тэмдэглэсэн бол авсан засах арга хэмжээгээ тайлбарлана уу
1	Бодлогын зохицуулалт	Төсөл нь өөрийн салбар, технологи, эсвэл газарзүйн бүсэд өөрийн салбар, технологи эсвэл газарзүйн бүсэд хамааралтай өнөөгийн орон нутгийн бодлого, хөтөлбөртэй нийцэж чадаагүй байх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
2	Байгаль орчны үнэлгээ (БОУ)	Төсөл нь Байгаль орчны нөлөөлөл байдлын үнэлгээг Монгол улсын Засгийн газарт тайлагнах Байгаль орчны үнэлгээний зохицуулалтын шаардлагыг хангаагүй байх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
3		Хүрээлэн буй орчны агаарын чанарыг бохирдуулах	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
4		Усны чанарт бохирдол үүсгэх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
5	Бохирдолын үнэлгээ (Хэрэв БОУ шаардагдах бол хариулах шаардлагагүй)	Цахилгаан хэрэгслийн хог хаягдал, хөргөлтийн шингэн зэрэг хог хаягдал үүсгэх	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Зарим энгийн болон цахилгаан хэрэгслийн хог хаягдлыг боловсруулсан. Эдгээр хог хаягдлыг зохих журмын дагуу тээвэрлэх, цэвэрлэх ажлыг орон нутгийн дүрэм журам, компанийн зохих журмын дагуу гүйцэтгэсэн.
6		Дуу чимээ ба/эсвэл чичиргээ үүсгэх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
7		Газрын суулт үүсгэх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
8		Хүрээлэн буй орчинд үнэр үүсгэх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
9	Аюулгүй байдал болон эрүүл ахуй	Аваар осол эсвэл мэргэжлээс шалтгаалсан осол гарах	<input type="checkbox"/>	<input checked="" type="checkbox"/>	Жижиг осол гарсан боловч түүнийг арилгаж, хохирлыг нөхөн төлсөн ба төслийн аюулгүй ажиллагааны арга хэмжээг шинэчлэн баталсан.

27 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp/>: [https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01\\_0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01_0.pdf)

10	Байгаль орчин ба биологийн төрөл зүйл	Тусгай хамгаалалттай газар нутгийн төлөв байдлыг өөрчлөх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
11		Газар ашиглалт болон экосистемийн төлөв байдлыг өөрчлөх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
12		Гаднын амьтны төрөл зүйлүүдийг оруулах	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
13		Барилга угсралтын ажлын явцад байгаль орчинд нөлөө үзүүлэх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
14		Гадаргын ус, газрын доорхи ус эсвэл гүний усыг ашиглах	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
15	Эдийн засаг	Орон нутгийн ажиллах хүчний чадамжийг бууруулах	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
16		Орон нутгийн нийтийн амар амгалан байдлыг алдагдуулах	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
17	Нийгмийн орчин ба олон нийтийн оролцоо	Нүүлгэн шилжүүлэлт эсвэл зөрчилдөөн үүсгэх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
18		Санал, гомдлын дагуу арга хэмжээ авахгүй байх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
19		Хөдөлмөрийн зохицуулалт, хөдөлмөрийн нөхцлийг зөрчих	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
20	Технологи	Технологи шилжүүлэх, сургалт явуулах, техникийн туслалцаа үзүүлэх зэрэг технологийн ашиглалт, үйлчилгээнд ажиллах ажилтан, байгууллагын чадавхийг бий болгож чадахгүй байх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
21		Технологийн үзүүлэлт, гарын авлагыг дор хаяж Англи, Монгол хэлээр хангаж чадахгүй байх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
22		Төслийн бэлтгэл шатанд хамрагдах орон нутгийн хүний нөөцийн чадварыг хөгжүүлж чадахгүй байх	<input checked="" type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

Дарааллын дагуу тодорхойлсон зүйл тус бүрийн дагуу төслийг хэрэгжүүлэх явцад үзүүлэх нөлөөллийн төрлөөс хамааран "Тодорхойлоогүй" эсвэл "Тодорхойлсон" гэсэн нүдийг нэг бүрчлэн тэмдэглэнэ үү. "Тодорхойлсон" гэсэн нүдийг тэмдэглэсэн тохиолдолд төслийн оролцогчид холбогдох "Тодорхойлсон" нөлөөлөл тус бүрт авсан арга хэмжээгээ тайлбарлана уу.

**Хүснэгт 8.** Тогтвортой хөгжлийн зорилтод оруулах хувь нэмрийн тайлангийн  
Тогтвортой хөгжилд оруулах хувь нэмрийн маягт<sup>28</sup>

С. Тогтвортой хөгжлийн зорилтод оруулсан хувь нэмэр			
С.1 ТХЗ-д оруулсан хувь нэмрийн жагсаалт			
ТХЗ No.	Төсөл нь хяналтын хугацаанд доорхи ТХЗ(ууд)-ын алинд нь хувь нэмэр оруулсан гэж тодорхойлсон бэ?	Тодорхойлсон	Хэрэв тодорхойлсон гэсэн бол хувь нэмрийг тайлбарлана уу
1	Ядуурлын бүх хэлбэрийг устгах	<input type="checkbox"/>	
2	Өлсгөлөнг зогсоох, хүнсний аюулгүй байдлыг ханган тэжээллэг байдлыг сайжруулж, тогтвортой хөдөө аж ахуйг дэмжих	<input type="checkbox"/>	
3	Хүн бүр эрүүл энх, сайн сайхан амьдрах нөхцлөөр хангах	<input checked="" type="checkbox"/>	Эрчим хүчний эх үүсвэрт нүүрсний хэрэглээг багасгаснаар Монгол улсад томоохон асуудал болоод буй орчны агаарын бохирдлыг бууруулсан. ТХЗ-ыг 3 зүйлийн 3.9 зорилтод заасан агаарын бохирдлоос үүдэлтэй нас баралт, өвчлөлтийг бууруулахад хувь нэмэр оруулах боломжтой.
4	Хүн бүхэнд чанартай боловсролыг ижил тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлэх, насан турш сурч боловсрох боломжийг дэмжих	<input type="checkbox"/>	
5	Хүйсийн эрх тэгш байдлыг хангаж, бүх охид, эмэгтэйчүүдийг эрх мэдэлтэй болгох боломж олгох	<input type="checkbox"/>	
6	Нийт хүн амд ундны ус болон ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй болгон тогтвортой менежмент хэрэгжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	Нарны цахилгаан станц нь дулааны цахилгаан станцууд шиг үйл ажиллагаандаа усыг ашигладаггүй тул ТХЗ-ын 6 зүйлийн 6.4-т зааснаар тус төсөл нь эрчим хүчний салбар дахь ус ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх, усны тогтвортой хэрэглээг дэмжих замаар усны нөөцийг хамгаалахад хувь нэмэр оруулна.
7	Нийт хүн амыг төлбөрийн чадварт нь нийцсэн, найдвартай, тогтвортой, орчин үеийн сэргээгдэх эрчим хүчээр хангах	<input checked="" type="checkbox"/>	XX МВт-ын нарны станцыг суурилуулснаар 2017 онд Монгол улсын эрчим хүчний төв системд ҮҮ% эрчим хүч нийлүүлсэн ба үндэсний зорилтод хувь нэмэр оруулсан. Тус төсөл нь орчин үеийн, тогтвортой эрчим хүчээр ханган дэд бүтэц, технологийг өргөжүүлэх хувь нэмэр оруулах ба далайд гарцгүй хөгжиж буй Монгол улсын хувьд сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэн ТХЗ-ын 7 зүйлийн 7.1, 7.2, 7.a, 7.б зэрэг зорилтуудад хувь нэмэр оруулсан юм.

28 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01.0.pdf)

8	Тууштай, хүртээмжтэй, тогтвортой эдийн засгийн өсөлтийг хангах, бүх нийтээрээ бүрэн, бүтээмжтэй, зохистой хөдөлмөр эрхлэхийг дхэмжих	<input type="checkbox"/>	
9	Найдвартай дэд бүтэц, хүртээмжтэй, тогтвортой үйлдвэржилт инновацыг дэмжих	<input checked="" type="checkbox"/>	Төсөл нь Монгол улсад ХХХ санхүүгийн хөрөнгө оруулалт, нарны эрчим хүчний дэвшилтэт технологи нэвтрүүлэх, техникийн ноу-хау болон нөөц ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх замаар тогтвортой, уян хатан дэд бүтцийн хөгжлийг дэмжсэнээр үндэсний цахилгаан эрчим хүчний системийн тогтвортой байдалд хувь нэмэр оруулсан ба ТХЗ-ын 9 зүйлийн 9.4, 9.а-д заасан байдаг.
10	Дотоодын болон улс хоорондын тэгш бус байдлыг багасгах	<input type="checkbox"/>	
11	Хот, суурин газруудын суурьшлыг аюулгүй, хүртээмжтэй, найдвартай, тогтвортой болгох	<input checked="" type="checkbox"/>	Нүүрсний хэрэглээнээс зайлсхийснээр тус төсөл нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулж, улмаар агаарын чанар, амьдралын чанарыг сайжруулан ТХЗ-ын 11 зүйлийн 11.6-д заасан Монгол улсын орчны эрүүл ахуйн томоохон асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсан.
12	Тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийн загвараар хангах	<input checked="" type="checkbox"/>	Чулуужуулсан түлшний оронд нарны эрчим хүчийг эрчим хүчний эх үүсвэр болгосноор жилд ойролцоогоор ХХХ тонн нүүрс ашиглагдаагүй бөгөөд ТХЗ-ын 12 зүйлийн 12.2-т заасан ашигт малтмалын тогтвортой менежментийг бий болгох болон цэвэр хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжихэд хувь нэмэр оруулсан. Төсөл нь орон нутгийн зохион бүтээгчид, үйлдвэрлэгчидтэй хамтран ажилласнаар Монгол дахь дотоодын техник технологийн салбарын ажиллах хүчийг чадавхжуулахад хувь нэмэр оруулсан.
13	Уур амьсгалын өөрчлөлт, түүний сөрөг нөлөөллийн эсрэг арга хэмжээг яаралтай авах	<input checked="" type="checkbox"/>	Энэхүү төслөөр жишиг ялгаралтай харьцуулахад ҮҮҮҮ tCO <sub>2</sub> e/жил баталгаажсан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан нь Монгол дахь хүлэмжийн хийн ялгарлыг бодитоор бууруулахад хувь нэмэр оруулсан юм. Уг төслөөр яам, хувийн хэвшлийн оролцоотой хоёр семинар, арван төслийн операторуудад зориулсан системийн ашиглалт, засвар үйлчилгээний нэг сургалт, арван таван орон нутгийн оролцогч талуудтай нэг удаагийн зөвлөгөөнөөр сэргээгдэх эрчим хүч, нарны эрчим хүч үйлдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах талаар мэдлэгийг дээшлүүлэв. Төсөл нь ТХЗ-ын 13 зүйлийн 13.3-т хувь нэмэр оруулсан.
14	Далай тэнгисийн нөөцийг хамгаалах, тогтвортой хөгжилд зүй зохистой ашиглах	<input type="checkbox"/>	

15	Хуурай газрын экологийн системийг хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, ойн нөөцийн тогтвортой менежментийг дэмжих, цөлжилттэй тэмжэх, газрын доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг мөхөж устахаас сэргийлэх	<input type="checkbox"/>	
16	Амар тайван, бүх нийтийн оролцоог хангасан тогтвортой хөгжлийг дэмжих, бүх нийтэд шударга ёсыг хүртээх, үр нөлөөтэй, хариуцлагатай, оролцоо бүхий чадварлаг институцыг бүх шатанд бий болгох	<input type="checkbox"/>	
17	Тогтвортой хөгжлийн төлөөх дэлхий нийтийн түншлэлийг эрчимжүүлж, хэрэгжүүлэх арга механизмыг бэхжүүлэх	<input checked="" type="checkbox"/>	Төсөл нь нарны цахилгаан станцын системийн угсралт, нэвтрүүлэлт, ашиглалт зэрэгт шууд хөрөнгө оруулалт авсан ба ХКОМ-аар дамжуулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төсвийн санхүүжилтийн дэмжлэгийг бас авсан юм. Төсөл нь ТХЗ-ын 17 зүйлийн 17.3,17.7, 17.17-д хувь нэмэр оруулсан.

“Тодорхойлсон” гэсэн эгнээний дор Зорилго тус бүрт оруулсан хувь нэмэрээс хамааран нүд бүрийг "Тодорхойлсон" гэж тэмдэглэнэ үү. "Тодорхойлсон" гэж тэмдэглэсэн тохиолдолд төсөлд оролцогч талууд нь Зорилтод оруулах хувь нэмэр(үүд)-ийг тайлбарлана уу.

### 6.3 ХКОМ-ЫН ТӨСЛИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД ОРУУЛАХ ХУВЬ НЭМЭР

Даян дэлхийн байгаль орчин стратеги судлалын хүрээлэн (IGES) ХКОМ-ын бүртгэгдсэн төслүүдэд (сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний хэмнэлтийн төслүүд, хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх төсөл) чанарын болон тоон дүн шинжилгээ хийсний үр дүнд ХКОМ-ын төслүүд ТХЗ<sup>29</sup>-ын дараах 12 зорилтод хувь нэмэр оруулах боломжтой гэж хэд хэдэн судалгаанаас харагдаж байна.

#### Тайлбар 6.

ХКОМ-ын ТХЗ-д оруулж буй 12 хувь нэмэр



29 Murun, T., & Tsukui, A. (2020). Joint Crediting Mechanism and Sustainable Development Goals Linkage Guidance. Hayama: IGES. Retrieved 2021, from <https://www.iges.or.jp/en/pub/jcm-and-sdgs-linkage-guidance/en>

Үүнээс харахад ХКОМ нь Хөтөлбөр-2030-д чухал нөлөө үзүүлж, түнш орнуудын ТХЗ-ыг биелүүлэхэд хувь нэмэр оруулахад асар их боломж байгаа юм.

ХКОМ-ын төслийг хэрэгжүүлснээр ТХЗ-ын 7, 9, 12, 13, 17-р зорилтод чухал хувь нэмэр оруулж байна. ХКОМ нь үйлдвэрлэлийн салбарт сэргээгдэх эрчим хүчний олон төсөл мөн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх олон төрлийн техник технологийг нэвтрүүлсэн. Энэ нь сэргээгдэх эх үүсвэрээс үйлдвэрлэх цахилгаан эрчим хүчийг нэмэгдүүлэх, тогтвортой аж үйлдвэр, дэд бүтцийг хөгжүүлэх, хариуцлагатай үйлдвэрлэл, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түншлэлийг бэхжүүлэх зэрэг ТХЗ-д хүрэхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Усжуулалтын системд сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлийг хөгжүүлснээр ТХЗ-ын Өлсгөлөнг устгах (Зорилго 2), Төлбөрийн чадварт нийцсэн цэвэр эрчим хүч (Зорилго 7), болон Цэвэр ус болон ариун цэврийн байгууламж (Зорилго 6) -уудтай холбогдох боломжтой юм.

Нийгмийн эрүүл мэнд, хүрээлэн буй орчны үүднээс авч үзвэл ХКОМ-ын бохир ус цэвэрлэх төслүүд нь Тогтвортой, найдвартай хотууд (Зорилго 11), Аж үйлдвэр, инноваци ба дэд бүтэц (Зорилго 9), Цэвэр ус болон ариун цэврийн байгууламж (Зорилго 6) зэрэгт хувь нэмэр оруулах боломжтой.

Хатуу хог хаягдал, хуванцарыг дахин боловсруулах төслүүд нь Усан доорхи амьдрал (Зорилго 14), Хариуцлагатай хэрэглээ ба үйлдвэрлэл (Зорилго 12)-д асар их нөлөө үзүүлэх ба улмаар далай тэнгис хуванцараар бохирдох асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр болно.

### **Судалгаа 1: Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт байрлах 12.7 МВт-ын нарны цахилгаан станцын төсөл<sup>30</sup>**

Хотын хүнсний ногооны чанарыг сайжруулах, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмэр оруулах давхар үр ашиг бүхий 12.7 МВт-ын хүчин чадал бүхий газар тариалан, сэргээгдэх эрчим хүч хосолсон Солар Фарм төслийг Япон талаас Farmdo Co., Ltd, Монгол талаас Эвридэй Ферм ХХК компаниуд хамтран Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлж байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр Монгол улсын нүүрсний хэрэглээг тодорхой хэмжээнд бууруулах ба жилд 11223 т/CO<sub>2</sub>-той дүйцэх хэмжээний хүлэмжийн

30 Murun, T., & Tsukui, A. (2021). JCM contributions to SDGs - Best practices. Hayama, IGES. Retrieved 2021, from <https://www.iges.or.jp/en/pub/jcm-sdgs-best-practices/en>



хийн ялгарлыг бууруулан үйлдвэрлэсэн эрчим хүчээ төвийн эрчим хүчний системд нийлүүлж байна. 2018 оны 11 сард Монгол–Япон улсын Хамтарсан Хорооны шийдвэрээр төслийн хүлэмжийн хийн ялгарлын бууралтын хяналт шинжилгээн дээр үндэслэн 8800 т/CO<sub>2</sub>-той дүйцэх хэмжээний кредитийг тооцсон байна.

Энэ төсөл нь ТХЗ-ын 9 зорилтод хэрхэн хувь нэмэр оруулж байгааг дараах Хүснэгт 9-өөс харна уу.

### Хүснэгт 9. Солар фарм төслийн ТХЗ-д оруулсан хувь нэмэр

ТХЗ-ууд	ХКОМ-ын оруулсан хувь нэмэр
	2019 онд Улаанбаатар хотын оршин суугчдыг 27 тонн шинэ ургацын нарийн ногоо, жимс, жимсгэнээр хангасан байна. Эрчим хүчний үйлдвэрлэлийн орлого нь тус компанид Японы хөдөө аж ахуйн технологийг суурилуулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн юм.
 	Сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр цахилгаан эрчим хүч үйлдвэрлэснээр нүүрсний хэрэглээг багасгаж энэ нь агаарын бохирдлыг бууруулах, хүрээлэн буй орчны сөрөг нөлөөллийг сайжруулахад нөлөөлж байна.
	Farmdo Co., Ltd нь орон нутгийн тариаланчдад зориулж хөдөө аж ахуйн ур чадвараа дээшлүүлэх сургалтыг Солар фарм дээр явуулдаг. Мөн нарны цахилгаан станц дээр ажилладаг инженер болон ажилчид нь цахимаар үйлдвэрлэгчийн удирдамжийн дагуу ажлыг гүйцэтгэдэг.
 	2017 оноос үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш нийт цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 40000 МВт/цаг хүрч, 38000 МВт/цаг (2019 оны 12-р сарын 31-ний байдлаар) цахилгаан эрчим хүчийг борлуулсан байна. Нарны цахилгаан станцаар үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг үндэсний сүлжээнд борлуулдаг бөгөөд энэ нь тус улсын сэргээгдэх эрчим хүчний цахилгааны эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулж байгаа ба улмаар CO <sub>2</sub> ялгарлыг бууруулж байна.
 	Монголын эрчим хүчний салбарт тогтвортой дэд бүтцийг бий болгож, хамгийн ихээр хүлэмжийн хий ялгаруулдаг салбарын технологийн шинэчлэлийг бэхжүүлснээр улс орныг илүү тогтвортой үйлдвэрлэлд шилжихэд нэмэр болно.
	ХКОМ-д оролцон янз бүрийн оролцогч талуудтай хамтран ажилснаар бага нүүрс төрөгч бүхий технологийг дэлгэрүүлж, хоёр орны төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулна.

## Судалгаа 2. Вьетнам: Да Нанг хотод өндөр үр ашигтай усны насосыг нэвтрүүлэх<sup>31</sup>

Ёкохама хот болон Да Нанг хот нь “Хот хоорондын хамтын ажиллагаа”<sup>32</sup>-ны түншлэлээр дамжуулан дэд бүтцийн хөгжил болон байгаль орчны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой техникийн хамтын ажиллагааг дэмжиж ирсэн байна. Тус хоёр хот нь эртнээс түншилж ирсэн бөгөөд энэхүү төслийг эхлүүлсэн байна. Yokohama Water Co., Ltd нь Da Nang Water Supply One-member Limited Company (DAWACO) компанийн эзэмшдэг ус цэвэрлэх байгууламжийн хоёр усны насостой станцын энгийн усны насосыг Японы өндөр үр ашигтай насосуудаар сольсон. Шинээр нэвтрүүлсэн насосууд нь цахилгаан зарцуулалтыг багасган CO<sub>2</sub> ялгарлыг бууруулж, усан хангамжийн үйлчилгээгээр дамжуулан байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулсан.

Энэхүү ХКОМ-ын төсөл нь ТХЗ-ийн 9 зорилтод хэрхэн хувь нэмэр оруулж байгааг дараах (Хүснэгт 10) хүснэгтээс харна уу.

### Хүснэгт 10. Да нанг хотын усны системийг сайжруулах төсөл

ТХЗ-ууд	ХКОМ-ын оруулсан хувь нэмэр
	Yokohama Water Co., Ltd төслийг зохих ёсоор хэрэгжүүлэхийн тулд орон нутгийн төсөлд оролцогчдод засвар үйлчилгээ, ашиглалт, хяналт шинжилгээ хийх техникийн сургалтыг явуулсан.
	Суурилуулсан өндөр үр ашигтай усны насос нь усан хангамжийг өдөрт 5000 тонноор нэмэгдүүлэх хувь нэмэр оруулсан. Да-Нангийн усны хэрэглээний 70% -ийг дотоодын компани хангадаг энэхүү төсөл нь хотод тогтвортой усны хангамжийг бий болгож, өндөр чанартай усаар хангаж өгсөн.
 	Эрчим хүчний үр ашиг 20% -иар өсч, CO <sub>2</sub> ялгарлыг бууруулснаар ус цэвэрлэх байгууламж дахь цахилгаан эрчим хүчний өртөг буурсан.
  	Өндөр үр ашигтай усны насосыг суурилуулснаар Да Нанг хотын оршин суугчдыг тогтвортой усан хангамжтай болгосон. Энэхүү төсөл нь Вьетнам дахь дэд бүтцийг тогтвортой хөгжүүлэхэд санхүүгийн болон техникийн дэмжлэг үзүүлдэг байна. Түүгээр ч зогсохгүй шинэ тоног төхөөрөмжүүд нь илүү дуу чимээ багатай тул ажиллах орчныг сайжруулсан.
	ХКОМ-д оролцсон янз бүрийн оролцогч талуудтай хамтран ажилснаар бага нүүрстөрөгч бүхий технологийг дэлгэрүүлж, хоёр орны төрийн болон хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж байна.

31 Murun, T., & Tsukui, A. (2021). JCM contributions to SDGs - Best practices. Hayama, IGES. Retrieved 2021, from <https://www.iges.or.jp/en/pub/jcm-sdgs-best-practices/en>

32 The city city cooperation: [https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm\\_pamphlet\\_C2C\\_2019\\_EN.pdf](https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm_pamphlet_C2C_2019_EN.pdf)  
MOEJ official website for city and city cooperation: [https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/project/index.html#link\\_01](https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/project/index.html#link_01)

## 6.4 ХКОМ-ЫН ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН УДИРДАМЖ<sup>33</sup>

### 6.4.1 ЗОРИЛГО

Хамтарсан Кредит Олгох Механизмын (ХКОМ)-ын загвар төслийн зорилго нь жендерийн эрх тэгш байдлын тухай хөндсөн НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтын хүрээнд нүүрстөрөгч бага бүхий дэвшилтэт технологийг сурталчлан дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах мөн хамтрагч улсын тогтвортой хөгжлийн бодлогод хувь нэмэр оруулах юм.

Байгалийн баялгийн хүртээмж, байгаль орчны талаарх бодлого, арга хэмжээ шийдвэр гаргах түвшинд оролцоход жендерийн ялгаа байсаар байгааг хүлээн зөвшөөрч байна. Түүнчлэн эмэгтэйчүүд нийгэм эдийн засгийн ашиг тус, үйлчилгээг бүрэн авч чадахгүй байгаа билээ. Энэ нь нөлөөллийг бууруулах хүчин чармайлтад, цаашлаад НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудад хүрэхэд саад болж байна.

Тиймээс, энэхүү удирдамжаар жендерийн эрх тэгш байдлын талаарх үндсэн зарчим, тодорхой зөвлөмжийг өгөхөд чиглэсэн бөгөөд оролцогч талуудыг ялангуяа ХКОМ-ын загвар төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий төсөлд оролцогч талуудыг төслийн бүхий л үе шатанд (төлөвлөх, хэрэгжүүлэх, хянан шалгах) холбогдох арга хэмжээг авч ажиллахыг уриалж байна.

Төсөл тус бүрт жендерийн эрх тэгш байдал хэрхэн хамаарах нь харилцан адилгүй байх ч, энэхүү удирдамжийн дагуу, оролцогч талууд төсөл тус бүрийн онцлогт тохируулан боломжит байдлаар дэмжиж ажиллахыг зөвлөж байна.

### 6.4.2 ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

Энэ хэсэгт жендерийн эрх тэгш байдлын ерөнхий зарчмуудыг нарийвчлан тусгасан бөгөөд төсөлд оролцогч талуудыг эдгээр зарчмуудыг баримтлахыг уриалж байна.

#### 1) Эмэгтэйчүүдийн эрх мэдэл

- о Төслийн хэрэгжилтийн үр дүнд (өмнө нь эрчим хүчний асуудалтай байсан газруудыг тог, цахилгаантай болгох, газар эзэмшихтэй холбоотой нөхөн төлбөр олгох гэх мэт) эмэгтэйчүүдийг чадавхжуулах, тэр дундаа ажил эрхлэлт, орлого

33 MOEJ. (2020, Apr). Guideline on Gender Equality for the Joint Crediting Mechanism (JCM). Tokyo: GEC. Retrieved from <http://gec.jp/jcm>: [http://gec.jp/jcm/jp/kobo/r02/mp/jcmsbsdR2\\_gender\\_en.pdf](http://gec.jp/jcm/jp/kobo/r02/mp/jcmsbsdR2_gender_en.pdf)

- нэмэгдүүлэхэд эмэгтэй бизнес эрхлэгчдэд бизнесээ өндөр бүтээмжтэй эхлүүлэх болон өргөжүүлэхэд мөн боловсролын хүртээмжийг сайжруулахад нь хэрхэн нөлөөлөхийг авч үзэх.
- Төсөл хэрэгжүүлж буй байгууллагууд нь сургалтанд хамруулах, боловсрол мэдлэгийг дээшлүүлэх, жендерийн эрх тэгш байдлыг нь сайжруулах гэх мэт шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх замаар илүү олон эмэгтэйчүүдэд идэвхтэй үүрэг гүйцэтгэх боломжтой ажлын орчинг бүрдүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.
- 2) Жендерийн тэнцвэртэй шийдвэр гаргах үйл явц
- Уур амьсгалын өөрчлөлт, холбогдох бодлогын талаарх мэдээллийг нээлтэй байлгах, олон нийтийн шийдвэр гаргах үйл явцад тэдний оролцоог нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн тэгш эрхийг сурталчлах
  - Удирдах түвшинд эмэгтэйчүүдийн манлайллыг оролцуулах үүднээс төслийн хэрэгжилтийн шатанд жендерийн тэнцвэртэй шийдвэр гаргах үйл явцыг оруулах
- 3) Эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, сайн сайхан байдал
- Амьдралын янз бүрийн түвшинд эмэгтэйчүүдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулахад анхаарах тэр дундаа эрүүл мэнд (бохирдсон агаар, уснаас эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар), аюулгүй байдал (гудамжны гэрэлтүүлэг, ариун цэврийн байгууламж, нийтийн тээврийн системийг сайжруулах), мөн түүнчлэн эдийн засгийн болон бие бялдрын ачааллыг бууруулах (цахилгаан, эрчим хүчний төлбөрийг багасгах, мөн цэвэр бохир усны систем, өндөр үр ашигтай хоол хийх төхөөрөмж суурилуулах зэрэг гэр ахуйн ачааллыг бууруулах замаар) тал дээр анхаарах

#### 6.4.3 ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСЛИЙН ҮЕ ШАТ БҮРТ ЖЕНДЕРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАХ ЗӨВЛӨМЖ

Энэ хэсэгт төсөлд оролцогч талууд ХКОМ-ын загвар төслийн хэрэгжих хугацаанд жендерийн эрх тэгш байдлыг сайжруулах арга замуудыг нарийвчлан тусгав.

##### 1) Төлөвлөлтийн үе шат

- Төсөл нь ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, эмэгтэйчүүдийг илүү дээгүүр албан тушаалд ажиллах боломжоор хангах зэргээр

- эмэгтэйчүүдийг чадавхжуулахад нөлөөлөх эсэхийг харгалзан үзэх.
- Төслийн хүрээнд жендертэй холбоотой тулгарч болох бэрхшээлийг тодорхойлох мөн төслийн төлөвлөгөөнд тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх тухай боломжуудыг тусгах. Жендерийн тэгш байдлын талаарх үндэсний болон бүс нутгийн бодлого, санаачлагыг аль болох харгалзан үзэх нь чухал юм.
- 2) Төслийн хэрэгжилтийн үе шат
- Төслийн хэрэгжилтийн явцад эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, жендерийг анхаарсан ажлын орчин, эмэгтэйчүүдийн манлайлал, холбогдох сургалт, боловсрол зэргийг дэмжих.
  - Төслийн талаарх зөвшөлцлийг бий болгох үйл явцад эмэгтэйчүүдийн санал бодлыг тусгах мөн эмэгтэйчүүдийг газар эзэмших, нүүн шилжихтэй холбоотой нөхөн олговорын тал дээр эмэгтэйчүүдэд эрх тэгш хандах.
- 3) Төхөөрөмжийн үйл ажиллагааны үе шат
- Эмэгтэйчүүдийн ажил эрхлэлтийг сайжруулах, сургалтанд хамруулах ялангуяа тоног төхөөрөмжийг ажиллуулахад шаардлагатай менежментийн болон техникийн мэргэжилтний ажлын байранд бэлтгэх
  - Төслийн ашиг тусын талаар төсөлд ажиллаж байгаа эмэгтэйчүүдтэй хуваалцах, оролцогч талуудын хурлаар оруулсан санал бодлыг ижил түвшинд авч үзэх.
- 4) Мэдээллийг хуваалцах үе шат
- Жендерийн тэгш байдлын тал дээр авсан арга хэмжээ, ХКОМ-ын загвар төслийн хэрэгжилтийн үр дүнд гаргасан амжилт, сурсан зүйлүүдийг хуваалцах/мэдээлэх
  - Төслийн явцад жендерийн эрх тэгш байдлыг сайжруулах үүднээс ажил эрхлэлт, боловсрол, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг ажлууд үргэлжлүүлэн хийгдэж буй эсэхэд тогтмол хяналт тавих.

## ДҮГНЭЛТ

Монгол улс НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц (НҮБУАӨСК)-ын хүрээнд 2015 оны Парисын Хэлэлцээрт оруулах Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн бичиг баримт (ҮТХН)-даа тусгасан зорилтот арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр нийт хүлэмжийн хийн ялгарлаа 2030 он гэхэд эдийн засгийн хөгжил өнөөгийн жишгээр тооцсон үзүүлэлттэй харьцуулахад 22.7 хувьд хүргэх зорилтыг тусгасан байна. Хүлэмжийн хийг бууруулах дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нэмэлт санхүүжилт, технологи, чадавх шаардагдах бөгөөд Хамтарсан Кредит Олгох Механизмыг санхүүжилтийн нэг эх үүсвэр, чадавх нэмэгдүүлэх боломж гэж үзсэн байдаг.

Цаашид Монгол-Япон хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдэд Япон улсын хөрөнгө оруулалтыг татах, өндөр үр ашигтай технологийг Монгол улсад нэвтрүүлэх боломжийг илүү өргөжүүлж, олон төрлийн арга хэмжээ авахыг зорьж байна.

ХКОМ-ыг манай улсад хэрэгжүүлж эхэлснээс хойш өнөөг хүртэл нийт 9 судалгааны төсөл хэрэгжиж үүнээс албан ёсоор ХКОМ-ын хүрээнд 5 төсөл бүртгэгдэж, 3 аргагүй батлагдан, гуравдагч талын этгээд буюу Хөндлөнгийн магадалгаа, нотолгоо хийх эрх бүхий үндэсний 2 байгууллага бүртгэгдэн зөвшөөрлөө аваад байгаа билээ.

ХКОМ-ын хэрэгжилтийн онцлог нь тухайн төсөл хэрэгжиж дуусаад хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг бодитоор бууруулсан нь албан ёсоор батлагдсаны дараагаар ХКОМ-ын загвар төслөөр бүртгэн авдаг. Энэ журмын дагуу өнөөдрийн байдлаар 4 загвар төсөл, 1 үзүүлэх төсөлдөө 18311 тонн нүүрстөрөгчийн давхар исэл (CO<sub>2</sub>)-тэй дүйцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлын баталгаажсан бууралт /CER-Certified Emission Reduction/ буюу кредитээ тооцуулан аваад байна.

ХКОМ-аас буцалтгүй тусламж хэлбэрээр олгож байгаа санхүүжилт нь төсөл хэрэгжүүлэгч талуудад хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, санхүүгийн бусад зээлийн хүрээн дэх эргэн төлөлтийн хугацааг багасгах талаас ихээхэн хувь нэмэр болж байна. Өөрөөр хэлбэл, багагүй хөрөнгө оруулалт шаардагдах төслийг хэрэгжүүлэхэд банк, санхүүгийн байгууллагын зээлийг ХКОМ-ын дэмжлэгтэйгээр хослуулан хөрөнгө оруулалтын ачааллыг бууруулна гэсэн үг.

ХКОМ-ын санхүүжилтийн онцлог нь төслийг хэрэгжүүлэх явцад санхүүжилтийн тал хүртэлх хувийг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр олгодог давуу талтай.

## 1. Нүүрстөрөгч бага бүхий технологийг нэвтрүүлэх

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хамгийн гол суурь нь одоогийн ашиглаж байгаа эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон, нүүрстөрөгч ихээр ялгаруулдаг, эрчим хүчний үр ашиг багатай, агаар, орчны бохирдолыг ихээр нэмэгдүүлж байгаа хуучин технологийг халж шинэ дэвшилтэт технологи рүү шилжих.

Өртгийн хувьд өндөр, шинэ технологийг Монгол улсад нэвтрүүлэхэд төр, хувийн хэвшлийн бие даасан хөрөнгө оруулалтын боломж хязгаарлагдмал юм. ХКОМ-ын хүрээнд хэрэгжүүлсэн төслүүдийн хувьд Япон улсын Засгийн газар ХКОМ-аар дамжуулан өндөр үр ашиг бүхий тэргүүний технологийг Монгол улсад нутагшуулах боломжийг олгосон.

Түүнчлэн, хөрөнгө оруулагч нар олон улсын зах зээл дээр шинээр гарч байгаа техник, технологид хөрөнгө оруулалт хийхдээ эргэлзэж, болгоомжтой ханддаг. ХКОМ-ын давуутал нь санал болгосон технологийн аюулгүй, найдвартай, дэвшилтэт байдлыг ашиглалтын горимд туршиж байж нэвтрүүлэх баталгааг олгодог. Төслийн үндсэн үйл ажиллагаа эхлэхэд суурилуулсан нүүрстөрөгч бага бүхий дэвшилтэт технологийн үр өгөөж шууд харагдана. Төсөлд оролцогч талуудын туршлагаас харахад төслийг хэрэгжүүлснээр эрчим хүч, түлшний өртөг гэх мэт зардлууд бодитоор буурсан байна.

## 2. Өрсөлдөх чадвар, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх

Дэвшилтэт технологийг нэвтрүүлэн, төслийн үйл ажиллагааны болон технологи ашиглалтын зардлыг бууруулснаар тухайн аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадварт эергээр нөлөөлж, ашиг орлогыг нэмэгдүүлж байна. Өөрөөр хэлбэл, дэвшилтэт технологийн үр дүнд үйлдвэрлэл нэмэгдэн үүнийг дагаад ажлын байр, чадварлаг, мэргэшсэн боловсон хүчний орон тоо нэмэгдэж байгааг хэд хэдэн төслийн жишээн дээр харж болно.



### 3. Хувийн хэвшлийн оролцоо ба уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад оруулж буй хувь нэмэр

Манай улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтдоо хүрэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны оролцоо зайлшгүй чухал.

Энэ чиглэлийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шаардлагатай санхүүжилтийг бий болгох, олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцааг авахад хувийн хэвшлийн оролцоо зайлшгүй шаардлагатай. ХКОМ нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хамтарсан хүчин чармайлт гаргах хөшүүрэг болох санхүүжилтийн механизм гэж олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн.

Монгол улсад ХКОМ-ыг хэрэгжүүлж эхэлснээс хойш нийт 150 орчим сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийгээд байгаагаас 40 орчим сая нь буцалтгүй тусламж хэлбэрээр олгосон дэмжлэг байна. ХКОМ-ын бизнесийн загвар нь манай улсын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах хүчин чармайлтад ялангуяа сэргээгдэх эрчим хүчний хөгжил, эрчим хүчний хэмнэлт, үр ашиг дээр амжилттай хувь нэмрээ оруулж байна.

### 4. Хүний эрүүл мэнд, ажиллах орчныг сайжруулах

Дэвшилтэт технологийг нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тухайн компанийн ажилчдын ажиллах орчин эрс сайжирснаар хүний эрүүл мэндэд бас давхар үр өгөөжтэй байна.

Жишээлбэл: “Улаанбаатар хотын 118-р сургуульд өндөр үр ашигтай нам даралтын зуухыг суурилуулах” төсөл хэрэгжсэнээр ялгаруулж буй утаа, тоосжилт, нүүрсний тортгийг бууруулж тухайн бүсийн сургууль, цэцэрлэгийн хүүхдүүд болон уурын зуухны ажилчдын эрүүл мэнд, ажиллах, амьдрах орчин илүү сайжирсан.



## АШИГЛАСАН МАТЕРИАЛУУД

- <sup>1</sup> UN, N. U. (2015). The Paris Agreement. Retrieved Feb 15, 2021, from [www.unfccc.int](http://www.unfccc.int):  
<https://unfccc.int/process-and-meetings/the-paris-agreement/the-paris-agreement>
- <sup>2</sup> MOEJ. (2021). About the Mechanism: Basic concept of JCM. Retrieved Feb 15, 2021, from [www.jcm.go.jp](http://www.jcm.go.jp): <https://www.jcm.go.jp/about>
- <sup>3</sup> UN, U. N. (2015). The Sustainable Development Goals, Retrieved Feb 2021, from <https://sdgs.un.org>: <https://sdgs.un.org/goals>
- <sup>4</sup> UN, U. N. (2015, Sep 25). Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development. Retrieved from <https://sdgs.un.org>:  
[https://www.un.org/ga/search/view\\_doc.asp?symbol=A/RES/70/1&Lang=E](https://www.un.org/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/70/1&Lang=E)
- <sup>5</sup> МУЗГ, М. У. (2020). Алсын хараа-2050. Улаанбаатар. Retrieved from <http://nda.gov.mn/1107.html>
- <sup>6</sup> Mongolia-Japan, M. M. (2013, Jan 8). Low Carbon Development Partnership between the Japanese side and the Mongolian side. Retrieved from <http://www.jcm-mongolia.com/>: [http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM\\_MN\\_bilateral\\_document.pdf](http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM_MN_bilateral_document.pdf)
- <sup>7</sup> IGES, I. f. (2018, Dec). JCM in Charts for Mongolia 2018. Ministry of Environment and Tourism. Ulaanbaatar: Environment and Climate Fund. Retrieved Jan 2021, from [www.jcm-mongolia.com](http://www.jcm-mongolia.com/): [http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM-in-CHARTS-for-Mongolia\\_ver3\\_EN-3.pdf](http://www.jcm-mongolia.com/wp-content/uploads/2015/11/JCM-in-CHARTS-for-Mongolia_ver3_EN-3.pdf)
- <sup>8</sup> MOEJ, M. o. (2016, Jul 30). JCM Rules and Guidelines. [https://www.jcm.go.jp/mn-jp/rules\\_and\\_guidelines](https://www.jcm.go.jp/mn-jp/rules_and_guidelines). Retrieved Jan 2021. from <https://www.jcm.go.jp/>: [https://www.jcm.go.jp/opt/mn-jp/rules\\_and\\_guidelines/download/JCM\\_MN\\_Spec\\_Registry\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/opt/mn-jp/rules_and_guidelines/download/JCM_MN_Spec_Registry_ver01.0.pdf)
- <sup>9</sup> MOEJ, M. o. (2018, Nov 06). JCM Rules and Guidelines. Retrieved Jan 2021. <https://www.jcm.go.jp>: Sector Scope: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_05/JCM\\_MN\\_GL\\_PM\\_ver02.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_05/JCM_MN_GL_PM_ver02.0.pdf) Gas coverage: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_01/JCM\\_MN\\_RoI\\_ver04.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_01/JCM_MN_RoI_ver04.0.pdf)
- <sup>10</sup> MOEJ. (2015, Apr 5). JCM Rules of Procedures for the Joint Committee. Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_02/JCM\\_MN\\_RoP\\_JC\\_ver02.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_02/JCM_MN_RoP_JC_ver02.0.pdf)

- 11 MOEJ. (2018, Nov 06). Rules of Implementation for the Joint Crediting Mechanism (JCM). Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_01/JCM\\_MN\\_RoI\\_ver04.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_01/JCM_MN_RoI_ver04.0.pdf)
- 12 MOEJ. (2018, Nov 06). Rules of Implementation for the Joint Crediting Mechanism (JCM). Retrieved from <https://www.jcm.go.jp>: [https://www.jcm.go.jp/rules\\_and\\_guidelines/mn/file\\_01/JCM\\_MN\\_RoI\\_ver04.0.pdf](https://www.jcm.go.jp/rules_and_guidelines/mn/file_01/JCM_MN_RoI_ver04.0.pdf)
- 13 International Organization for Standardization (ISO) 14065. <https://www.iso.org/standard/74257.html>
- 14 GEC, G. E. (2020). The Global Environment Centre Foundation (GEC) as an implementing organization for the Financing Programme for Joint Crediting Mechanism (JCM). Retrieved from <http://gec.jp>: <http://gec.jp/jcm/about/>
- 15 MOEJ. (2013). Guidelines for Submitting Proposals. Tokyo: GEC. Retrieved 2020, from <http://gec.jp>: [https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/\(tentative\)2021\\_Guidelines\\_for\\_Submitting\\_Proposals.pdf](https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/(tentative)2021_Guidelines_for_Submitting_Proposals.pdf)
- 16 MOEJ. (2020). JCM Eco Lease Scheme. Tokyo: GEC. Retrieved from [http://gec.jp/jcm/kobo/mp/r02/jcmsbsdR2\\_ecolease\\_overview2\\_en.pdf](http://gec.jp/jcm/kobo/mp/r02/jcmsbsdR2_ecolease_overview2_en.pdf)
- 17 MOEJ. (2018). Demonstrate Decarbonization Technology for Realizing Co-Innovation. Tokyo: GEC. Retrieved from <https://gec.jp/category/innovation/>
- 18 Asian Development Bank ADB. (2016). Handbook for Developing Joint Crediting Mechanism Projects. ADB. Retrieved Jan 2021, from <https://www.adb.org/documents/handbook-developing-joint-crediting-mechanism-projects>
- 19 GEC, G. E. (2021). The Global Environment Centre Foundation (GEC) as an implementing organization for the Financing Programme for Joint Crediting Mechanism (JCM). <http://gec.jp/jcm/about/>. Retrieved from <http://gec.jp>:
- 20 Asian Development Bank ADB. (2016). Handbook for Developing Joint Crediting Mechanism Projects. ADB. Retrieved Jan 2021, from <https://www.adb.org/documents/handbook-developing-joint-crediting-mechanism-projects>
- 21 MOEJ. (2010). The Feasibility Study Program. Tokyo, Japan. Retrieved from <https://www.env.go.jp>: [https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm\\_pamphlet\\_02.pdf](https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm_pamphlet_02.pdf), City-city cooperation link: [https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm\\_pamphlet\\_C2C\\_2019\\_EN.pdf](https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm_pamphlet_C2C_2019_EN.pdf)

- 22 GEC, G. E. (2020). Guidelines for Submitting Proposals. Tokyo: GEC. Retrieved from [https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/\(tentative\)2021\\_Guidelines\\_for\\_Submitting\\_Proposals.pdf](https://gec.jp/jcm/jp/kobo/r03/mp/(tentative)2021_Guidelines_for_Submitting_Proposals.pdf), (CHAPTER 5) is adopted entirely based on the "Guidelines for Submitting Proposals", an official document developed by GEC for the JCM.
- 23 МУЗГ, М. У. (2020). Алсын хараа-2050. Улаанбаатар. Retrieved from <http://nda.gov.mn/1107.html>
- 24 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp>:  
[https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01.0.pdf)
- 25,26 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp>:  
[https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01.0.pdf)
- 27,28 MOEJ. (2018, Nov 6). Joint Crediting Mechanism Guidelines for Developing Sustainable Development Contribution Plan and Report. Retrieved from <https://www.jcm.go.jp>:  
[https://www.jcm.go.jp/jc\\_decisions/1465/JCM\\_MN\\_GL\\_SDCP\\_CR\\_ver01.0.pdf](https://www.jcm.go.jp/jc_decisions/1465/JCM_MN_GL_SDCP_CR_ver01.0.pdf)
- 29 Murun, T., & Tsukui, A. (2020). Joint Crediting Mechanism and Sustainable Development Goals Linkage Guidance. Hayama: IGES. Retrieved 2021, from <https://www.iges.or.jp/en/pub/jcm-and-sdgs-linkage-guidance/en>
- 30 Murun, T., & Tsukui, A. (2021). JCM contributions to SDGs - Best practices. Hayama, IGES. Retrieved 2021, from <https://www.iges.or.jp/en/pub/jcm-sdgs-best-practices/en>
- 31 Murun, T., & Tsukui, A. (2021). JCM contributions to SDGs - Best practices. Hayama, IGES. Retrieved 2021, from <https://www.iges.or.jp/en/pub/jcm-sdgs-best-practices/en>
- 32 The city city cooperation: [https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm\\_pamphlet\\_C2C\\_2019\\_EN.pdf](https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/english/project/data/jcm_pamphlet_C2C_2019_EN.pdf), MOEJ official website for city and city cooperation:  
[https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/project/index.html#link\\_01](https://www.env.go.jp/earth/coop/lowcarbon-asia/project/index.html#link_01)
- 33 MOEJ. (2020, Apr). Guideline on Gender Equality for the Joint Crediting Mechanism (JCM). Tokyo: GEC. Retrieved from <http://gec.jp/jcm>:  
[http://gec.jp/jcm/jp/kobo/r02/mp/jcmsbsdR2\\_gender\\_en.pdf](http://gec.jp/jcm/jp/kobo/r02/mp/jcmsbsdR2_gender_en.pdf)



# ХАВСРАЛТ

1. Олон улсын Консорциум байгуулах тухай гэрээ  
(Жишээ: ХКОМ-ын Загвар төсөл болон  
Эко түрээсийн схемийн төсөл)
2. ХКОМ-ын Загвар төслийн саналын тэмдэглэл  
(Маягт № 36)
3. ХКОМ-ын Кредитийг хуваах тухай гэрээ  
(Маягт № 5 ХКОМ-ын Загвар төсөл болон  
Эко түрээсийн схемийн төсөл)

## ХКОМ-ЫН ӨРГӨДЛИЙН ЗАГВАРУУД

### 1. ОЛОН УЛСЫН КОНСОРЦИУМ БАЙГУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ (ЖИШЭЭ: ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСӨЛ БОЛОН ЭКО ТҮРЭЭСИЙН СХЕМИЙН ТӨСӨЛ)

Энэхүү гэрээ хэлэлцээрийг (цаашид "Гэрээ" гэх) Олон улсын консорциумыг (цаашид "Консорциум" гэх) байгуулах, доор дурдсан нүүрстөрөгчийн давхар исэл (CO<sub>2</sub>)-ийн ялгарлыг бууруулах төслийн "Хамтарсан кредит олгох механизм (цаашид "ХКОМ" гэх)-ын Загвар төсөл 202X"-ийн санхүүжилтийн хөтөлбөрийг ашиглах зорилгоор байгуулсан болно.

Төслийн нэр: \_\_\_\_\_ (цаашид "Төсөл" гэх)

#### 1 дүгээр зүйл (Нэр)

Энэхүү гэрээнд үндэслэн байгуулсан Олон улсын консорциумыг \_\_\_\_\_ төслийн консорциум гэж нэрлэнэ.

#### 2 дугаар зүйл (Бүрэлдэхүүн гишүүдийн байршил болон нэр)

Энэхүү консорциум нь Японы талын оролцогч(ууд) болон ХКОМ-ын түнш орны оролцогч(ууд) - оос бүрдэх бөгөөд бүрэлдэхүүн хэсэг нь дараах байдалтай байна.

- (1) Оролцогчийн нэр .....
- Хаяг .....
- (2) Оролцогчийн нэр .....
- Хаяг .....
- (3) Оролцогчийн нэр .....
- Хаяг .....

#### 3 дугаар зүйл (Төлөөлөн оролцогч болон түнш оролцогч(талууд))

Энэхүү Консорциумын төлөөлөгч нь Япон талын оролцогч байх бөгөөд \_\_\_\_\_-ийг томилов. Бусад бүрэлдэхүүн гишүүд нь түнш оролцогч(талууд)) байна.

#### 4 дүгээр зүйл (Төлөөлөн оролцогчийн үүрэг хариуцлага ба эрх мэдэл)

Энэхүү Консорциумын төлөөлөн оролцогч нь Төслийн нэвтрүүлсэн байгууламж болон тоног төхөөрөмжийг (цаашид "Байгууламж" гэх) худалдан авах, угсрах, ашиглалтад оруулах үүрэг хүлээнэ. Төслийн хэрэгжилтийн хувьд төлөөлөн оролцогч нь төслийн үйл ажиллагааны менежмент болон данс тооцоог хариуцна. Төлөөлөн оролцогч нь санхүүгийн дэмжлэг авах өргөдөл гаргах болон авах бөгөөд энэхүү Консорциумд хамаарах эд хөрөнгийг захиран зарцуулна.

#### 5 дугаар зүйл (Бүрэлдэхүүн гишүүдийн хамтарсан үүрэг хариуцлага)

1. Энэхүү Консорциумын бүрэлдэхүүнд багтсан гишүүн бүр хүлээсэн

үүргийнхээ хүрээнд ахиц дэвшил гаргахыг эрмэлзэх бөгөөд төслийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хамтдаа хүлээнэ.

2. Энэхүү Консорциумын бүрэлдэхүүн гишүүн бүр төслийг хэрэгжүүлэх дараах үүргийг хамтран хариуцна:

- (1) Байгууламжийг ашиглан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөлд хэрэглэгдэх аргазүйг боловсруулахад шаардлагатай мэдээллээр хангах замаар ХКОМ-ын аргазүй боловсруулагч нартай хамтран ажиллах.
- (2) Дээр дурдсан төслийн магадлагааг үр дүнтэй явуулахад шаардлагатай материал, мэдээллээр хангах болон төслийн талбайд хүлэмжийн хийн ялгарал буурсан эсэхийг шалгах хөндлөнгийн Гуравдагч талын этгээдтэй (ГТЭ) хамтран ажиллах.
- (3) Байгууламжийг ашиглан хүлэмжийн хийг бууруулах, хянах, тооцоолох.
- (4) Байгууламжийг ашиглан хүлэмжийн хийн ялгарал буурсан үр нөлөөг хэмжих, тайлагнах, мөн Японы хууль тогтоомжид заасан тухайн Байгууламжийн ашиглалтын хугацаа дуустал жил бүр Японы Байгаль орчны яаманд тайлагнах, энэ төслийн хувьд \_\_\_\_ жил байна.

Эко түрээсийн төслүүдийн гэрээнд дараахь өөрчлөлттэй байна.

(Байгууламжийг ашиглан хүлэмжийн хийн ялгарал буурсан үр нөлөөг хэмжих, тайлагнах, мөн Японы хууль тогтоомжид заасан тухайн Байгууламжийн түрээсийн хугацаа дуустал жил бүр Японы Байгаль орчны яаманд тайлагнах, энэ төслийн хувьд \_\_\_\_ жил байна.)

- (5) Хамтарсан Хорооноос гаргасан эсвэл Японы Засгийн газар болон ХКОМ-ын түнш орноос гаргах төслийн бүртгэлд зориулсан анкет гаргах зэрэг шаардлагатай арга хэмжээг авах.
- (6) Бүртгэгдсэн ХКОМ-ын төсөл нь дээр дурдсан хууль ёсны жилүүдэд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнд бууруулсан кредит тооцуулах хүсэлтээ Хамтарсан хороонд илгээхдээ ЯБОЯ-аас шийдвэрийн дагуу тодорхой хувь хэмжээг Японы Засгийн газарт шилжүүлэх хүсэлт гаргах.

Эко түрээсийн төслүүдийн гэрээнд дараахь өөрчлөлттэй байна.

(Бүртгэгдсэн ХКОМ-ын төсөл нь дээр дурдсан хууль ёсны түрээсийн жилүүдэд хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнд олгогдсон ХКОМ-ын кредитийг Хамтарсан Хорооноос гаргуулах болон тавь болон түүнээс дээш хувийг Японы засгийн газарт шилжүүлэх хүсэлт гаргах.)

- (7) ХКОМ-ын Загвар төсөл хэрэгжиж дууссаны дараа ч санхүүгийн дэмжлэг авах зорилгоор үр ашигтай ажиллагаатай байлгахын тулд Японы хууль тогтоомжид заасан хугацааны туршид төслийн найдвартай байдлыг ханган Байгууламжийг удирдах.

Эко түрээсийн төслүүдийн гэрээнд дараахь өөрчлөлттэй байна.

(ХКОМ-ын Загвар төсөл хэрэгжиж дууссаны дараа ч санхүүгийн дэмжлэг авах зорилгоор үр ашигтай ажиллагаатай байлгахын тулд түрээсийн хугацааны туршид төслийн найдвартай байдлыг ханган Байгууламжийг удирдах.)

- (8) Бүрэлдэхүүн гишүүн өөрчлөгдсөн тохиолдолд Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Санд мэдэгдэх ба дээрх (1)-с (7) хүртэлх үүргээ үргэлжлүүлэх,

### **6 дугаар зүйл (Олон улсын консорциум хэрэгжүүлэх бүтэц)**

Энэхүү гэрээнд үндэслэсэн хэрэгжүүлэх бүтцийг Хавсралтад дурдсан болно.

### **7 дугаар зүйл (Энэхүү гэрээг байгуулах болон хүчинтэй хугацаа)**

1. Энэхүү гэрээ нь 2020 оны \_\_-р сарын \_\_ -нд хүчин төгөлдөр болох бөгөөд Япон улсын хуулийн дагуу Байгууламжийн үнэ цэнэ нь бүрэн буурснаас хойш Японы санхүүгийн жилийн сүүлээр (3-р сар)-д дуусна.
2. Өмнөх догол мөрөнд заасан энэхүү Гэрээний хүчинтэй хугацааг төлөөлөн оролцогч болон түнш оролцогч(талууд) нар харилцан тохиролцож сунгаж болно.

### **8 дугаар зүйл (Удирдах хороо)**

Энэхүү Консорциум нь Төслийг удирдах бүх бүрэлдэхүүн гишүүдээс бүрдсэн удирдах хороог зохион байгуулна.

### **9 дүгээр зүйл (Төслийн удирдагч)**

Энэхүү Консорциумд төлөөлөн оролцогч нь төслийн удирдагч болон төслийг хянах, удирдах эрх бүхий үүрэг гүйцэтгэнэ.

### **10 дугаар зүйл (Төслийн хариуцагч болон холбогдох хүн)**

Энэхүү Консорциум дах бүрэлдэхүүн гишүүдийн төлөөлөл нь Төслийн удирдагчийн удирдлага дор хариуцагч болон Төслийн холбогдох хүнийг томилно.

### **11 дүгээр зүйл (Бүрэлдэхүүн гишүүдийн хэд хэдэн үүрэг, хариуцлагатай)**

Хэрэв энэхүү Консорциумын бүрэлдэхүүн гишүүн нь төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бусад гишүүдэд эсвэл гуравдагч этгээдэд хохирол учруулсан бол тухайн үүссэн хохиролд хариуцлага хүлээнэ.

### **12 дугаар зүйл (Эрх, үүргийг шилжүүлэхийг хязгаарлах)**



Энэхүү Гэрээгээр олгогдсон эрх, үүргийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг нь гуравдагч этгээдэд шилжүүлэх буюу өвлүүлэх ёсгүй.

### **13 дугаар зүйл (Нууцлалын үүрэг)**

Энэхүү гэрээний журам нь Төслийн бүрэлдэхүүн гишүүдийн хооронд харилцан тохиролцсон баримт болох бөгөөд гуравдагч этгээдэд задруулах ёсгүй.

### **14 дүгээр зүйл (Төсөл хэрэгжих үеэр бүрэлдэхүүн гишүүд дампуурах эсвэл татан буулгахтай холбоотой арга хэмжээ)**

Хэрэв бүрэлдэхүүн гишүүдийн аль нэг нь дампуурсан эсвэл татан буугдсан бол үлдсэн гишүүд нь дампуурсан эсвэл татан буугдсан гишүүний үүрэг даалгаврыг хамтран гүйцэтгэнэ.

### **15 дугаар зүйл (Татан буугдсаны дараах доголдлын хариуцлага)**

Хэрэв энэхүү Консорциум татан буугдсаны дараа Төсөлд ямар нэгэн доголдол илэрсэн тохиолдолд бүрэлдэхүүн гишүүн бүр хамтран хариуцна.

### **16 дугаар зүйл (Энэхүү гэрээнд тусгаагүй асуудал)**

Энэхүү гэрээнд тусгаагүй асуудлыг Удирдах хороо тогтооно.

### **17 дугаар зүйл (Маргаантай эсвэл эргэлзээтэй асуудлыг шийдвэрлэх)**

Хэрэв энэхүү гэрээг тайлбарлахад ямар нэгэн маргаантай эсвэл эргэлзээтэй асуудал байгаа бол төлөөлөн оролцогч болон түншүүд хоорондоо зөвшилцөж, асуудлыг эв зүйгээр шийдвэрлэхийг хичээнэ.

Энэхүү гэрээг \_\_\_\_\_ ( ) эх хувь үйлдсэн бөгөөд нэг хуулбар хувь бөгөөд бүрэлдэхүүн гишүүн бүр гарын үсэг, тамгаа даран эх хувийг хадгална. Хуулбарыг тэтгэмж хүсэх өргөдлийн маягтын хамт Даян Дэлхийн Байгаль Орчны Төв Санд хүргүүлнэ.

#### **Огноо: сар/өдөр/жил:**

Төлөөлөн оролцогч:

(Гарын үсэг)

Овог нэр:

Албан тушаал:

(Төлөөлөн оролцогчийн нэр:)

Түнш оролцогч(ууд):

(Гарын үсэг)

Овог нэр:

Албан тушаал:

(Түнш оролцогчийн нэр:)

## 2. ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСЛИЙН САНАЛЫН ТЭМДЭГЛЭЛ (МАЯГТ № 3Б)

Баримт бичиг илгээсэн он сар өдөр	(өдөр/сар/жил)
<b>Санал болгож байгаа төслийн нэр</b> (Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах үйл ажиллагаагаа тодорхой тайлбарлах)	
<b>Хэрэгжүүлэгч орон</b>	
<b>Төслийн үйл ажиллагааг хариуцсан хүний мэдээлэл</b> (төслийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хариуцсан холбогдох хүн)	Холбоо барих байгууллагын нэр (компани/ хүн ...): Байгууллагын хаяг: Байгууллагын цахим хуудас: Хариуцсан хүний нэр, албан тушаал: Хариуцсан хүний и-мэйл хаяг: Хариуцсан хүний утасны дугаар:
<b>Төслийн үйл ажиллагаанд оролцох Япон талын хамтрагчийн мэдээлэл, үүрэг хариуцлага</b> (хэрвээ боломжтой бол төсөлд оролцох аж ахуйн нэгж бүрийн холбоо барих хүн тус бүрийн мэдээллийг оруулна уу)	Байгууллагын/ хариуцсан хүний нэр: Төсөлд оролцогч байгууллагын үүрэг, хариуцлага: Байгууллагын хаяг: Байгууллагын цахим хаяг: Хариуцсан хүний нэр, албан тушаал: Хариуцсан хүний и-мэйл хаяг: Хариуцсан хүний утасны дугаар: [Шаардлагатай бол бусад байгууллагуудыг нэмж оруулна уу]
<b>Төсөл хэрэгжүүлэгч улсын оролцогч тал(ууд)-ын төслийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлага</b> (хэрвээ боломжтой бол төсөлд оролцох аж ахуйн нэгж бүрийн холбоо барих хүн тус бүрийн мэдээллийг оруулна уу)	Байгууллагын/ хариуцсан хүний нэр: Төсөлд оролцогч байгууллагын үүрэг, хариуцлага: Байгууллагын хаяг: Байгууллагын цахим хаяг: Хариуцсан хүний нэр, албан тушаал: Хариуцсан хүний и-мэйл хаяг: Хариуцсан хүний утасны дугаар: [Шаардлагатай бол бусад байгууллагуудыг нэмж оруулна уу]
<b>Төслийн товч танилцуулга</b> Жишээ нь: <b>Төслийн зорилго:</b>	
<ul style="list-style-type: none"> <li>✓ Төслийн байршил:</li> <li>✓ Хөрөнгө оруулалтын хэмжээ, төлөвлөж байгаа хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг дурдах</li> <li>✓ Төсөлд ашиглагдах технологи(ууд), болон товч танилцуулга</li> <li>✓ Төслийн хэрэгжилтийн төлөвлөгөө, оролцогч талуудын үүрэг</li> <li>✓ Төслийн өнөөгийн байдал, явц</li> </ul>	
<b>Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах урьдчилсан тооцоолол</b> (нэгж: жилд/т-CO <sub>2</sub> )	
<b>Барилга угсралт, инженерингийн байгууламжийг дуусгах болон ХКОМ-ын төслөөр бүртгүүлэх төлөвлөж буй хугацаа</b>	
<b>Хэрэгжүүлэгч орны оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө</b> (шинээр суурилуулсан тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээ, оролцогч талуудад мэдээлэл солилцох, сургалт семинар зохион байгуулах, эсвэл Японд танилцах аялал хийх сургалт гэх мэт.)	

### 3. ХКОМ-ЫН КРЕДИТИЙГ ХУВААХ ТУХАЙ ГЭРЭЭ (МАЯГТ № 5 ХКОМ-ЫН ЗАГВАР ТӨСӨЛ БОЛОН ЭКО ТҮРЭЭСИЙН СХЕМИЙН ТӨСӨЛ)

- Улаан өнгөөр тодруулсан хэсгүүдийг төслийн мэдээллээр бөглөнө үү.
- Төсөлд ороцлогч талууд хоёроос дээш байгаа нөхцөлд төслийн төлөөлөх тал болон төслийн хэрэгжүүлэгч талуудын хооронд гэрээнд гарын үсэг зурна.
- Төслийн саналаа ирүүлэхдээ эдгээр зааврыг устгана уу.

Энэхүү Хамтарсан Кредит Олгох Механизмын хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнд бий болсон кредитийг хуваарилах гэрээг XXXX оны X-р сарын XX-ны өдөр ... газар төв оффис нь байрлах Төсөлд оролцогч А тал болон .... газар төв оффис нь байрлах Төсөлд оролцогч Б нарын хооронд байгуулав.

Энэхүү гэрээ нь төсөлд оролцогч талуудын хооронд байгуулсан Олон улсын консорциумын гэрээний хүрээнд хамтран хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсон санал болгож буй “Төслийн нэр” (цаашид хамтад нь Төсөл гэх) төсөл нь Японы Байгаль орчны яамнаас санхүүжүүлж, Даян дэлхийн байгаль орчны төвийн сангаас удирддаг ХКОМ-ын Загвар төсөл/Эко түрээсийн төсөл болон сонгогдон хэрэгжихээр болсон тохиолдолд хүчинтэй байна.

ТИЙМЭЭС, дээр дурдсан нөхцөл байдлаас үндэслэн Түрээсийн Төслийн хугацаанд суурилуулах төслийн байгууламжаас бууруулсан хүлэмжийн хийн ялгарлын бууралтын үр дүнд бий болсон кредитийн тодорхой хувь хэмжээг Япон улсын Засгийн газарт тооцуулахаар харилцан тохиролцов.

ҮҮНИЙГ ГЭРЧЛЭН, Төсөлд оролцогч талууд дээрх гэрээг өмнө дурдсан он, сар, өдрийн байдлаар гүйцэтгэв. Энэхүү гэрээний нэг хувийг төслийн саналын хамт Даян дэлхийн байгаль орчны төв санд хүргүүлнэ.

Төсөлд оролцогч тал А

Төсөлд оролцогч тал Б

Сар/Өдөр/Он: \_\_\_\_\_

Сар/Өдөр/Он: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

Нэр

Нэр:

Албан тушаал

Албан тушаал:



# ХАВСРАЛТ



Монгол-Япон улсын Нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл буюу Хамтарсан Кредит Олгох Механизмыг 2013 оноос хэрэгжүүлж эхэлснээс хойш Техник эдийн засгийн үндэслэлийн судалгааны 9 төсөл, Үзүүлэх төсөл 1, Загвар төсөл 7, АХБ-ны дэмжлэгтэй 2 төсөл шат шатандаа амжилттай хэрэгжиж байна.

### MN001 – Загвар төсөл (бүртгэгдсэн)

“Улаанбаатар хотын 118-р сургуульд өндөр үр ашигтай нам даралтын зуухыг суурилуулах” төсөл. Жилд 62 тонн CO<sub>2</sub> дүйцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 19520 Гж дулаанаар ханган 118-р сургууль, цэцэрлэгийн байрыг халуун ус, дулаанаар ажиллаж байна. 2016, 2018 онуудад 168 тонн CO<sub>2</sub>-той дүйцэх хэмжээний ялгарлын баталгаажсан бууралт буюу кредитээ тооцуулсан.



Хэрэгжүүлэгч талууд:

- Ану сервис ХХК (Монгол талаас)
- Suuri Keikaku LLC (Япон талаас)

### MN002 – Загвар төсөл (бүртгэгдсэн)

“Төв аймгийн Борнуур сумын төвийн дулаан дамжуулах шугамыг өндөр үр ашигтай нам даралтын зуухаар солих” төсөл. Жилд 102 тонн CO<sub>2</sub> дүйцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 39210 Гж дулаан үйлдвэрлэн Борнуур сумын төвийг халуун ус, дулаанаар ажиллаж байна. 2016, 2018 онуудад 315 тонн CO<sub>2</sub>-той дүйцэх хэмжээний ялгарлын баталгаажсан бууралт буюу кредитээ тооцуулсан.



Хэрэгжүүлэгч талууд:

- Ану сервис ХХК (Монгол талаас)
- Suuri Keikaku LLC (Япон талаас)



### MN003 – Загвар төсөл (бүртгэгдсэн)

Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүрэгт хэрэгжиж буй Газар тариалан, сэргээгдэх эрчим хүчний хосолсон “Моннаран 12.7 МВт-ын нарны цахилгаан станц”-ын төсөл. Жилд 12500 тонн CO<sub>2</sub> дүйцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 16 сая кВт/цаг цахилгаан үйлдвэрлэн төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд нийлүүлэн ажиллаж байна. 2018 онд 8880 тонн CO<sub>2</sub>-той дүйцэх хэмжээний ялгарлын баталгаажсан бууралт буюу кредитээ тооцуулсан.



Хэрэгжүүлэгч талууд:

- Эвридэй ферм ХХК, Бридж групп (Монгол талаас)
- Farmdo Co.,Ltd (Япон талаас)

### MN004 - Загвар төсөл (бүртгэгдсэн)

Монгол улсын анхны том хүчин чадалтай Дархан хотод хэрэгжиж байгаа 10 МВт-ын нарны цахилгаан станцийн төсөл. Жилд 12850 тонн CO<sub>2</sub> дүйцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 16 сая кВт/цаг цахилгаан үйлдвэрлэн төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд нийлүүлэн ажиллаж байна. 2017 онд 8947 тонн CO<sub>2</sub>-той дүйцэх хэмжээний ялгарлын баталгаажсан бууралт буюу кредитээ тооцуулсан.



Хэрэгжүүлэгч талууд:

- Солар Повер Интэрнэйшнл ХХК (Монгол талаас)
- Sharp Energy Solutions Corporations (Япон талаас)

### MN005 -Үзүүлэх төсөл (бүртгэгдсэн)

Оюутолгойгоос Цагаан суваргын дэд станцуудыг холбосон 220 кВТ-ын цахилгаан дамжуулах алдагдал бага гаргадаг шугамыг байгуулж, өмнө ашиглагдаж байгаа хуучин шугамтай харьцуулах замаар алдагдлыг бууруулж буй хэмжээг тооцоолон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах төсөл. 2019 онд 1 тонн CO<sub>2</sub>-той дүйцэх хэмжээний ялгарлын баталгаажсан бууралт буюу кредитийг тооцуулсан байна.



Хэрэгжүүлэгч талууд:

- ҮЦДС ТӨХК, МАК корпораци (Монгол талаас)
- Hitachi Ltd (Япон талаас)

### MNXXX – Загвар төсөл (бүртгэгдээгүй)

Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, шинэ нисэх буудлын урд байрлах “Бөхөг 15 МВт-ын нарны цахилгаан станц”-ын төсөл. Жилд 18438 тонн CO<sub>2</sub> дүйцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, 24 сая кВт/цаг цахилгаан үйлдвэрлэн төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд нийлүүлэн ажиллаж байна.



Хэрэгжүүлэгч талууд:

- Тэнүүн гэрэл констракшн ХХК / Монгол талаас/
- Sharp Energy Solutions Corporations /Япон талаас/



### MNXXX – Загвар төсөл (бүртгэгдээгүй)

УБ хотын Баянзүрх дүүрэгт байрлах Эм Си Эс (MCS Coca Cola) компанийн нүүрсэн галлагаатай зуухыг хийн (LPG gas) зуухаар солих төсөл. Урьдчилсан тооцооллоор жилд 5847 тонн CO<sub>2</sub>-ийг бууруулна.



#### Хэрэгжүүлэгч талууд:

- Эм Си Эс Интернэйшнл ХХК/ Эм Си Эс Кока Кола ХХК (Монгол талаас)
- Saisan Co.,Ltd. (Япон талаас)

### MNXXX – Загвар төсөл (бүртгэгдээгүй)

(#50088-002) Азийн хөгжлийн банкны ХКОМ-ыг дэмжих Япон сан (JF JCM)-гаас 6 сая ам. долларын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжих Завхан аймгийн Улиастай хотод баригдах 5 МВт+3.6 МВт/цаг нөөцлүүр бүхий нарны цахилгаан станцын төсөл. Урьдчилсан тооцооллоор жилд 6439 тонн CO<sub>2</sub>, 25 жилд 160975 тонн CO<sub>2</sub>-ийг бууруулна.

#### Хэрэгжүүлэгч талууд:

- Эрчим хүчний яам, Эм Си Эс Интернэйшнл ХХК (Монгол талаас)
- Азийн Хөгжлийн Банк, NGK Insulators Ltd (Япон талаас)

### MNXXX – Загвар төсөл (бүртгэгдээгүй)


(#49173-003) Азийн хөгжлийн банкны ХКОМ-ыг дэмжих Япон сан (JF JCM)-гаас 3.5 сая ам. долларын буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжих Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэгийн өргөтгөлийн халаалт, агааржуулалт, цахилгааныг эрчим хүчний хэмнэлттэй, сэргээгдэх эрчим хүчийг хослуулан цогцоор шийдэх төсөл. Урьдчилсан тооцоогоор жилд 2993 тонн CO<sub>2</sub>, 20 жилд 59860 тонн CO<sub>2</sub>-ийг бууруулна.

#### Хэрэгжүүлэгч талууд:

- Эрүүл мэндийн яам (Монгол талаас)
- Азийн хөгжлийн банк (Япон талаас)




# ХАВСРАЛТ



УЛС ТУС БҮРИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ХКОМ-ЫН ЗАГВАР  
ТӨСЛИЙН ТОО, АШИГЛАЖ БҮЙ ТЕХНОЛОГИЙН АНГИЛАЛ



# ХКОМ-ЫН ЕРӨНХИЙ СХЕМ





Уур Амьсгалын Өөрчлөлтийн  
Судалгаа, Хамтын Ажиллагааны Төв,  
ХКОМ-ын нарийн бичгийн газар,  
Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам

Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Оюутны гудамж  
Маргад төв, 203 тоот  
Улаанбаатар хот-14191, Монгол улс



+ 976 - 70000743



[jcmmongolia@gmail.com](mailto:jcmmongolia@gmail.com)



[www.jcm-mongolia.com](http://www.jcm-mongolia.com)

